

# PLAYBOY

ENTERTAINMENT FOR MEN

MAY/JUNE 2015

## Lingerie Special

Supermodel  
Nomi Ganbold-г  
онцолж байна

ЦУСТ МЭРИ  
ДУРААРАА МАНГАС  
ХОРИОТой ТААШААЛ  
МӨРӨӨДИӨӨ НЭХЭГЧ СЕЛФИЧ  
INTERVIEW: Ц.ЦОГЗОЛМАА  
20 АСУУЛТ: Т.САНЧИР  
THAT 90'S SHOW

10 0007



8 658000 703111

www.playboymongolia.mn



“Эй Ар Би Монголия” ХХК

**4X4 ACCESSORIES**

**Манай бүтээгдэхүүнүүд:**

- ARB урд хойд хамгаалалт
- ARB ачаа
- OLD MAN амортизатор пүрш, втулька резин
- Агаарын хоолой Safari Snorkels
- ARB Татлага, ARB аяны хөлдөөгч,
- ARB хийн компрессор
- IPF гэрэл
- Дотор каркасан бэхэлгээ хамгаалалт
- Соорег дугуй

# ТАНЫ АЯЛАЛЫН НАЙДВАРТАЙ ТҮНШ



Утас: 53002000, 53002001

Вэб хуудас: [www.arbmongolia.mn](http://www.arbmongolia.mn)

Хаяг: СБД, Залуучуудын өргөн чөлөө, Ш/х-646, Улаанбаатар 14201

*Илүү хол явцаар*



# Strike it rich!

Premium tobacco pleasure®



**SURGEON GENERAL'S WARNING:** Smoking By Pregnant Women May Result in Fetal Injury, Premature Birth, And Low Birth Weight.

Visit us at [Newport-pleasure.com](http://Newport-pleasure.com)  
Restricted to Adult Smokers 21 or Older.

Newport® (logo), pleasure®, Newport pleasure®, spinnaker design, Newport Non-Menthol® and package design are trademarks of Lorillard Licensing Company LLC.



# РЕДАКЦ

“Миний тарьсан цэцгүүдийн нэгийг та одоо гартаа барьж сууна . Та одоо үүнийг үнэрлэнэ . Аль нэгэн хуруугаараа ,эсвэл зүрхээрээ зөөлөн зөөлөн имтэрч , илж, бас имэрч үзнэ” яруу найрагч, зохиолч Л.Өлзийтөгсийн энэ мөртэй хамт таньд “PLAYBOY MONGOLIA” сэтгүүлийн 2015 оны нэгэн шинэ дугаараа таны өмнө тавьж байна.



Манай сэтгүүлийн энэ дугаараас “20 асуулт” буланд 2014 оны шилдэг тамирчдын нэг, сагсан бөмбөгийн үндэсний шигшээ багийн гишүүн Т.Санчир уригдан оролцлоо. Үүнээс гадна Майкл Жордан, Чарльз Барклей, Скоти Пиппен зэрэг 1990 оны америкийн сагсан бөмбөгийн домог болсон тамирчдын түүхэн амжилтын талаарх тойм хүүрнэл, Америкт хувь хүмүүс компани байгуулан сансар судлалд хэрхэн оролцож байгаа тухай дэлгэрэнгүй сурвалжлагад аливаа хүн зорилготой, мэдлэг боловсрол, авьяас чадвартай бол юуг ч бүтээж, ямар ч оргилд гарч чадах боломжтой талаар өгүүлжээ.



Холливүүдийн нэрт жүжигчин, продюсер Жон Малкович, гитарчин, дуучин Ленни Кравиц нар алдар хүнд, хөгшрөлтийн талаар ямар бодолтой байдаг бол? Тэдэнтэй хийсэн шилдэг ярилцлагуудыг анхаарал талбин уншина уу.



Загварын чиг хандлага, гоо сайхан, эрүүл аж төрөх ёс, зугаа цэнгэл-плейбой ертөнцийн чимээ анир гээд амралт чөлөөт цагт зориулсан олон шинэ мэдээ, мэдээлэл байлгүй яахав.



2015 оны шинэ дугаарын плеймейт бүсгүй Ганболдын Номин-г танилцуулж байна. Энэ удаагийн playmate бүсгүй маань “зорилгоо биелүүлэхийн тулд нэг алхахад түүний хүсэл мөрөөдөл өөдөөс нь нэг алхдаг” хэмээн урам зоригтой сурч боловсорч яваа нэгэн.



Секс, гэр бүлийн харьцаа, эрчүүдийн сонирхол, хоржоонтой шоглол бас нүд салгамгүй гэрэл зураг энэ чинь л PLAYBOY шүү дээ . . .





**WHAT TO DRINK.  
WHAT TO WEAR.  
WHERE TO GO.**



*(and where to find a  
Playmate or two.)*

**THE NEW PLAYBOY FOR iPhone APP**



Ерөнхий редактор: **Н.БОЛОРМАА** / Editor-in-Chief **N.BOLORMAA**

Захирал: Б.Шинэбилэг  
Хариуцлагатай редактор: Ш.Төмөрбаатар  
Гэрэл зурагчин: Н.Галбадрал  
Брэнд дизайнер: Н.Тулга  
Сэтгүүлч: Ж.Лхамаа  
Маркетингийн менежер: Ц.Үүрсайхан  
Борлуулалтын менежер: Н.Шижирбаатар Ц.Үүрсайхан  
Хуулийн зөвлөх: Д. Алтайсайхан  
Нарийн бичиг: Ч.Болормаа  
Орчуулагч: Б.Мөнхтуяа

**ДУГААРЫГ БЭЛТГЭХЭД АЖИЛЛАСАН :**

Жош Райн,  
Тод Паркер, Рилан Перри,  
Дэвид Беллемер, Мэттью Полли , Д.Золбоо  
Глюкит, Б.Алтайсайхан, Г.Гэрэлцэцэг, Д.Түвшинбаяр,  
Т.Отгонтөгс, О.Одонболд  
Стефен Ребелло, Грег Фэган, Роб Танненбаум, Жоа  
Педро Жорж

PLAYBOY ENTERPRISES, INTERNATIONAL  
Hugh M. Hefner Editor-in-Chief

U.S. PLAYBOY  
Scott Flanders, Chief Executive Officer David Israel, Chief Operating Officer  
Jimmy Jellinek, Editorial Director Mac Lewis, Art Director Rebecca Black,  
**Photo Director**

PLAYBOY INTERNATIONAL PUBLISHING  
Mike Violano, SVP/Content Rights & Licensing Mary Nastos, Publishing Services Manager Gabriela Cifuentes, Digital Asset Manager Lacey Won,  
Editorial Coordinator

Playboy барааны нэр болон тэмдэг нь "Playboy Enterprises International Inc" -ын өмч мөн. Playboy Mongolia сэтгүүл Хууль зүйн яамны 000018871 тоот гэрчилгээ бүхий хэвлэн нийтлэх эрхтэй. Playboy Mongolia сэтгүүл нь мэдээлэл өгөх, реклам цацах зориулалттай. Зар сурталчилгааны эх сурвалжийг зарлуулсан байгууллага хариуцах ба Playboy Mongolia хариуцлага хүлээхгүй. Редакцийн үзэл бодол зохиогчийн үзэл бодолтой заавал нийлэх албагүй. Playboy Mongolia- н эрх Playboy Enterprises International Inc -д харьяалагдана. Тус сэтгүүлд хэвлэгдсэн материалыг редакцийн зөвшөөрлийн дагуу олгоно.

**СЭТГҮҮЛ БОРЛУУЛАХ ЦЭГ:**

- Номин их дэлгүүрийн бүх салбар
  - Smart худалдааны төв
  - Оргил супермаркет
  - Good price дэлгүүр
  - Номын дэлгүүрүүд
- Сарнайх супер маркет
  - Ханбүргэдэй
  - HOME PLAZA

**Хэвлэл захиалах индекс**

- Монгол шуудан - 253316
- Улаанбаатар шуудан - 2001188
- Түгээмэл шуудан - 111199
- The Morning post




# PLAYMATE

PLAYBOY СЭТГ ЛДУГААРЬ РТЭЭСАЙХАН  
Б СГ ЙГ (PLAYMATE) ТАНИЛЦУУЛДАГ  
УЛАМЖЛАЛТАЙ.САРЬ РСАЙХАНБ СГ ЙГ  
ТОДРУУЛАН МЭРГЭЖЛИЙН Т ВШНИЙ  
ЗУРАГ АВАЛТАНД ОРУУЛЖ, СЭТГ ЛИЙН  
Н Р,БУСАДХУУДАСТЗУРГИЙГТАВИХААС  
ГАДНА ТУХАЙН ОНЫ Т ГСГ ЛД БОЛОХ  
“PLAYMATE OF THE YEAR” БУЮУ ОНЫ  
PLAYMATEТОДРУУЛАХШАЛГАРУУЛАЛТАНД  
ОРОЛЦОХ ЭРХТЭЙ БОЛНО.

Бидэнтэй холбогдох утас  
70135868 91030902 96667757





# BOOK A PLAYMATE FOR YOUR NEXT EVENT

CORPORATE EVENTS  
TRADE SHOWS  
PRODUCT CAMPAIGNS  
NIGHT CLUB APPEARANCES  
SPORTING EVENTS  
FEATURE FILM & TV  
ADVERTISER VIDEO & PRINT  
FASHION FOR EDITORIAL


[PLAYMATEPROMOTIONS.COM](http://PLAYMATEPROMOTIONS.COM)





### ТОНИ КЕЛЛИГИЙН ТОМЧУУДЫН ТОГЛООМ

Алдарт гэрэл зурагчин Тони Келли томчуудын тоглоомын ертөнцөд шинэ санаа гаргаад байна. Тэрээр дөрвөн жилийн өмнө хуванцар тоглоомнууд ба үзэсгэлэнт эмэгтэйчүүдийг зургийг нь авч, Playboy сэтгүүлд нийтэлж байсан билээ. Ноён Келли 96 хуудас “тоглоом ба бүсгүй” цуглуулгаа одоо ч арвижуулсаар байна. “Энэ бол эрчүүдийн санаа бодлын талаарх нийгмийн сэтгэгдэл юм” хэмээн Келли тайлбарлаж байна. Том биетэй булчинлаг супер баатрууд, жижиг өхөөрдөм тоглоомон эрчүүд эмэгтэйчүүдийн сонирхлыг их татах нь мэдээж шүү дээ. Хамгийн том гоо зүй, секс сэтгүүл Playboy-н үзэсгэлэнт playmate-үүд бол Келлигийн уран бүтээлийн анхаарлын цэг юм. Түүний өөрөө эхийг нь бэлтгэж, гараар үдэж хавтасласан фото зургийн шинэ цомог бэлэн болоод байгаа бөгөөд тун цөөхөн хувиар хэвлэгджээ. “Энэ бол ном биш, энэ бол туршлага юм” хэмээн Тони Келли онцлов.



### БАНИИ ТУУЛАЙ ШИГ-ДАВХИ!

Indy Lights-ийн нисгэгч Риан Финнигийн уралдааны машин дээр playboy-н лого, банни туулайг байрлууллаа. Тэрээр үүгээрээ үнэхээр бахархаж байгаа бөгөөд “энэ бол ёстой галзуу санаа” хэмээн ярьсан юм. Хүмүүс түүний машин дээр цуглаж зургаа даруулах нь эрс нэмэгдсэн бөгөөд би урьд нь ийм юм үзээгүй гэж тэрээр нэмж хэллээ. Энэ бол хамтын шийдвэр байсан агаад удахгүй Палм Спрингсийн замд уралдах юм. Финни болон түүний багийнхан Playboy гаражид бэлтгэлээ базаах болно.



### ЖЕНТЛЕМЕНИЙ ХУВЬСАЛ

Күүпер Хефнер өөрөө загварыг нь гаргасан юүдэнтэй цамцаа booster.com –оор зарж эхлээд байна. Тэрээр эндээс олсон орлогоо “Хью-Хефнер” сангийн үйл ажиллагааг дэмжихэд зарцуулах юм. “Би эрэгтэй хүнийг цамцан дээр хүнийг дүрслэхдээ хувьсал өөрчлөлт нь орчин үеийн playboy жентлемен дээр ирээд зогсож байгаагаар үзүүлсэн. Playboy эр хүн, хэний ч хүндэтгэлийг хүлээж, эрх чөлөө, хайр нигүүлслийг эдэлж чаддаг” хэмээн Күүпер онцлон хэлж байна.



### ИРЖ БУЙ ЦАГ

Playboy –н удирдлагад Biofit компаниас захидал ирүүлсэн байна. Ер нь гоо зүй, хүмүүсийн бие бялдрыг хөгжүүлэх тал дээр Biofit – Playboy ижил байр суурьтай байдаг бөгөөд, өнгөрсөн 60 жилд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад илүү анхаарч ажиллаж ирлээ. Энэ бол бидний хувьд том хүндэтгэл бөгөөд цаашид эрүүл чийрэг бие махбод, гоо сайхны төлөөх үйл хэргээ урам зоригтой үргэлжлүүлэх болно хэмээн Playboy –н зохиогчийн эрх хариуцсан ерөнхийлөгч Матт Нордби дээрх захидалтай холбогдуулан өгүүллээ.

## ХЕФИЙН ХАРШИД БОЛСОН НИЖИГНЭЭН

Ер бусын нэгэн хаалттай үдэшлэг Хефнерийн харшид боллоо. Энэ үдэшлэгийг алдарт Кейт Моссын туслалцаатай зохион байгууллаа. Хеф болон түүний хүү Күүпер 2014 оноос хойш өөрсдийн хамгийн дотно найз нөхдөө энэхүү "бут авалт"-д урьсаар иржээ. Үдэшлэгт алдартай плеймэйт бүсгүйчүүд болох Жиа Мэри, Стефани Брэнтон, Маркета Янска, Кимберли Филлипс нар оролцсон байна. Мөн Тодд Морсигийн хамтлаг хүрэлцэн ирж Хефийн харшийг доргиож чадлаа.



## БАНИ ЦУГЛАРАЛТ

"Лос-Анжелас орчмын Хүнсний банк" байгууллагад туулах, дэмжих зорилгоор Холливүүдийн "Lucky Strike" клубт томоохон үдэшлэгт боллоо. Үдэшлэгт арван хэдэн бани бүсгүйчүүд, "Entourage" цувралын гол

дүрд тоглосон Жереми Пайвен оролцов. "Sum 41" хамтлагийн Дерик Вайблигийн галзуу хөгжим үзэсгэлэнт бүсгүйчүүд гэхээр чухам яг ямар үйл явдал болсон нь нүдэнд тань харагдаж байгаа биз.




## БАНИ БЕЙОНСИ

Сайхан, эрч хүчтэйн бэлгэдэл "элчин сайд" гэж яригддаг бани туулайт цамц, хясаан зүүлт алдарт Бейонсигийн "7/11" синглийн нэгэн чимэглэл болж чадлаа. Спорт хэв маягийн энэ цамц Jovrich X Playboy коллекцид багтдаг. Поп хатан хаан Бей бүжигчдийн хамт ёстой үзүүлж гардагийг түүний видеонаос харсан биз дээ. Үнэхээр өөлөх юмгүй.

# МАНСУУРЛЫГ ЭЕРЭГ ТАЛААС НЬ ХАРВАЛ

ЗАЛУУ ГЭРЭЛ ЗУРАГЧДЫН ЭРОТИК АРТ АЖЛУУД НЬ  
ҮНЭХЭЭР СОНИН МЭДРЭМЖ ТӨРҮҮЛЖ БАЙНА



## САРА ЭНН ЖОНСОН /ПИННИБЕРГ МАНИТОБА/

Сара хосууд секс хийж байгааг бодитоор /амьд/ дүрсэлдэг. Түүний бүтээлүүд голдуу хүчлээр түлэгдсэн мэт ажиллагаатай, сексийн дотоод мөн чанарыг гаргахыг хичээдэг нь тод мэдрэгддэг. Энэ бол тухайн үеийн сайхан мэдрэмж нөгөө талаар эрсдэлтэй талыг харуулахыг хичээсэн. Секс хийх хосууд аажуухан хөдлөх, оруулах тэр агшинг. Эдгээр цуврал зураг хүсэл тачаал, тачаангуй байдлыг тийм нэг өвөрмөц бүр гаж гэмээр сэтгэгдэл төрүүлж ч болох юм.



## ШАЕ ДЕТАР /НЬЮ-ЙОРК/


Хөгжим бол миний ямар өнгөөр ажиллахыг залуурдаж зааж өгдөг хэмээн Шае ДеТар гэх бүсгүй ярьж байна. Эхлээд хөгжмөө сонс, дараа нь гэрэл зургийн аппаратаа ав! энэ бол түүний ажлын ёс журам. Улбар шар хөрс шороо, элсэн цав дээр нь нүцгэн биецагаан өнгө. Уйтгар гуниг төрүүлэвч

энэ бол бодит. Би байгаль дэлхий хэрхэн оршдогийг харуулах гэж хичээсэн гэж Шае хэллээ. Тухайн бүтээлийн өнгөсүнс тэр үед чухам яг ямар хөгжим сонсож байсныг харуулж чадна. "За тэгэхээр, би яг одоо шар ба номин өнгөнд умбачлаа" гэсээр залуу бүсгүй хөгжмөө сонслоо.

## ДЭВИС АЕЭР /ЛОС-АНЖЕЛИС/

Би бол оюунлаг эрэлхийлэгч гэж Дэвис өөрийгөө тодорхойлов. Би магадгүй таны хариулж чадахгүй байж болох амьдралын сүнслэг, хаос, метафизик олон асуултын хариуг гэрэл зургаараа харуулахыг зорьдог. Юу гэмээр юм дээ,

нэг тийм зүүд зөн билгийн гэх юм уу гэж хэлэнгүүтээ зургаа үргэлжлүүллээ. Тэр зураг нь цээж нүцгэн залуу бүсгүй. Нүцгэн байгаа нь илүү их чөлөөтэй, хэв маягт автаагүй байгааг илтгэнэ. Бас бага зэрэг мансуурлыг мэдэрч болох юм.





# ХОРИОТОЙ ТААШААЛ

Америкчуудын хайртай технологийн компани нөхөн үржихүйн хичээлд F дүн авч байна.

**24** настай Тина Гонг өөрийн бүтээсэн iPhone утасны аппликэйшн болох "HarryPlayTime"-аа iTunes-ээс зөвшөөрөл авах гээд өргөдөл өгөхдөө бүтэхгүй гэдгийг гадарлаж байлаа. "Apple-ын зөвшөөрөл олгох процесс нь хэр хэцүү байдгийг мэдэхгүй байна, гэхдээ миний хийсэн 'HarryPlayTime' нөхөн үржихүйн эрүүл мэндийн тухай болохоор би зөвшөөрөл авах байх гэж бодож байсан" гэж хэлэв. Гонгын аппликэйшнд эмэгтэй хүний бэлэг эрхтэн гардаг бөгөөд дэлгэц дээрээс нь баруун зүүн тийшээ 'swipe' / хоёр хажуу тийш гүйлгэх/ хийж болдог байна. Эмэгтэй хүний бэлэг эрхтэн "маш аз жаргалтай" болсноор энэ тоглоомонд хождог байна. Өөрөөр хэлбэл гар хангалга хийж байгаа мэт хөдөлгөөнөөр таашаал өгдөг юм байна. Энэ аппликэйшн нь эмэгтэй хүний анатомийг бас заадаг юм байна. Үүгээр дамжуулан эмэгтэй хүний анатоми болон дур ханалтын талаар хэрэглэгчдээ зааж өгөх

зорилготой юм. "Гар хангалга бол бэлгийн ажлын анхан шат шүү дээ" гэж тэрээр нэмж хэлэв.

Apple түүний аппликэйшныг хэт ёс зүйгүй гээд олон нийтэд түгээх зөвшөөрлийг олгоогүй учир маргаан үүсчээ. Гонг тэдний хэлснийг сонсон татаж авч болох насыг 17 болгосон ч гэлээ нөлөө үзүүлээгүй байна. "Тэд порно шиг гэж тайлбар өгөөд миний өргөдлийг буцаасан. Гэхдээ энэ аппликэйшнд ямарч порнографик зүйл болдоггүй. Зүгээр л зураг тэгээд дагалдах тайлбар нь байдаг" гэв.

Apple компанийн шалгалтын процесс нь үнэхээр хатуу, маш их бичиг баримт, олон шатны шалгалт шаарддаг. Шат дараалсан шалгалтын дараа зөвшөөрөл олгох эсэхээ шийддэг. Утга агуулгынх нь тайлбар хэтэрхий ерөнхий. Уг компанийнхан хэлэхдээ "Бид шугамнаас хэтэрсэн агуулгатай аппликэйшныг олон нийтэд биднээр дамжуулан хүргэхийг зөвшөөрдөггүй". Тэр нь ямар агуулгын тухай ярьж байгаа юм бол? Дээд шүүхийн нэгэн шүүгчийн тайлбарлаж байснаар "Би шугамнаас хэтэрсэн

агуулгыг хараад л мэднэ” гэдэг шиг л юм болж байна. Тэр шугам нь тодорхой бус, бас туйлын үнэн биш. Apple-аас зөвшөөрсөн аппликэйшнуудыг харъя: “Tip-der” гээд болзооны, “Hot Tips” гэдэг шөнийн жаргалын, iKamasutra гээд сексийн явцаа бичлэг хийх зориулалттай гэх мэт. Тэгэхээр яагаад “өөрийгөө жаргаахад” зориулсан аппликэйшнд зөвшөөрөл өгөөгүй юм болоо?

“Секс гэхээр хүмүүс ёс суртахуунгүй, балиар заваан юм гэж боддог” гэж Емили Нагоский тайлбарлав. Емили бол Смит Их сургуулийн профессор бөгөөд “Эмэгтэйчүүдийн таашаал авах зөв алхмууд” гэсэн ном бичсэн. “Apple компани секстэй холбоотой зүйлийг таашаал авахыг өдөөн хатгахтай хольж хутгаад байна. Энэ хоёр чинь адил зүйл биш шүү дээ” гээд иймэрхүү шалтгаанаас болоод өнөө цагт секс болон технологийн төгс хослолыг гаргаж ирж чадахгүй байгаа. Apple компани оюунлаг сонголт биш харин ёс суртахууны сонголт хийгээд байна. Тиймээс ч Гонгын шиг шилдэг санаа-эмэгтэй хүний таашаалд хандах нийгмийн буруу хандлагыг алга болгох зорилготой шинэчлэлүүд үл тоогдсоор байна. Хүмүүс нөхөн үржихүйн талаар мэдлэгтэй болох боломжийг нь олгох хэрэгтэй” гэж Емили тайлбарлав.

“Технологиос өөр хүн бүрт хүртээмжтэй хүрэх суваг байгаа юу?” Судлаачид нөхөн үржихүйн боловсрол хувь хүний сексийн амьдралыг сайжруулдаг гэдгийг мэдэхийн дээдээр мэддэг. Нөхөн үржихүйн анагаахын сэтүүлд мэдээлснээр нийт судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 90 хувь нь гар хангалгын талаарх сургалтад суусны дараа дур тавьж сурдаг байна. Жилийн эцсийн судалгааны тайланд сексийн боловсролын тухай ном унших нь сэтгэл зүйч дээр очихоос илүү үр дүнтэй гэж онцолжээ. “Боловсрол нөлөөтэй” гэж Нагоский хэлээд “энэ мэдээллийг ямар сувгаас авах нь чухал бус” гэж тайлбарлав.

Том Чен гэх “Linkcube” секс тоглоом үйлдвэрлэг компанийн эзэн дижитал нөхөн үржихүйн боловсролыг нэг шатаар ахиулж, “smart” буюу “ухаалаг” тоглоом үйлдвэрлэх санаатай байгаа гэнэ. Жишээлбэл, “Skea” гэдэг тоглоом эмэгтэй хүний үтрэний булчинг хөгжүүлэх зориулалттайгаар хийгдсэн байна. Уг тоглоом нь “Alice in Continent” гэдэг тоглоом дээр үндэслэсэн юм байна. Эмэгтэй хүмүүс “Skea” тоглоомыг пэлвик булчингаараа чангалж, суллаж Алиса гэх гол дүрээ дээш үсэргэж, гүйлгэх хөдөлгөөн хийдэг байна. Энэ маягаар эмэгтэй хүмүүс пэлвик булчингаа хөгжүүлж улмаар бэлгийн таашаал авах нь сайжирдаг байна. Чен хэлэхдээ энэ утасны тоглоом их өндөр хүлээлттэй байгаа тул дараа жил худалдаанд гарахад их олон хүнд хүрнэ гэсэн магадлалтай. Уг тоглоом Apple компаниас зөвшөөрөл авна гэдэгт тэрээр итгэлтэй байгаа, яагаад гэвэл тоглоомоо зугаа цэнгэлийн төрөлд оруулахгүй харин анагаах/шинжлэх ухааны төрөлд бүртгүүлэх юм байна.

Түүний зөв буруу нь хамаагүй, хамгийн гол нь нөхөн үржихүйн талаарх боловсрол түгээхийг хүссэн мэргэжилтнүүд зорилгоо шинэ технологи ашиглан биелүүлэх өндөр эрмэлзэлтэй байгаа. “Хэрэггүй дүрэм хүмүүст сайн зүйл хийхэд саад болж байгаа нь харамсалтай. Бид орчин үеийн технологи ашиглан эрүүл байдлыг дэмжих хэрэгтэй. Өнөө цагт энэ талаар ярьж байгаа нь бас ахицтай бөлгөө” гэж Нагоский хэлэв.

Шайн Майкел Синг



## HARD CORE

Apple нөхөн үржихүйн талаар мэдээлэл түгээх хүсэлтэй хүмүүст маш олон хатуу хүтүү дүрэм, шаардлага тавьдаг.



**ХОРИОТ**



**Geometric Porn -Геометрын порн (Англи)**

Лучиано Фоглиа гэх уран бүтээлчийн зохион бүтээсэн “Геометрын порн” нь сексийн үйл ажиллагааг геометрын дүрсээр үзүүлдэг аппликашин. Фоглиа аппликэйшнаа садар самуун сурталчдадгүй, зүгээр л хүний хийдэг зүйлийг элдэв дүрс ашиглан үзүүлдэг гэж хэлэхэд, Apple санаа нийлсэнгүй. Тэд агуулгыг нь хэт “балиар” гэж үзсэн байна.



**ХОРИОГҮЙ**



**Luxuria Superbia -Супер Люкс (Бельги)**

Уг тоглоомын дэлгэцэг зөөлөн, хатуу, хурдан илдэг байна. Болоод ирэхээрээ “Одоо хий!” гэсэн заавар авангуут шууд “хийдэг” гэнэ.



**Sex Criminals- Секс гэмт хэрэгтэн (Америк)**

Матт Фракшны /Matt Fraction/ зохиосон комик ном бөгөөд Comixology утасны аппликэйшн дээр зарагдахыг Apple хориглосон байна.



**Passion-Тачаал (Америк)**

Энэ нь iPhone утасны микрофон болон хөдөлгөөн мэдрэгчийг ашиглан сексийн дуу болон хөдөлгөөнийг мэдэрч хариу мэдээлэл хэрэглэлчид өгдөг байна. Таны хариуг бусад найзуудын тань хариутай харьцуулдаг байна.



**HappyPlayTime- Аз жаргалын тоглоом (Америк)**

Тина Гонгын аппликэйшн нь эмэгтэй хүний бэлэг эрхтэнг зургаар дүрслэж мөн түүнд “зөв” хүрч улмаар таашаал өгч байж ялдаг тоглоом.



**iKamasutra (Швед)**

Энэ аппликэйшиныг App Store-оос ямар ч асуудалгүй татаж авч болно. Уг тоглоомд 100 гаруй сексийн арга барил, байрлалыг зурагтай нь тайлбарлан үзүүлсэн байдаг. Уян налархай байдлаа хянах үзүүлэлт бас байна.

# БЕНЖАМИН БҮҮКЕР

НЬЮ-ОРЛЕАНЫ ГИТАРЧИН ЗАЛУУ ПАНК & БЛЮЗ  
ДУУГААР ОНЫ ШИЛДЭГ ДЕБЮТИЙН НЭГ БОЛЛОО

Хорин таван настай Бенжамин Бүүкер хөгжмийн дэлгүүрт ажилладаг. Найзууд нь Старбакст түүний дууг гэнэт сонссоноо мессежээр хэлсэн байна. Бид мэдээллийн эрин үед амьдарч байгаа ч Бүүкерийн хүрсэн амжилтын талаар ямар нэг зүйлийг хараахан сонсож амжаагүй байж болно шүү дээ. Магадгүй бид Бүүкерийн доорх ярилцлагаас түүний орчин үеийн дуу хөгжмийн тухай ертөнцийг нээн харж болох юм.

**PLAYBOY:** Чиний зохиосон хөгжим маш их нийлмэл, олон төрөл, урсгалыг багтаасан байдаг. Хөгжим зохиох үедээ санаатайгаар ийм туршилт хийдэг үү?

**БҮҮКЕР:** Тиймээ. Би нэг жил гитар тоглосон. Энэ хугацаанд би яг юу, ямар урсгалын хөгжим зохиох талаараа үнэхээр мэдэхгүй байсан. Харин нэг өдөр яагаад ч юм бэ ийм нэг зүйл миний толгойд орж ирсэн л дээ. Би яг бичих ёстойгоо дотроо сонсож, маш хурдан хөгжмөө зохиосон. Энэ үеэс ардын уламжлалт, панк, блюз болон шашны хөгжмийн хэсгүүдийг найруулан ая зохиож эхэлсэн.

**PLAYBOY:** Анхны шоу концерт ямар болсон бэ?

**БҮҮКЕР:** 2012 онд Нью-Орлеаны "Allways Lounge"-д анхны концертоо хийсэн. Би акустик гитартай, цөөхүүл хөгжмийн хамтлагтай тоглосон. Маш их айж сандарч

байсан ч анхны гэдэг утгаараа сайхан болсон. Тайзан дээр гартал арав гаруй л хүн харагдсан. Төд удалгүй 80 орчим хүн цугласан байх шүү. /инээв/ Тэр үед 4-5 дуу дуулаад хөшигний ар лүү гүйж орсон.

**PLAYBOY:** Ковер дуу дуулж байв уу?

**БҮҮКЕР:** Жек Уайттай аялан тоглолт хийх үеэр тайзны ард түүнтэй Жек Еллиотын нэг дууг ковер хийж дуулах талаар ярилцсан юм. "Falling down Blues" гэсэн дууг тэр урьд нь сонсоогүй байсан л даа. Энэ дууг сонсоод тэрээр аялан тоглолтын турш дуулахыг зөвшөөрсөн юм.

**PLAYBOY:** Тэгэхээр Жек Уайтыг блюз дуугаар уруу татжээ?

**БҮҮКЕР:** /инээв/ Энэ талаар яг юу гэхээ мэдэхгүй байна. Хамтлаг энэ дууг тоглох их дуртай байсан. Харин Жек сонсоод юу бодож байсныг хэлж мэдэхгүй байна.



# МӨРӨӨДЛӨВ НЭХЭГЧ-СЕЛФИЧ


Брүүклин дэх нэгэн зураач хуучин арга технологиор орчин үеийн эмэгтэйчүүдийн дүр төрхийг урлаж, алдаршиж байна



Брүүклинд байх Эрин М.Райлейн урлангийн хана бүхэлдээ хагас нүцгэн бүсгүйчүүдийн зургаар чимэглэгджээ. Эдгээр зураг бол гараар нэхсэн бага гэхээргүй хэмжээтэй хивсэнцэр юм. Райлей хаа сайгүй таарах инстграм, твитер гээд нийгмийн сүлжээнд байдаг охид бүсгүйчүүдийн селфи зургийг хивсээр өнгө хослуулан урладаг аж. Селфи зураг өнөөдрийн нийгэмд хамгийн хүчтэй дэлгэрсэн өөрийгөө нээх, бусдад таниулах нийтлэг арга, соёл мөн боловч өөрийгөө дөвийлгөх дуртай "өвчтэй хүмүүсийн" хэрэг мөн хэмээн шүүмжлэлд байнга өртдөг. Хэдий тийм ч Райлейн хувьд селфичдийг хивсээр урлах тал дээр нэгэнт амжилт олжээ. "Сельфи зураг байнга авдаг халуухан, тачаангүй бүсгүйчүүд өөртөө итгэлтэй, сэтгэл хангалуун хүмүүс байдаг. Нэг

талаараа хөгжилтэй ч дараа нь бусдаас ирэх шүүмжлэл, бараг доромжлолд бухимдах нь олонтаа. Селфи зургаа дэлгэсний дараа хүн хоорондын харилцаа хэрхэн өрнөх вэ? " хэмээн Райлей асууж байлаа. Түүний нэхмэл тус бүр өнгө хосолсон секси харагдах ч мэдээжээр тухайн дүрийг хэн гэдэг нь танигдахгүй бүдгэрүүлсэн байдаг. Райлей заримдаа уран бүтээлийнхээ дүр төрх, ааш аягийг илүү тод гаргахын тулд өөрийн селфиг ч ашигладаг нь оновчтой санагдсан. Зарим үзэгч түүний урлалын секси хэсгийг хамгийн түрүүнд ажигладаг, хэвлэл мэдээллийнхэн ч хивсэн урлалын технологи, арга барил гэхээсээ илүү залуу бүсгүйчүүдийн хагас нүцгэн байдлыг шүүрч авдагт шүүмжлэнгүй хандаж сууна. "Эрт үед иймэрхүү секси бүтээлүүдийг хэрхэн хүлээж авдаг байсан нь надад сонин бөгөөд хачин санагддаг" хэмээн тэр нэмж хэллээ. Тэрээр 2000 оны үеэс иймэрхүү дижитал зургуудыг анхааран, уран бүтээл болгох

тал дээр ажиллаж эхэлжээ. Фейсбүүкээс өмнө AOL-ын чат болон literotica.com-ын эротик өгүүллэгүүд, жижиг мэдээнд анхаарлаа хандуулж туршлага хуримтлуулдаг байж. "Селфи бол өнөөдрийн цаг үеийн тусгал, рефлекс юм. Энэ бол хүнд заяасан сексийн зөн билгийн үйлдэл, би үүнийг л онлайнаас олж, хивс болгон урладаг" гэж онцоллоо. Райлей өөрийнхөө ажлыг уран бүтээлч эмэгтэй хүний туршилт: ямар ч гэсэн эмэгтэй хүний сексийн дур хүслийг буруушаадаг үзлийн эсрэг үйлдэл хэмээн тайлбарладаг. Райлей уламжлалт давхар суурьтай хивсний гар машин ашигладаг бөгөөд урландаа ноосоо гараараа ээрч, будганд оруулдаг. Тэрээр бүхий л анхаарлаа нэхэж буй хивсэндээ хандуулж нэлээн сууснаа селфи зургаа харж ажлаа хэсэг завсарлалаа. Ер нь нэг бүтээлдээ маш их цаг зарцуулдаг агаад бүтээж буй эмэгтэй бүрээсээ хайр энэрэл, дэмжлэг мэдэрдэг гэж нэхэх зуураа нухацтай хэлэв.



## ШАР АЙРАГ ГАЗАР ДООГУУР

Бельги шар айраг үнэхээр тасархай л даа. Гэхдээ замын хөдөлгөөнд саад түгжрээ үүсгэдэг. Энэ бол үнэхээр амьдрал дээр ч бодитой явдал байсан юм. Бельгийн Брюжес хотоос 2 миль /3.21km/ газар доогуур хоолойг эртний түүхт Де Алве Маан хүртэл татсан байна. Өмнө нь энэ хоолойг байгуулахаас өмнө өдөрт 500 удаа машинаар нааш цааш шар айраг зөөж, замын хөдөлгөөнд хүндрэл үүсгэдэг байжээ. Одоо бол тэр байдал түүх болж, хуванцар хоолойгоор цагт 1500 галлон /5.6 тн/ шар айраг шинээрээ хэрэглэгчиддээ хүрдэг боллоо.



# НАЧО МАЧО

Шилдэг тогоочийн тогоо шанаганы тоглоом ... Нугасны өөх тос

Өөрийн гэсэн арга барил, уламжлалт сонгодог маягаар хоол хийдэг тогоочоор мексик үндэсний начо хийх талаар зөвлөгөө өгүүлж байна. Шинэ амт шинэ мэдрэмж- бидний бай бол начо. Бид Эдуарда Руйзтай уулзлаа. Тэрээр Калифорнийн "Коразони Миел" хэмээх латин Америк ресторанд ажилладаг бөгөөд тэрээр франц маягаар нөөшилсөн нугасны тосоор эрчүүдийн сонгох дуртай хоолыг хэрхэн хийх талаар бидэнд үзүүлсэн юм.

## Орц найрлага:

- 3 ширхэг улаан лооль /дөрвөн хэсэг хуваана/
- 1 ширхэг сонгино /дөрвөн хэсэг хуваана/
- 2 ширхэг сармис
- 3 улаан & ногоон чинжүү /голоор нь хуваасан/
- 2 ширхэг хатаасан гуахилло чинжүү
- Нугасны цээж 2 ширхэг
- 1 хоолны халбага давс
- Нэг лааз вандуй
- Нэг сав тортилла чийпс
- 220 грамм бяслаг /үрүүлээр үрсэн/

1. Шарах шүүгээг 500 хэм халаана. Лооль, хэмх, сонгино, сармис, улаан ногоон чинжүүг тусгай саванд хийж, ногоог далд ортол чидун жимсний тос дүүргэнэ. Савтай ногоогоо шарах шүүгээнд 15 минут орчим, шаргал болтол нь байлгана.
2. Гуажилло болон арболо чинжүү арилгаад халуун усанд 10 минут сайн буцалгана.
3. Нугасны цээж махаа авч хальсал, хурц хутгаар махаа солбицуулан өнгөц зүснэ.
4. Хайруулын тавгаа халааж цайны халбагаар нэг удаа чидун жимсний тос хийнэ. Эхлээд махныхаа хальсалсан хэсгээр нь тавган дээрээ тавьж, ойролцоогоор 12 минут борлотол шараарай. Дараа нь эргэн тойрон шарна.
5. Шарах шүүгээнээс ногоогоо авч, сайтар шарсан чинжүүтэйгээ бүлээн усанд хутгаж салса бэлтгэнэ.
6. Дээр нь хайруулын тавган дээр нугасны тосонд нөөшилсөн вандуй, дээр нь мөн нугасны цээж махаа хийнэ. Вандуй зөөлөртөл багахан галаар болгоорой.

Бэлэн болсон хоолон дээрээ бяслагаа үрнэ. Шарах шүүгээг 450 хэм халааж савтай хоолоо 5 минут орчим байлгана. Бяслаг бүрэн хайлсны дараа та гаргаж рэдис, үрлэн улаан лооль зэргээ нэмж таваглаарай.







[www.playboymongolia.mn](http://www.playboymongolia.mn)

**YOU ARE WELCOME**

# ЦУСТ МЭРИ

Bloody Mary коктейл дэлхийн хамгийн алдартай, түгээмэл коктейл. Энэ коктейлийн гарал үүслийн хувьд 1921 онд Нью-Йоркийн нэгэн баарны эзэн Фернанд Петиот анх хийсэн гэдэг. Фернанд Петиот хожим "Harry's New York Bar"-ыг ажиллуулж байжээ. Энэ баар олон коктейлыг гаргасан юм. Заримаас нь дурдвал: White Lady (1919), Bloody Mary (1921), Harry's Pick Me Up (1923), Side Car (1931), Blue Lagoon (1960), James Bond (1963) зэргээрээ алдартай билээ.

Нобелийн шагналт зохиолч-сэтгүүлч Эрнст Хэмингуэй "цуст мэри"-д туйлын дуртай нэгэн байсан агаад, өглөө бүр энэ баараар үйлчлүүлдэг байжээ.

Коктейлын нэрний хувьд Английн Хатан хаан I Мэри Теодортой / цуст Мэри/ холбон тайлбарладаг. Мөн тухайн үеийн холливүүдийн жүжигчин Мэри Пикфордтой ч холбоно. Өөр нэг яриа байдаг нь Чикаго хотын "Bucket of Blood" баарны зөөгч эмэгтэй Мэригийн нэр хэмээн үздэг байна. Гэхдээ ямар ч гэсэн уг коктейлын нэр цусан улаан өнгөтэй нь холбоотой.

"Цуст Мэри" Олон улсын Барменуудын холбооны албан ёсны бүртгэлд орсон коктейл юм.

## Орц:

- Хоёр ширхэг шоо мөс
- Хоёр хундага цагаан архи - 45 мл
- 90 мл улаан лоолийн шүүс
- 15 мл лимоны шүүс
- 6 дусал ворчестер / вустер/ сүмс
- 3 дусал Табаско
- Чимх давс & хар перец

## Бэлтгэх дараалал:


- Юуны өмнө бэлтгэсэн шилэн аяганыхаа амсрыг лимоноор арчиж үр
- Дараа нь тавганд асгасан далайн давсанд шилэн аяганыхаа амсрыг дүрнэ /аяганы амсарт давс наалдуулна/
- Шейкэнд цагаан архи, лоолийн шүүс, табаско, сүмс, давс, хар перецээ жорын дагуу хийж сэгсэр
- Сайтар сэгсэрсний дараа аягандаа эхлээд мөсөө хийж, коктейлээ нэмээрэй
- Ингээд "Bloody Mary" бэлэн болно. Коктейл дээрээ ганц хоёр цоохор майлз /celery/ хийвэл улам янзтай



**THE**  
**VODKA**  
**THAT**  
**GOES**  
**WITH**  
**BLACK**  
**TIE OR**  
**BLACK**  
**T-SHIRT.**

*Stoli.*

**THE**  
**VODKA**



# VIVA VIENNA

За даа, Австрийн нийслэл Вена хот аргагүй сайхан газар

Вена хот аль ч улиралд зочилсон үнэхээр төгс сайхан хот л доо. Эртний уран барилга, дэлгүүр хоршоо, шөнийн клуб, цэцэрлэгт хүрээлэн гээд хотоор зугаалахад танд юу эсийг зөвлөх билээ. Европын олон хотын адил хуучин, шинэ хэмээнргүүд ялгаатай. Дөлгөөн Дунайн эргээр шөнө алхах ямар гээч. Вена хот Австрийн хамгийн том хот бөгөөд 1.7 сая гаруй хүн амтай (дагуул дүүргүүдээ оруулаад 2.5 сая). Хүн амын тоогоор Европын холбоонд аравт ордог хот бөгөөд амьдралын чанар, тав тухаараа хоёрт ордог. Вена хотын төвийг ЮНЕСКО-гийн соёлын өвд бүртгэж авсан гэхээр нэмэлт гоё ганган үг, тайлбар илүүц биз. Ер нь европ төдийгүй дэлхийн хамгийн эртний хотын нэг юм. Эртний кельт, ром, дундад зуун, барокко стилийн уран барилгаар дүүрэн. Нью-Йорк, Женев шиг олон улсын байгууллага төвлөрсөн гуравдахь хот билээ.

1

Агуу Моцартын төрсөн эх орон, вальс, дуурь, симфони гэвэл Вена хотын нэрийн хуудас шүү дээ. Хотын аяллаа Хелденглацаас эхлэхийг зөвлөө. Энэхүү орчмыг монголоор Баатруудын талбай гэж орчуулж болно. XIX зуунд бүтээн босгосон гайхамшигт уран барилгын цогцолборт Австрийн төдийгүй дэлхийн улс төрийн томоохон үйл явдал болж байжээ. 1938 онд Адольф Гитлер Австрийг эзлэн авсан тухай алдарт илтгэлээ эндээс тавьж байжээ.

2

Вена хотын аквариумын түүх их сонирхолтой. Дэлхийн хоёрдугаар дайны



нь 2,5 сая ширхэг гэрлэн чимэглэлээр чимдэг. Хамгийн гол зах Шпителберг /музейн хорооллоос холгүй/ юм. Энэ орчим гот маягийн уран барилга, сүм хийдийн цогцолбор бөгөөд 98 фийт /30 метр/ өндөр сүрлэг гацуур мод таныг угтах вий. Энд австри үндэсний хоол унд, гар урлалын зүйлийг худалдан авч болно. Мөн вальс, эсвэл рок поп, диско бүжиглэх олон арван газар бий. Шөнө дунд гэгээн Стефений сүмийн хонх хэдэнтээ дуугарахад асар олон хүн нэгэн зэрэг вальс бүжиглэж эхлэнэ дээ. Бүжиглэж болсон бол зэргэлдээхэн нь байх бохем дүүргээр орж олон арван эртний кафе, ресторанд тухлаарай.

5

Сайхан халуун дарс, зайдас идэж гэдэс гарч, бүжиг хийж алжаасан бол хоногийн хэзээ ч таныг хүлээн авч үйлчлэх зочид буудал Музейн хорооллоор дүүрэн. Энэ орчмын буудлууд эртний барилгатайгаараа онцлог. Унтахын өмнө та цонхоороо нэг хараарай. Дунай мөрний эрэг дээрх үзэсгэлэнт хотод хөл хөдөлгөөн үргэлжилсэн хэвээр л байна даа.

үед агаарын довтолгооноос хамгаалах цамхгийг /Haus des Meeres (HdM, English: House of the Sea)/ орчин цагийн уран барилгын жишгээр засаж янзлан тохижуулжээ. Өдгөө энд 300 тонн усан санд далайн элдэв амьтан ургамлыг үзүүлэн болгожээ. Энд та гэр бүлийн хамт усанд сэлж ч болно. Мөн гадна ханыг уулчдад зориулан хад асга шиг засч янзалжээ.

3

Музейн бүх л бүтэн дүүргээр ороод гараарай. Эндээс Леополдын музейг үзэхийг зөвлөө. Энэ музейн түүх Рудолф ба Элизабет Леополдын цуглуулгаас эхтэй. Одоо энэ музейг Австрийн төр засгаас тусгайлан анхаарч олон давхар барилга бүхий орчин үеийн урлаг, уран зургийн арвин цуглуулгатай болгожээ. Ер нь 7 дугаар дүүрэг буюу Нойбау /Neubau/ орчмоор алхах нь өөрөө маш сайхан амралт болдог.

4

Зул сарын баярын үеэр /өвөл/ Вена хот гэрлэн чимэглэлээ асааж улам үзэсгэлэнтэй сайхан болдог. Баярын үеэр жижиг захууд олноор нээгдэж, орчмыг





# INNOVATION DOESN'T REST.

ENGINEERED WITH PATENTED X-STATIC® XT2™ TECHNOLOGY WHICH BLENDS SILVER PARTICLES WITH PIMA COTTON FOR THE MOST LUXURIOUS + ANTI-MICROBIAL PERFORMANCE UNDERWEAR.



SILVER  
BY MACK WELDON

# DODGE ДУРААРАА МАНГАС

Супер хүчтэй авто хүлэг хурд хүчээ гайхуулан айсуй

Бүхий л эрчүүд эрч хүчтэй, бярамагдсан тоглоом хайж байдаг. Энэ хүслээсээ болоод асуудалд өртөх нь олон. Ийм дур хүслийг хангагч бол "зэвүүн мангас" 707 морины хүч чадалтай Dodge Challenger Hellcat SRT юм. 2015 онд гарах цусан улаан өнгөтэй Hellcat-ийг та харангуутаа ухаан зулаггүй давхих, хаазаа тултал гишгэх хүсэл төрөх вий. Гэхдээ энэ үед та өмгөөлөгчийнхөө утасны дугаарыг биедээ авч яваарай. Жолоочийн ар талаас тухтайхан

тулах, бор шаргал өнгийн арьсан суудал дээр суумагц 6,2 литрийн V8 хөдөлгүүр 3,5 секундын дараа дээд хурдаа авах болно. Хурдны 8 түвшний автомат араатай, 8 инчийн жолоочийн хянах, дээр нь мэдрэг дэлгэц бүхий олон функцийн хянах самбар байрлуулжээ. Хар хурдаараа давхих үеэрээ энэхүү төхөөрөмжөөр та мэдрэмжээ сэргээн галзуу хөгжим сонс. Dodge Hellcat-ыг тухайн замын нөхцөл байдлаасаа шалтгаалан sport, track, street гэсэн гурван төрлийн байдлаар жолоодож болох бөгөөд хөдөлгүүр, явах эд анги, дугуй энэ бүгдэд өөрөө автоматаар тохируулга хийгддэг байна. Энэ бол седан загварын хамгийн хүчтэй, хамгийн хурдан Hellcat!



## ЭДГЭЭР ХҮЛГҮҮД ХЭДЭН ЯНЧААН БЭ?

Доорх хэдэн машины хөдөлгүүрийн хүч чадлыг тооцоолж үзье. Өөрөөр хэлбэл нэг морины хүч хэдэн төгрөг болох бол? Харьцуулцагая.

Porsche 918 Spyder  
Хүчин чадал-887 морины хүч  
Үнэ- 1 592 825 000  
Нэг морины хүч- 1 115 920



Chevy Camaro 1ss  
Хүчин чадал - 426 морины хүч  
Үнэ - 63 156 925  
Нэг морины хүч - 148 255



Rolls-Royce Wraith  
Хүчин чадал - 624 морины хүч  
Үнэ - 537 036 500  
Нэг морины хүч - 860 634



Jaguar F-Type V8 S  
Хүчин чадал - 495 морины хүч  
Үнэ - 173 420 000  
Нэг морины хүч - 350 346





## МАШИНЫ МАЭСТРО ПОЛЬ АРЗЕНС

Францын дизайнер Поль Арзенс (1903–1990)-ийн авьяас билэг нь 1930-1950 хүртэлх хамгийн тансаг, чанартай, үнэтэй автомашины загваруудаас тод харагддаг. Дэлхийн II дайны дараа францын тансаг зэрэглэлийн автомашин сонирхогчдын гарааш түүний сод бүтээлүүдээр дүүрсэн гэж болно.

Өвөрмөц сэтгэлгээ, нарийн хийцийг эрхэмлэдэг түүний бүтээл нь “моторт хүлэг бол эд хөрөнгө, хүчирхэг байдал” гэсэн үзэл баримтлалыг анх тунхагласан. Машиныуд нь цорын ганцхан хувь, бүгдийг гараар угсарсан гэдгээрээ тэр үеийн машин сонирхогчдын шохоорхлыг үнэхээр их татаж байв. Өнөөг хүртэл автомашин сонирхогчид Поль Арзенсийг шүтэж, түүний загваруудыг шагшин магтсаар ирлээ.

XX зууны эхэн үед Поль Арзенс Парисын Дүрслэх урлагийн их сургуульд /École Nationale supérieure des Beaux-Arts/ сурч, урлаг, уран зураг, баримлын маш өндөр боловсролтой болжээ. Металл урлалын хамгийн сүүлийн үеийн арга технологийг гаргууд эзэмшсэн тэрээр сургууль төгсөөд төд удалгүй өөрийн студи урлангаа Парист нээсэн байна.

Тэрээр олонд алдашиж танигдахын төлөө ажиллаж байгаагүй ч, хөнгөн цагаан, гөлмөн төмрийн чадварлаг хийц нь 1920-30 онд Итали, Францын машины кузов зохион бүтээгч үйлдвэрлэгчдийн анхаарлыг татаж эхэллээ. Бидний өнөөдрийн ойлголтоор тэр үе бол бараг л сүйх тэрэгний мэт бүхээг хийж байсан үе шүү дээ.

Поль Арзенс металлийг бүтэц талаас нь түлхүү сонирхон автомашины хийц бэлдэц хэрхэн хийх, хүмүүсийн хэрэглээнд ойртуулах талаар судалж

эхэлжээ. Энэ судалгаагаараа тухайн үеийн автомашинуудаас илүү нимгэн мөртлөө бат бөх металл гадаргуу, хоолой хийх талаар өөрийн технологийг боловсруулсан байна.

Металлын бүтэц, хийцийг судалж байх явцад 1928 онд plexiglas /органик шил/ нээгдсэн нь залуу Польш онцгой нэгэн бэлэг болжээ. Энэ материал нээгдсэн нь нисэх онгоцны хөгжилд томоохон дэвшил болж, илүү хөнгөн, хурдан загварыг зохион бүтээхэд түлхэц өгсөн юм.

### AB OVO

Бүх л загвар зохион бүтээгч алдартай хүмүүсийн адил Поль Арзенсийн мөрөөдөл, хийхээр төлөвлөсөн ажил дандаа бүтэмжтэй, шулуухан байсангүй. Азгүй гэмээр юм уу даа. Гэхдээ тэр сэтгэл санааны хувьд бууж өгсөнгүй.

Дэлхийн II дайны үед ч тэр шинийг эрэлхийлж уйгагүй ажилласаар. Түүний гуравдахь алдартай концепт бол “L'Œuf électrique” буюу “цахилгаан өндөг”. Энэ загвараа алдарт зохион бүтээгч маань жинхэнэ өөрийн хувийн дур сонирхлынхоо үүднээс бүтээсэн гэдэг. Үүгээрээ тэрээр фашистууд Парисийг эзлэн, түлш шатахуун худалдаалах хатуу хориг тавьсны эсрэг хариу барьжээ.

“Цахилгаан өндөг”-өө зохион бүтээгч ердөө ганц л удаа унаж явсан бөгөөд энэ “ирээдүйн” машин нь 75 км/цагийн хурдтай, таван ширхэг аккумулятораар 100 км явах боломжтой байв. Дайны дараа, машинаа 125 см/куб авсаархан дотоод шаталтын хөдөлгүүртэй болгон өөрчилжээ. Энэхүү хот дотор унах цахилгаан хөдөлгүүрт машины загвараа хийхийн тулд модон хэв ашиглан органик шилийг халааж хэлбэрт оруулж туршсан нь амжилттай болжээ. Дайн дууссан ч улс орны байдал, эдийн засаг балгас болж, Поль Арзенс ч

санхүүгийн хувьд ягтаа тулав. Францын Төмөр замын газраас /SNCF/ шинэ загварын зүтгүүрийн зураг төслийн саналыг хүлээн авч ажиллаж эхэлжээ. Удалгүй тэрээр Францын төмөр замын ерөнхий дизайнер болов.

Поль Арзенс зөвхөн автомашины загвар гэлтгүй автомат хөдөлгүүр, жолооны механизм, тоормос, дугуйн талаар судалж загвар бүртээ өөрөө тусгайд нь зохион бүтээж байлаа. 1950-60 онуудад загвар зохион бүтээгчийн автомашины фантази түр зогсож, бараг оролдсонгүй, галт тэрэг, зүтгүүрийн ажлаа л хийж байв. Энэ чиглэлээр багагүй зүйл хийсний хамгийн алдартай нь “CC7100 Эвдэрхий хамарт” /Nez Cassé/ гэх зүтгүүр толгой болой. Загвар болоод технологийн дэвшил болж чадсан энэ зүтгүүрийн машинистын бүхээг урд шилний зохиомж нь дээрх нэрийг авахад нөлөөлжээ.

1951 оны зун Поль Арзенс ээлжит нэгэн машинаа бүтээсэн нь гэргий, хүүдээ зохиулсан өвөрмөц нэгэн загвар болсон байна. 5,5 л/с хөдөлгүүртэй гэр бүлийн машин нь мөн л хөнгөн цагаан, органик шил ашигласан, зай багтаамж том, маш өнгөлөг болсноос гадна моторыг нь ард нь байрлуулсан нь олны анхаарлыг татав.

XX зууны автомашины загварын сод төлөөлөл миссю Поль Арзенс урт удаан, бүтээл туурвил ихтэй амьдарсан бөгөөд 1990 онд таалал төгсчээ. Түүний алдартай загварууд автомашины дизайны чиглэлээрх хичээлийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болж, түүний давтагдашгүй урлал Франц төдийгүй Европын хамгийн том автомашины музейд /Cite de l'Automobile/ хүндтэй байрыг эзлэн байна.



# MT АВТОМАТ УГААЛГА



**5**  
Минут

Таны машиныг 4 үйлдэл бүхий бүрэн автомат угаалгын төхөөрөмжөөр 5 минутанд угааж цэвэрлэнэ.

**Давуу тал:**

- Цэвэр усгаар угаана
- Хөөс түрхэж цэвэрлэнэ
- Зориулалтын өнгөлөгчөөр өнгөлнө
- Халуун агаараар үлээж хатаана

**Авто угаалга 1:** Замын цагдаагийн газрын зүүн талд **MT ШТС-27**

**Авто угаалга 2:** Амгалан захын эсрэг **MT ШТС - 14**




**78001010**





# 3%ff DISCOUNT CARD



- ✓ Шатахуун худалдан авсан үнийн дүнгээс 3% хөнгөлөлт эдлэнэ
- ✓ Картын дансны хуулгаа шалгаж, шатахууны хэрэглээ, зардлаа хянах
- ✓ Картын дансанд дансны доод үлдэгдэл үл харгалзан сарын 0,3%-ийн хүү хуримтлуулах
- ✓ ХХБ-ны бусад төлбөрийн картын адил өөрийн бүх төрлийн санхүүгийн хэрэгцээнд ашиглаж болно

# ХӨГЛӨХ ЦАГ БОЛЛОО

Нейл Янг /Neil Young/  
хөгжмийн технологийн  
хувьслыг тэргүүлж байна

Нейл Янгын бодлоор mp3-ын эрин үе дуусч байгаа гэнэ. Гранж рокын хаан Нейл Янг саяхан PopoPlayer-ийг ашигласан байна. Энэ төхөөрөмж mp3-аас дууны дуугаралт, нягтралаар даруй гуч дахин илүү сонсогддог аж. Техник технологийн хурдтай хөгжлийн энэ эрин үед өндөр нягтшил бүхий поно-плейрийг удахгүй HD телевизэд суулгах юм. Энгийн iTunes секундэд 256 кбайт, CD – 1411 Kbps, харин хамгийн сүүлийн үеийн поно плейр 9216 Kbps шахаагүй файлыг уншиж чаддаг юм. “Өндөр нягтшил бүхий аудио тоглуулагчийн тусламжаар эцсийн эцэст хөгжим гэж яг юуг хэлдгийг ойлгох болно” хэмээн HDtracks.com-ын үүсгэн байгуулагч Дэвид Чески үзэж байна. HDtracks.com бол дэлхийн хамгийн том дуу татдаг вэб сайт юм. Поно-плейр бол яг л амьд хөгжим мэт гайхалтай

сонсогдох бөгөөд өмнөх үеийн Iprod, mp3 зэрэг төхөөрөмжүүдийг ярих ч хэрэг алга. Одоо хөгжмөө хөглөх цаг ирлээ.



## ТОЛГОЙН ГОЁЛ

- 1953 онд Бруклинд байгуулагдсан Градо Лаб өндөр чанарын чихэвч зохион бүтээлээ. Градогийн RS2e (\$495 gradolabs.com) нь гараар урласан зандан модон агаар нэвтрүүлэгч чимэглэл, дээд зэргийн металаар хийсэн бүрхүүл, 44 мм диаметр хэмжээтэй юм. Дууг хамгийн “дулаан” сонсогхоос гадна дээд ба доод өнгийг гайхамшигтай ялгадгаараа онцлог бүтээл болжээ.

## ЖИНХЭНЭ ТОГЛУУЛАГЧ

- Аливаа дижитал хөгжмийн дуугарах чансаа бол тухайн файлын хэмжээнээс шалтгаална. Өндөр нарийвчлал, нягтшилтай хөгжмийн файл энгийн mp3-аас 6-10 дахин илүү байдаг. Sony –ийн үйлдвэрлэсэн NAP Z1ES (\$2000) тоглуулагч маш өндөр нягтшилтай аудио файл хадгалах 1 терабайт багтаамж бүхий санах ойттой. Өсгөгчтэй wi-fi, эсвэл кабелиар холбогдоно. Мөн өнгөт дэлгэцээр файлуудаа сонгох, тохируулах боломжтой.



## ДУУ ЦАЦРУУЛАХУЙ

- Highway 61 Revisited /Боб Диланы дуу/ -ийг зөвхөн таны зочны ерөөгөөр зогсохгүй байшин даяараа сонсох хэрэгтэй. Дуугаралтын мангас энэхүү төхөөрөмж нь – өөрөө Monster Soundstage S3 (\$400 monsters.com) гэсэн нэртэй. Байшин даяар утасгүй холболт, “хөх шүд”, wi-fi-ээр холбогдоно. Яг л бидний хүсээд байдаг хөг өнгийг унтлагын ерөөнөөс гал тогоо, угаалгын ерөө хүртэл цацруулна.

## ХОЛЬЦОО НЬ ҮГҮЙ АЛТ


Нейл Янг /Канад гаралтай, гранж рок дуучин/ дижитал аудио төхөөрөмжийг усан дотор хөгжим сонсож байгаа мэт, дүлий оргиод дэмий эд хэмээн ойшоодоггүй байсан бол поно-плейр гарснаас хойш энэ бодол нь эрс өөрчлөгджээ. Түүний цомог, дуу хөгжим өнөөдрийн байдлаар popomusic.force.com-д хамгийн топ байранд ороод байна. Поно плейр багтаамжийн хувьд 128 гигабайт, дууны чанарын хувьд ёстой “хольцоо нь үгүй шижир алт” шиг цэвэр тунгалаг!





MARK NASON.  
FOOTWEAR





# НОМЫН СОЛИОТНУУД МУУХАЙ ААШТАЙ БОЛОХОД

Номхон даруу зантнууд дэлхийг өвлөн авсан. Яван явсаар номхон даруу зангаа гэв

**Н**ад шиг зан ааштай хүмүүс миний итгэлийг алдаж байна. 1980 онд гарч байсан кино бодит амьдрал дээр биеллээ олж, номын хүмүүс дэлхий ертөнцийг эзлэх юм бол орчлон хорвоо улам энхрий болно гэж боддог байсан.

Гэв гэнэт бүсгүйчүүд бидний төрлийн залуусыг (номын) тоож эхлэхэд бид дуртайяа тэднийг хайрлана. Багаасаа хүнд дарлуулдаг байсан зовлонгоо санаж бид том компанийн захирал болохоороо нийгэмд дарлуулж гадуурхдаг хүмүүст боломж олгоно. Гоо үзэсгэлэн, хөрөнгө гэх хоосон хэмжигдэхүүн болж аж үйлдвэрийн дор булагдана.

Гэтэл адаа харин ч эсрэгээрээ номын залуус үнэхээр адгийн шаарнууд болжээ. Үнэнийг хэлэхэд бид дарангуйлагчаас муухай ааштай болсон байна. Даруухан, номын залуус сайхан ааштай тул тэдэнтэй болзох хэрэгтэй гэсэн ээжийн сургааль яав? Ээжийн буруу байжээ. Жаахан л эрх мэдэлтэй болоод ирэхээр бид өөртэйгөө адил

алгоритмд хайртай, манга цуглуулагч биш л бол үл хүндэтгэн хүйс, насаар ялган гадуурхсан, эд хөрөнгөнд дуртай балиар хүмүүс болж хувирчээ.

Facebook-ыг үндэслэгч Марк Цүкербергийн эхний вэбсайт нь Facemash байсан бөгөөд энэ нь Харвардын эмэгтэй оюутнуудын хамгийн халуухныг тодруулахын тулд санал асуулга авахад зориулагдсан байв.

Google-ын нийт ажилтнуудын хоёр хувь нь л хар арьстай. Цахиурын хөндийд настай хүн ажилд орно гэж горьдоод ч хэрэггүй. Napster болон Plaxo-ын үндэслэгч Шон Паркер 10 сая долларын зардалтай хуримынхаа үеэр зэргэлдээх ойд гэмтэл учруулсан тул 2.5 сая долларын торгууль авсан. Стив Жобс охиныхоо аав байхаас татгалзаж, Стив Возньякаас их мөнгө авч, олон хүмүүсийн дунд ажилтнуудаа халж бас тахир дутуу хүмүүсийн зогсоол дээр үнэтэй тэргээ тоохгүй байрлуулсан. Махбод Морхадам гэх залуу өөрийнхөө бүтээсэн RapGenius гэдэг вэбсайтнаас халагдсан. Тэрээр Исла Вистад болсон аллагын алуурчны эмэгтэй хүнийг доромжлон бичсэн захиасыг "сайхнаар бичсэн" гэж хэлж байсан байна. Цахиурын хөндийд ажилладаг ихэнх хүмүүс Арти Зиффээс жаахан дээр. Тэр залуу Марже гэх бүсгүйг хүчиндэхийг оролдож, "миний завгүй гарнаас татгалзаж чадахгүй!" гэж хашгирч байсан удаатай.

Бид багадаа хүссэн зүйлээ дуртай цагтаа авч чаддаггүй байсан нь биднийг яг таван настай хүүхэд шиг л болгосон. Тэр цагт нэн даруй хүссэн бүх зүйлээ авахыг хүсдэг. Тэгээд бид гуч дөхөж, найз охинтой боллоо. Гэсэн ч их сургуулийн оюутан шиг л аашилж гэрлэх, хүүхэдтэй болохоо хойшлуулдаг. Сонголт байгаа болохоор бүгдийг туршихийг хүсдэг. Тэгээд бид нэг халуухан эмэгтэйд өөртөө дурлуулсан ч гэсэн тэдэнтэй "серьёзны харьцаа үүсгэмээргүй

байна", "танай нөгөө найзыг чинь хэн гэдгийн" гэх мэтийн тэнэг юм ярьдаг. Ингэж хэлэхдээ хүний чихэнд аятайхан сонсогдохоор бас хэлэхгүй ээ. Өсөж эр хүн болох явцдаа өөрийнхөө тоглоомтой ярьж ихэнх цагийг өнгөрөөдөг байсан бид эмэгтэй хүнтэй эвтэйхэн ярих нь бага. Жорж Клуни олон хүүхнүүдтэй болзож харин Муппетс шоуны Бикер ингэж амжаагүй шалтгаан бий. Эмэгтэй хүмүүсийг араар нь тавих нь нэг зүйл харин тэр тавьсан шалтгаанаа секс, хайр хоёр өөр зүйл гэж тайлбарлах гэж оролдох нь өрөвдөлтэй.

Биеийн тамирын хичээлдээ сайн байсан залуус өөртэйгөө гоо зүйн талаар адил охидуудтай болзохыг хүсдэг. Гэтэл номын залуус гоо зүйн тал дээр эн тэнцэх хүмүүстэй байхыг хүсдэггүй. Залуу баян номын залуучууд яг хөгшин баян хүмүүс шиг. Тэд өөрөөс нь шал өөр халуухан бүсгүйчүүдтэй байхыг хүсдэг. Тэгээд өөрсдийгөө тэднээс мундаг их сургууль төгссөн, илүү мөнгө хийдэг болохоор тэдэнтэй эелдэг бус харьцах нь элбэг.

Биеийн тамирт сайн байсан залуус багаасаа бүсгүйчүүдтэй харьцаад сурсан болохоор тэднээс юу хүсэхээ сайн мэднэ. Харин бидэн шиг залуусын эмэгтэй хүнийг харах нүд видео тоглоом, аниме ба порн үзээд сэвтсэн байдаг. Тэгээд тэдний нүүр дээр тавихад тэд аз жаргалтайгаар инээмсэглэхгүй байхаар бидний дургүй хүрдэг. Бид эмэгтэйчүүд өндөр өсгийт ба дотуур хувцсыг секс хийх гэж өмсдөг гэж боддог учраас эсрэг хүйстнээ хүссэнээр байхгүй болохоор дургүйцдэг.

Удахгүй энэ технологийн тэсрэлт дуусах учраас гольфийн цохиур барьсан сайхан залуус буцаад дэлхийг захирна аа.

Тэгэхэд бид бас л бухимдан, хөгшин хүмүүсийг ажлаас нь халахыг хүлээгээд, халуухан охидыг араасаа хөврүүлээд, Феррари унахыг хүсээд суух нь маргаангүй.

# НАМАЙГ БЯЛУУ ТАЙВАН ИДҮҮЛ

Энэ бол баярын номер 1 дүрэм:  
Найз охин болон амттан хоёрын  
дунд битгий зогс!

**Т**иймээ! Энэ бол амралтын өдөр! Гэрээ тохижуулаад, дэлхий ертөнц аз жаргалаар дүүрэн. Амттан идэхээ бэлд! Би энэ цагийг бүтэн жил хүлээлээ. Надаас гадна маш олон эмэгтэйчүүдийн хувьд энэ баяруудад хоол их том нөлөө үзүүлдэг. 10 дугаар сарын сүүлээр болдог Halloween-ы баярын дараагаас эхлээд үргэлжилдэг сайхан хоолууд байна. Candy corn, Milk duds чихэр байсан. Энэ чихрийг нь амандаа хийчхээд 12 сард болох баяруудад улам их гоё зүйлс иднэ гэж хүлээнэ. Тэгээд л өөрөө өөртэйгөө байлдан, баяртаа бэлдэж эхэлнэ дээ.

Бид зорилготой эмэгтэйчүүд. Бид 10; 11 сар гээд л идэж уусан юмныхаа калорийг тооцож эхэлнэ-тослог, калори, нүүрс ус гэх мэтийг. Бид өглөө нэг цагийн өмнө сэрүүлэг тавьж эртлэн босно. Тэгээд төлөвлөсөн ёсоороо гүйдэг. Бид жимсийг амттан гэж бодоод иднэ дээ. Кино театрт Diet Coke ууж сэтгэлээ тайвшруулна. Гэртээ жигнэсэн тахианы оронд жигнэсэн загас идэж өөртөө янз бүрийн хоол идэж болж байгаа шүү гэж сануулна. Бид гайхалтай. Бид бол өөрийгөө эзэмдэж чадахын туйл. Хүрээлэн буй эрчүүд биднийг хүндэтгэж эхэлдэг. Ноднин жилийн ярьсан эрүүл, туранхай болно гэсэн төлөвлөгөө бусдын нүдний урд өрнөдөг. Ярих нь багасч хийх нь ихэсдэг. Үнэхээр гайхалтай. Бид ганц хундага вино уугаад больдог. Яагаад гэвэл энэ бүхэн өөрсдөөс минь том

зорилгын төлөө болохоор. Тэгээд энэ бүх баяр дуусахад чи шоконд ордог байх л даа.

Талархлын баяр! Энэ бол амралтын өдөр, тэмдэглэлт мөч. Энэ бол гэр бүлийн уламжлалт ёс. Нүүрс усаар дүүрсэн, тослог, өндөр калоритой хоол. Энэ сүүлийн зургаан сар өөрөө өөртэйгөө байлдан байж олсон контрол нэг өдрийн дотор байхгүй боллоо. Тэгээд цагаа тулаад ирэхээр бид өөрсдийгөө хорихыг хүсдэггүй. Биднийг тавгаа өндөр калоритой хоолоор дүүргэж, чихэрлэг жимс идэнгээ цөцгийн тостой талхыг жимсний чанамлаар дүүргэхийг харна. Тэгэхэд чи, аан манай хүн амттанаа алгасах юм байна гэж бодно. Чи буруу, маш буруу таамаглалаа. Бид шууд амттан руу дайрна. Чи энийг "за яахав нэг л өдөр ингэх юм байна" гэж бодно. Гэхдээ энд хүрээд дуусахгүй. Баярын маргааш нь бас л энэ янзаар үргэлжлүүлнэ. Бүр Старбакс орж хамгийн чихэрлэг зүйлийг нь уугаад тэгээд гэртээ кристмасын жигнэмэг хийж эхэлнэ. Бидний энэ байдал чамд маш сонин санагдана. Бүтэн жилжингээ өөрөө өөртөө хяналт тавьсныг чи харсан. Victoria's Secret-ийн моделууд мэт жигнэмэгийн уутнаас ганцыг л аваад буцаад гялс хаахыг чи харсан. Ингээд ийм "контрол" алга болоход чи надад ямар нэгэн зүйл хэлэх ёстой гэж

боддог. Чи зүгээр л туслахыг хүссэн. Нэг удаа манай найз залуу надад туслах гэж оролдсон. Намайг шарсан төмс идэж байхыг хараад над руу ирэв. Тэр намайг бүтэн нэг сар хоолны дэглэм барьж байгааг мэддэг байсан л даа, "Гэдсээ битгий шарсан төмсөөр дүүргээ" гэж хэлэв. Тэр яг юу гэж хэлэх гээд байсан бэ гэхээр "Битгий гахай шиг гэдсээ хагартлаа ид" гэж хэлэх гээд байсан байх. Би өөрийнхөө талаар нэг юмыг тэр өдөр мэдэж авсан: Би хүн алж чадах юм байна аа гэж. Би тэрний сахалнаас нь татаж толгойг нь салсаанд дүрээд живтэл нь байлгалаар байсан. Тэр намайг ердөөсөө ойлгоогүй болохоор миний уур маш их хүрсэн.

Үнэнийг хэлэхэд эмэгтэй хүн болгон л жин нэмж хасдаг. Баярын өмнө хоолны дэглэм бариад 3 кг хассан нь удахгүй бикини авахыг хүссэн учраас тэгсэн зүйл биш. Бид хүсвэл 3 кг буцаад нэмж болно. Энэ нь дуртай юм аа идээд тэгээд 3 кг нэмэхдээ санаа зовохгүй байж болно гэсэн үг. Бид 10 сард ямар жинтэй байсан тэрэндээ буцаж орж байна гэсэн үг. Таргалах гэдэг бас учиртай.

Битгий санаа зовоо. Энэ удаан үргэлжлэхгүй. Удахгүй 1 дүгээр сар болж чамайг уриалан дуудаж гүйж хариагаад явж байна. Харин одоо хайрттайгаа баяраа гоё тэмдэглэ. Бялуу идэхэд нь хажууд нь зүгээр байж бай.



Архи уугаад шараа тайлахад секс хий, эсвэл бүр хийж болохгүй гэж янз бүрээр ярих юм. Аль нь зөв бэ?  
Дархан. А.Эрдэнэ-Очир

- Яг энэ асуудлаар Бразилийн Линья Сан-Педро хотын эмч нар туршилт судалгаа хийсэн байна. Шартаж зовж буй 200 хосыг бэлгийн харьцаанд оруулж "харгислал үйлджээ". Туршилтын үеэр мөн оролцогчдын түүх, хорт зуршилтай эсэхийг нарийвчлан шалгасан байна. Судалгааны эцэст бэлгийн харьцаанд эрчтэй хүчтэй орох үеэр даавар ихээр ялгарч бие махбод дахь хорыг задлах, гадагшлуулахад хэрэгтэй хэмээн Бразилийн эмч нар үзсэн байна. Гэхдээ энэ аргыг хэрэглэхгүй байх нь өөрөөс тань шалтгаална. Архи, тамхи хортой шүү дээ.


- Зарим бүсгүй хөхөөрөө тавиулах гээд байдаг нь ямар учиртай бол?  
Багануур. Н.Алтанхуяг

- Эмэгтэй хүн гэлтгүй хүн бүр өөр өөрийн мэдрэмж, таашаалтай байдаг. Секслогичдын тооцоогоор хөхөөрөө "энхрийлж" тавиулдаг бүсгүйчүүд 2-3 хувиас хэтэрдэггүй. Энэ бол залуу бүсгүйчүүдэд тохиолддог бөгөөд нас ахиад ирэхээрээ аяндаа больдог юм.

- Компьютерийн тоглоом өнөөдөр спорт болтлоо хөгжлөө. Энэ кибер спортод дасгалжуулагч гэж байдаг уу? Ер ямар дэглэм шаардлага тавьдаг бол?  
Ховд. Н.Батнасан

- Энэ төрлийн спортоор хичээллэгсэд байнга кейборд нүдээд байхгүй ээ, харин ч эсрэгээрээ амралт чөлөөт цагаа их зохицуулах шаардлагатайг кибер тоглоомын мастерууд зөвлөдөг. Хэт удаан

# PLAYBOY ЗӨВЛӨГӨӨ



Нөхөр бид хоёр сүүлийн хэдэн сар ямар ч жижиг асуудлаас болоод түр тар хийдэг боллоо. Яаж хэвийн байдалдаа орох вэ?  
Ж.Сарнай

- Маргааныхаа шалтгааныг бод. Та хоёрын маргалдаж байгаа шалтгаан, асуудлыг байж болох эсэхийг бодож үзээрэй. Зөвхөн бардам зангаа даван гарахын тулд маргалдаад байгаа юм биш биз. Хайрынхаа төлөө хааяа бууж өгөх нь зөв байдаг. Тэгш эрх. Үүссэн асуудалд хамтдаа хариуцлага үүрч сурах хэрэгтэй. Зөвхөн хайртын чинь буруу биш шүү дээ. Маргалдаж, хэрэлдэж чадаж байгаа юм чинь эвлэрч, эвтэй байж чадна. Нөхөртэйгөө нүүр тулж яг юунаас, ямар инээдтэй юмнаас болж "гал ассаныг" сайн ярилцаарай. Инээд чинь хүрэх вий. Ийн ярилцахад маш илэн далангүй, нээлттэй байвал зохино. Мөн уучлал гуйх гэж яарсны хэрэггүй. Яг уучлал гуймаар санагдах үеэ хүлээх хэрэгтэй. Эвлэрээгүй байхдаа үнсэлцэх тэврэлцэх хэрэггүй. Асуудлыг шийдэхгүйгээр эвлэрэх нь дараагийн маргааныг улам хурцдуулах аюултай.

төвлөрөх, дэлгэц удаан ширтэх нь амжилтад эсрэгээр нөлөөлдөг болохыг тэд анхааруулдаг. Жишээлбэл Өмнөд Солонгосын кибер спортын шигшээ баг дэлхийн том өрсөлдөгчид. Тэд тусгай байранд амьдарч бэлтгэл сургуулилтаа хийдэг. Гэхдээ багш нар нь залуусыг хэт донтуулах, хичээл сурлага, хувийн амьдралдаа илүү их цаг зарцуулах тал дээр хатуу дэглэм баримталдаг байна. Хуруу гарын хөдөлгөөнийг эвсэл олгох, фитнес, бассейн оруулах, программ хангамж, компьютерийн мэдлэгийг дээшлүүлэх гээд тэдний бэлтгэл маш нарийн системээр хийгддэг шүү.

- Насанд хүрэгчдэд зориулсан киног яагаад XXX гэж тэмдэглэдэг болсон юм бэ? Хаанаас гаралтай вэ?  
Улаанбаатар.  
Баянгол дүүрэг М.Наранбаатар

- Энэ тэмдэглэгээг порно үйлдвэрлэгчид өөрсдөө сонгосон юм. "X" тэмдэглэгээг Америк, Британийн кино үйлдвэрлэгчид 1950-иад оноос анх хэрэглэсэн бөгөөд 16-аас доош насныхан үзэж болохгүй гэсэн анхааруулга байж. Харин энэ чиглэлийн бизнес эрч хүчээ авсан 1970-аад онд "XX" юмуу "XXX" гэсэн тэмдэглэгээ нэвтэрсэн. Мэдээжээр тэмдэглэгээний тоо нэмэгдэх тусам илүү заваан задгай, хэтэрхий гэмээр үйл явдал гардаг. Дашрамд хэлэхэд өнөөдөр АНУ-д хүчирхийлэл, цус нөж, аллага бүхий киног NC-17 гэсэн тэмдэг хэрэглэдэг. Энэ нь "no children 17 and Under Admitted" гэсэн агуулгыг илэрхийлдэг. Порно бол мэдээж "XXX".

- Эмэгтэй хүний сэрлийг дээд зэргээр өдөөгч цэгийг яагаад G гэж нэрлэсэн юм бол? Латин цагаан толгойн олон үсэг бий шүү дээ.  
Орхон. Б.Батбаяр

- Энэ цэгийг германы эрдэмтэн, эмэгтэйчүүдийн эмч Эрнст Графинберг нээсэн. Аливаа нээлт хийсэн эрдэмтдийн нэрээр тухайн зүйлийг нэрлэдэг жишгээр тэрээр өөрийн овгийн эхний үсгээр нэрлэжээ. Өнгөрсөн зууны 50-аад онд эмэгтэй хүний дур тавилт, үтрэний талаар нарийвчлан судалж байжээ. Харин эрдэмтнийг нас барсны дараа 1980-аад онд доктор Эрнст G цэгийг эмэгтэйчүүдийн үзлэгийн үеэр үү, аль эсвэл хувийн амьдралаасаа нээсэн үү гэдэг дээр хүмүүс сонирхож өгүүлэл бичиж байж.

- Нэгэн сониуч гэмээр асуулт байна. Порно жүжигчид зураг

авалтын үеэр өдөрт хэдэн удаа тавьдаг бол?

*МУИС Ж.Сарантуяа*

- Энэ талаар тодорхой тоо баримт судалгаа алга байна. Тухайн хүний зан ааш, сэрэл мэдрэмжээс тав юмуу эсвэл хорин тав тавих нь шалтгаалах байх. Гэхдээ америкийн порно жүжигчин Жон Доу зураг авалтынхаа үеэр өдөрт 55 удаа тавьсан гэдгээрээ өнөөдөр Гиннесийн амжилтыг тогтоожээ.

- *Би германуудтай нэлээн хэдэн жил ажилласан тэднийг сайн мэдэх хүн. Гэхдээ ихэнх порно дээр германаар "яа яа, дас ист фантастиш" гэсэн үг байнга гардаг, яагаад?*  
*Сүхбаатар дүүрэг. Г.Мөнхцэцэг*

- Герман порно кино дээр германаар л ярина шүү дээ. Статистик тоо баримтаас үзвэл герман жилд 7 сая порно диск гаргадаг байна. /хууль бус хуулбар бичлэгийг оруулаагүй/ Энэ тоо бол энэ чиглэлийн нийт зах зээлийн дийлэнх хувь, дэлхийн хаана ч хүрч борлогдоно гэсэн үг шүү дээ. Мөн судлаач сэтгэл зүйчид герман порно жүжигчин хүүхнүүд биеийн өө сэв, сайхан муухайгаасаа үл хамаараад ичих зовохгүйгээр нэлээн задгай тоглож чаддаг нь киноны борлуулалтад сайнаар нөлөөлдөг гэж үзжээ.

- *Би Орост олон жил амьдарч байгаад ирсэн. Орос эмэгтэйчүүд их том хөхтэй байдаг. Орос болон манай эсэгтэйчүүдийн дундаж хэмжээ нь хэд байдаг вэ?*  
*Улаанбаатар. Я.Наранцэцэг*

- Үнэхээр тийм. Орос эмэгтэйчүүдийн хөх тэдний гоо үзэсгэлэнгийн нэг хэсэг гэж үздэг. Судалгаагаар орчин үеийн орос бүсгүйн хөхний хэмжээ нь 7-8 гэж гарсан байна. Харин өсвөр насны охидынх 3 гэжээ. Харин манай монгол бүсгүйчүүд дунджаар 4-5 гэсэн хэмжээтэй хөхтэй байдаг.

- *Хосууд хамтдаа гар хангалга хийх талаар секслогич эмч нар юу гэж үздэг вэ? Энэ хамтын секс мөн үү?*

- Энэ асуудал дээр эмч нар маргасаар байна. Мэдээж гар хангалга гэсэн үгээс шалтгаалж байна л даа. Нэг хэсэг нь хосууд хамтдаа гар хангалга хийж бие биедээ таашаал өгч чадаж

байгаа бол секс мөн гэж байхад нөгөө хэсэг нь жинхэнэ сонгодог секс биш хэмээн үздэг юм байна.

- *Найз залуу яг "ид ажлын үед" унтаад өгсөн. Энэ надаас болов уу?*  
*Булган Э.Энхцэцэг*

- Тантай ямар ч холбоогүй ээ, түүний асуудал байна. Ер нь тэр их ядарсан бололтой. Сексийн үеэр маш их эрч хүч гардаг учраас тэр унтсан байж болно. Ер нь нэмж хэлэхэд согтууруулах ундаа хэрэглэсэн үед эрчүүд дуусгаж чадалгүй хурхирах үе байна шүү.

- *Би найз охиноосоо доод эрхтэн дээрээ шивээс хийлгэхийг хүслээ. Гэтэл тэр сексийн үеэр ямар ч мэдрэмжгүй болдог гэж байна. Үнэн болов уу?*  
*Сонгино Хайрхан дүүрэг Б.Чадраа*

- Үгүй ээ, шивээс сексийн мэдрэмжид нөлөөлөхгүй. Чамд зөвлөхөд эрхтний тэр хэсэг газар бол эмэгтэй хүний сэрлийн цорын ганц цэг биш юм. Өөр газар нь ч аятайхан шивээс хийлгэж болно. Гэхдээ та хоёр хоюулаа хос шивээс хийлгэвэл түүнийг ингэж хүчлэхээс хамаагүй илүү байх болно.

- *Би махлаг эмэгтэйчүүдэд дуртай. Энэ талаараа нэг эмэгтэйд хэлтэл, тарган эмэгтэйчүүд хүсдэг бол энэ нь нэг төрлийн гаж дон гэлээ.*  
*Баянхонгор Н.Анхбаяр*

- Хүн бүрийн сонирхол таашаал харилцан адилгүй. Тарган эмэгтэйчүүдэд дуртай байж болно. Гэхдээ тарган том биетэй эмэгтэй хүнд таашаалтай хандахыг секс судлалд "морфофили" хэмээн нэрлэдэг. Гиннесийн амжилтын ном үзсэн биз дээ. Тэнд бүхэл бүтэн байшин лугаа адил том эмэгтэйчүүдийн зураг олон бий. Гэхдээ энгийн махлаг эмэгтэй сонирхох нь хэвийн үзэгдэл. Дурлал- Эрүүл энхийг хүсье!

- *Эмэгтэйчүүд хөх томруулах мэс засал их хийлгэдэг болж, эсрэгээрээ жижгэрүүлэх мэс засал хийдэг болов уу?*  
*Улаанбаатар Ж.Баярмаа*

- Мэдээж хэрэг болно. Анагаах ухааны уйтгартай нэр томъёогоор "жижгэрүүлэх пластик мэс засал" гэдэг байна. Томруулахтай адилхан олон хүн хийлгэдэг. 6-8 хэмжээтэй хөх гээд бодоод үзье. Эмэгтэй хүн урд


талдаа "ийм хэмжээний ачаа" үүрээд явах нь нуруу өвдөх гээд хүндрэл бий. Дээр нь хэт том хөхтэй бүсгүйчүүд даашинз, богино ханцуйтай цамц өмсөхөд асуудал үүсдэг л дээ.

- *Гар хангалгыг зөвхөн хүн хийдэг үү?*  
*Улаанбаатар Ө.Наранчимэг*

- Үгүй ээ, хүн бол гар хангалгын цорын ганц хаан биш. Сайхан хангайн буганаас авхуулаад далайн замба гүрвэл хүртэл "гар хангалга" хийдэг байна. Амьтад чулуу, модны мөчир, навч цэцгийг ашиглаж дур хүслээ хангадаг. Тэр байтугай АНУ-ын нэгэн амьтны хүрээлэнд эм шимпанзе насанд хүрэгчдийн сэтгүүл үзээд гар хангалга хийсэн тухай мэдээлэл гарч байжээ.


Эрэгтэй хүний үрийн шингэн эмэгтэй хүнд их хэрэгтэй гэдэг хэр үнэн бэ? Би хааяа хөхөх үеэрээ залгичихдаг.  
Улаанбаатар Х.Насанжаргал

- Нью-Йоркийн их сургуулийн эмэгтэй оюутнуудын дунд хийсэн судалгаагаар эр үрийн шингэн эрүүл мэнд, гоо сайханд маш их чухал болохыг тогтоожээ. Судалгааг нээлттэй, хамаагүй задгай асуултад илэн далангүй хариулах нөхцөлөөр хийсэн байна. Ингээд ссудалгааны дүнд аман сексийн үеэр "залгисан" болон үтрээнд хамгаалалтгүй "тавьсан" үрийн шингэн нь эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд эерэг нөлөөтэй болох нь тогтоогдоод зогсохгүй зан байдал, сэтгэл санааг нь тогтворжуулж, стресс сэтгэл гутралыг ялан дийлэх хамгийн сонгодог эм болохыг тогтоожээ. Үрийн шингэн нь сэтгэл санааг тайвшруулж, хүсэл хайрыг нэмэгдүүлэх мөн нойргүйдлийг анагаах элементүүдийг агуулдаг бөгөөд сэтгэл гутралын эсрэг ч үйлчлэх цөөнгүй найрлагыг өөртөө шингээжээ. Сексийн тогтмол мөн "хамгаалалтгүй" харилцаа нь стресснээс ангид байлгахын зэрэгцээ уураг тархинд ч сайн нөлөө үзүүлж байгааг судалгааны багийнхан нээн илрүүлсэн байна. Судалгааны багийнхны үзэж байгаагаар үрийн шингэн нь хүсэл, хайрыг нэмэгдүүлэгч "кортизол", сэтгэл санааг сэргээгч "окситоцин", даавар ялгаруулагч "тиротропин", сэтгэл гутралын эсрэг "серотонин" зэрэг эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд эерэг нөлөөтэй хэсэг химийн нэгдлүүдийн төлөөллөөс бүрдэл болдог ажээ.



# PLAYBOY'S

## GREATEST COVERS



For nearly 60 years, Playboy Magazine has made a splash with its mind-blowing covers. Now, for the first time, there is a book dedicated to this American icon.



Featuring hundreds of color photographs and behind-the-scenes outtakes from cover shoots.

Foreword by Pamela Anderson, text by Damon Brown. Sterling Publishing.

310 pages. 9" by 11." \$35 (\$42 in Canada).

Go to [amazon.com](http://amazon.com) to order.



# АМЖИЛТЫН ДАЙСАН

ЭРЧҮҮДЭЭ, ӨӨРСДИЙНХӨӨ АЙДАСЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨР!



Айдас сул доройн шинж үү? Зохиолчын хэлж буйгаар: Дэмий яриа, харин ч давуу тал, эр зоригын илэрхийлэл.

Ажлын болон хувийн амьдралдаа айдасаа бусдад харуулах нь өнөөдрийн нийгэмд сул доройд тооцогддог. Харин ардын ярианд айдас бол хамгийн муу зөвлөгч гэгддэг байна. Сүүлийн жилүүдэд айдас гэдэг нь маш муу зүйл мэт яригдах болсон. Бидний ихэнх нь айдасыг хувь хүний эр зоригтой, итгэл төгс биш байгаагийн илэрхийлэл гэдэг. Ажилчдынхаа өмнө ирээдүйд юунаас айж эмээж байгаагаа хэлж буй захирал, дарга нарыг төсөөлөхийн аргагүй. Эсвэл бүтэлгүйтэхээс айж байгаа улс төрч, мэс засалч, онгоцны ахлагч нар байх бол уу? Үнэндээ л инээдтэй! Амжилтын төлөө чармайн зүтгэдэг германчууд нь сэтгэл санааны байдлаа үл тоох, дарах эсвэл сэтгэл санааны байдалтайгаа тэмцэхийг их хичээдэг. Айх, эргэлзэх нь таны амжилтыг сүйтгэнэ. Эерэгээр бодож, дайчин байх нь танд их ирээдүйг бэлэглэнэ. Тиймээс өөртөө итгэ, тэгвэл чи хүссэн бүхэндээ хүрч чадна! Зөвхөн нэг инээмсэглэл бүхнийг өөрчлөж чадна. Таны гайхамшигтай хуурамч инээмсэглэлийн ард айдас, эргэлзээ нуугдаж байгааг хэн нэгэн таана гэж үү? Айдас бол бүтээлч биш, эрүүл биш, итгэл төгс биш – мөн эрэгтэйлэг бус гэж өнөөгийн нээлттэй нийгэм


хүлээж авдаг. Германчууд жилд ойролцоогоор 1 тэрбум тайвшруулах болон стрессний эсрэг эм худалдаж авдаг нь гайхаад байх зүйл биш. Мансууруулах бодис, эм болон допинг нь биднийг ажидаа болон хувийн амьдралдаа эрч хүчтэй байхад тусалдаг. Тэр тусмаа бүхнийг хяналт нь доороо байлгахыг хүсдэг мэргэжлийн тамирчид хэдэн жилийн турш метилпенидар бэлдмэлийг хэрэглэдэг ба энэ нь риталин гэдэг нэрээр худалдаанд гардгаараа олонд танил. Энэ ампетамины төрөл ба хүүхдүүдийг томоотой суулгахын тулд тэдэнд өгөхийг зөвшөөрдөг байна. Одоо бол энэхүү бэлдмэлийг олон эцэг эхчүүд болон хүүхэдгүй насанд хүрэгчид ажилдаа төвлөрч анхааралтай ажиллахын тулд өргөнөөр хэрэглэдэг болсон байна. Нэг өдрийн хэрэглээний метилпенидар нь жилд 50 сая орчим зарагддаг байна. Химийн ямар ба нэгэн бодисын нөлөө, тусламжгүйгээр ажил хөдөлмөр эрхлэх нь боломжгүй зүйл болж байгаа мэт. Чухал нь үүнийг хэнд ч мэдэгдүүлэхгүй байх: үл тоох болон нууцлах. Хамгийн эмгэнэлтэй нь өөрөө өөрийнхөө айдасыг хүлээн зөвшөөрөхгүй байх нь юм. Тиймээсээ ч үүнийгээ бусдад харуулахгүйг хичээн, ямар нэгэн нян бактерь устгах мэт эм бэлдмэл хэрэглэж, мансууруулах бодисонд дондож юу ч болоогүй мэт инээмсэглэн цааш алхана. Өөрийнхөө айдасыг хүлээн зөвшөөрөх нь эхэндээ тухайн хүний айдасыг улам нэмэгдүүлдэг нь тодорхой болсон. Жишээлбэл бүтэлгүйтэхээс айх эсвэл ажлаа алдахаас айх: Өөрийн айдасаа хүлээн зөвшөөрч ажлын болон хувийн амьдралын хэв маягаа

өөрчилж чадахгүй бол айдас гэдэг зүйл үргэлжийн мөнх таны дагуул байх болно. Айдасыг албан хүчээр дарлаа гээд эрч нь сулрахгүй ба харин ч таны эрч хүчийг улам л сулруулсаар байх болно. Айдастайгаа тэмцэх арга хэмжээнүүдийн судалгааны дүн нь үнэхээр сэтгэл гонсойм: Судалгаа 1 жил үргэлжилсэн ба 20 сая германчууд эмчилж болохоор айдасын төрлүүд, гуниж гутрах, сэтгэл санаагаар унах болон сэтгэл санааны тогтворгүй байдалд нэрвэгдсэн нь тогтоогджээ. Тайвшруулах эмийн худалдаа сүүлийн 10 жилд 2 дахин өссөн байна. Хөдөлмөрийн бирж дээрх ажилгүйдэл, цомохтгол зэрэг нь хүмүүсийн айдасыг улам л нэмэгдүүлнэ. Яагаад? Учир нь бид айдас гэх энэ зүйлд маш их ач холбогдол өгч түүндээ хүчтэй автаад байгаад учир нь байгаа юм. Айдас нь тийм ч дэмий зүйл биш, харин ч ихээхэн үнэ цэнэтэй ололт амжилт юм. Айдас нь баяр баясгалан, уур уцаар, гунигын нэгэн адил хүнд байдаг л энгийн шинж чанаруудын нэг. Энэ чанар нь эрт дээр үеэс хүн төрлөхтөний амьд үлдэх баталгаа болсоор ирсэн. Айхгүй байх нь өвдөлтийг мэдрэхгүй байгаатай адил юм. Айдас болон өвдөлт нь биднийг гэмтээж хохироох болон амь насаа алдаж болох нөхцөл байдлаас сэрэмжлүүлдэг. Хүний хувьсал хөгжлийн явцад айдасыг мэддэггүй амьд биетүүд юуны түрүүнд устаж үгүй болсон. Сэргэлэн, уян хатан, зохицох чадвартай болон аймхайнууд нь л амьд үлдэж чадсан ба тэднээс бид үүсэлтэй юм. Яагаад бид үүнтэй тэмцэх ёстой гэж? Энэ бидэнд муугаар нөлөөлдгийг анагаах ухааны судалгаа

шинжилгээнүүд баталдаг. Хэдий биднийг юу хүлээж байгааг бид мэдэхгүй ч, айдас нь биднийг ямар нэгэн зүйл хийхээс ухрааж, шийдэмгий бус болгодог ба бидэнд ахин нэг тунгааж бодох хугацааг олгодог юм. Итгэл найдвар нь айдасыг даван туулахад ихээхэн нөлөөлдөг. Сайхан үгсээр чимсэн худал хуурмаг амлалтуудаас илүүтэй гэрэл гэгээтэй, өөдрөг үзлийг шингээсэн итгэл найдвартай байх нь маш чухал. Айдас нь эсрэгээрээ бодит ба бидний хийж буй зүйлсд шууд чиглэдэгээс гадна таатай бус мэдрэмжийг төрүүлдэг. Тиймээс бидийг өөрсдийн амьдралаа хамгаалж үлдэх ямар нэгэн өөрчлөлтийг биднээс шаарддаг. Айдасаасаа зугтаах нь хамгийн том тэнэглэл. Айдас нь бүтээлч байдлын болон өөрчлөлтийн зам ба энэ зам нь зоригтой байхыг шаарддаг. Бидний итгэхийг хүсдэг шиг зоригтой байх нь айхгүй байгаа гэсэн үг биш юм. Харин ч эсрэгээрээ: Бодох, ярих, хийх зориг бол айдасаа давах чадвар юм. Айдас байгаагүй бол эр зориг ч байхгүй байсан. Айдастайгаа тэмцэх, айдасаа нуух нь нөгөөтэйгүүр хулчарын шинж. Ажилчиддаа өөрийнхөө айдасыг нээлттэй хуваалцаж байгаа дарга хичнээн зоригтой вэ? Сайхан амлалтгүй улс төрч хэр үнэмшилтэй бэ? Бусдын нүдэн дээр итгэл үнэмшилтэй, хүчирхэг харагдахын тулд оюун санаа, бие махбодио тайвшруулах эм бэлдмэлээр бөмбөгдөх нь байж боломгүй. Айдсаасаа ичин хүчинд нь автах бус харин ч айдасаа хүлээн зөвшөөрч, даван туулах хэрэгтэй: Энэ нь жинхэнэ эр хүний эр зориг болон хувь хүний чадварыг шаардах болно.

# 50 *years of*

## PLAYBOY INTERVIEWS





ЭРЧҮҮДИЙН ЯРЬЖ БАЙГАА ЮМ НЬ ИХЭВЧЛЭН МАКРО ЭДИЙН  
ЗАСАГ, УУЛ УУРХАЙ, ЭНЭ НЬ ХЭРЭГТЭЙ ЮУ ГЭВЭЛ ХЭРЭГТЭЙ.  
ГЭХДЭЭ ХЭТЭРХИЙ НЭГ АСУУДАЛ РУУ ХЭЛТИЙЖ ХАЗАЙГААД  
ЯРЬЖ БАЙТАЛ НЬ ЯГ ҮНЭНДЭЭ МОНГОЛ АЙЛ ӨРХИЙН АМЬДРАЛ  
АЛДАГДЧИХСАН, ГУДАМЖИНД ГАРЧИХСАН БАЙНА.

# Ц. ЦОГЗОЛМАА:

АСАР ИХ ҮНЭЭР БУЦААЖ МОНГОЛ ГЭР  
БҮЛИЙНХЭЭ АМЬДРАЛЫГ ОЛЖ АВАХАД  
ХҮРЭХ ВИЙ ДЭЭ...

“Плэйбой Монголиа” хэвлэгдэн гарсаар хоёр жил хагас болжээ. Сэтгүүлд “20 асуулт”, “Ярилцлага” гэсэн ярилцлагын хоёр булан байдаг. Үндсэн ярилцлагын анхны эмэгтэй зочин маань Ц. Цогзолмаа болж байна. 2015 оны анхны Зочин ярилцагчаар түүнийг урилаа. Ирэх жил УИХ-ын ээлжит сонгууль болно. Өнөөдөр манай улс төрд дутагдаж байгаа нэг зүйл бол эмэгтэйчүүдийн тоо, оролцоо, тэдний байр суурь, шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэх шаардлага байгаа юм. Нийгмийн сайн сайханд хүрэхийн тулд илүү олон эмэгтэй эрх мэдэлд хүрч, удирдах түвшинд гарах шаардлагатай. Эмэгтэйчүүд өөрсдийнхөө урд тавьсан саадыг өөрсдөө л цэгцэлж чадна. Эрчүүдийг гэртээ ч, ажил дээрээ ч эмэгтэйчүүдээ дэмжигтүн гэсэн хандлага нийгэмд үүсэж эхэллээ. Энэ ч үүднээс улс төрд олон жил тасралтгүй зүтгэж байгаа Нийгмийн Ардчилал Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны ерөнхийлөгч Ц.Цогзолмааг урьсан юм.

Ярилцсан Н. Болормаа

**PLAYBOY:** Бидний урилгыг хүлээн авсан таньд баярлалаа.

**Ц. Цогзолмаа:** Нэг талаас ийм боломж олгосонд баярлалаа. Нөгөө талаас хувь хүн Цогзолмаа гэхээсээ илүүтэй эмэгтэйчүүдийнхээ өмнө хүлээсэн чиг үүргийг маань ойлгож байгаад баярлаж байна.

**PLAYBOY:** Олон жилийн түүхтэй танай намын эмэгтэйчүүдийн байгууллага нэрээ өөрчлөөд 20 жил болсон. Сахан ойгоо ч тэмдэглэлээ. 20 жилийнхээ үр дүнг товчхон хэлвэл юу гэх бол?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Нам гэдэг бол хүмүүсийн л олонлиг. Намын ачааг үүрэлцсэн хүмүүс гээд үүх түүхээс нь харахад эмэгтэйчүүдийн үүрэг их. НАМЭХ энэ байгууллага бол эмэгтэйчүүдийн улс төрийн

төлөвшил явагдсан 20 жил гэж би харж байгаа. Айлын хаалга тогшиж сонгуулийн сурталчилгааны материал тарааж байсан эмэгтэйчүүд маань шийдвэр гаргах түвшинд очих шаардлагатай болсон байна гэдгээ олж харсан цаг үе байлаа гэж олзуурхаж байна.

**PLAYBOY:** Улс төрд манлайлах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх шаардлага тулгарчээ?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Аливаа улс төрийн хүчнүүд амжилтанд хүрэхийн тулд янз бүрийн л арга барилаар эмэгтэйчүүддээ ханддаг байх, намдаа огт танил биш, улс төрд бэлтгэгдээгүй эмэгтэйчүүд ч гарч ирдэг шүү дээ. Хамгийн зөв арга зам бол намын анхан шатны байгууллагаас эхлээд дүүрэг

хотынхоо хөгжлийн асуудалд оролцдог, тэгж байж улсын хэмжээний бодлого ярьдаг үе шат шалгуураар явах юм бол манлайллыг бий болгох юм. Улс төрийн санамсаргүй сонголтоор, урилгаар ирсэн хүмүүс эргээд олон нийтэд хүлээн зөвшөөрөгддөггүй.

**PLAYBOY:** УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийг л улс төрийн хүрээнийхэн гэж ойлгоод байдаг хүмүүс.

**Ц. ЦОГЗОЛМАА:** Өнөөдөр манай улс төрд бий болчихсон байгаа имиж дүр төрх гэх юм уу даа эмэгтэйчүүд гэлтгүй, УИХ-ын 76 хүнээр л улс төрийн орон зайг тодорхойлоод байдаг юм. Угтаа бол төвлөрлөө сааруулаад тухайн бүс нутаг, аймаг орон нутаг өөрсдөө асуудлаа



аяж гаргаж ирж байна, шийдэж чадаж байна уу гэдэг нь чухал. Хот нь хөгжиж байж улс нь сайхан харагдана, аймаг нь хөгжиж байж улс сайхан харагдана гэдэг энэ үе шат орхигдсон. Тэгэхээр УИХ-д ийм үе шатаар дамжиж гарч ирэхгүй байгаа санагддаг юм.

21 аймаг хөгжлийн бодлогоор өрсөлдөөд ирэх юм бол монгол улсын хөгжлийн концепц гараад ирэх юм шиг харагддаг. Аймаг бүрт нэг брэнд байж л таараа. Түүнийхээ техник, эдийн засгийн үндэслэлийг гаргаж ирж чадвал. Тухайлбал, Увс чацарганаар, Ховдод юу байж болох вэ. Ховдын тарвас хамгийн сайн нь гэх мөртлөө тухайн орон нутаг яагаад түүнийг хөгжлийнхөө нэг хэсэг болгож болохгүй гэж? Шинжлэх ухаанчаар хайж судалбал арга зам байж л байгаа. Тэгэхгүй бол тухайн 4 жилд нэг зам засах, нэг цэцэрлэг барих гэх мэтийн аар саархан юмаар явж байгаа нь Монгол улсын ерөнхий том хөгжилд саад гацаа болж байна. Одоогийн хууль нь ч инээдэмтэй. Баян-Өлгий аймгийн Булган суманд сургуулийн цонх хагарахад боловсролын сайд шийдэх гээд сууж байгаа нь хөгжлийн ямар хөшүүрэг юм бэ? Монгол улс монголоороо л гоёж, бахархах ёстой байх. Гэтэл бусад орны сайн зүйлсийг үлгэрлэж дуурайж авч чадахгүй хуулийг нь автоматаар хуулчихдаг, шүүх эрх мэдлийн тухай хуулийн шинэчлэл гээд л сайжирч байгаа мэт ерөнхий ойлголт олны дунд явж байгаа боловч үнэн хэрэгтээ монголоос эрс гажчихсан шүүхийн тогтолцоог хийчихээд л сууж байна. Тархай бутархай нутаг дэвсгэртэй манай улсын хувьд тухайн бүс нутагт нь таарсан бодлого, монголдоо таарсан бодлого хэрэгтэй байтал өөр формат суулгаад байгаа нь хөгжих гэж байгаа эсэх нь эргэлзээтэй байна. Болж бүтэхгүй байгаа зүйлсийг нарийн харахад эмэгтэйчүүдийн үүрэг асар чухал нь ойлгогддог. Эрчүүдийн ярьж байгаа юм нь макро эдийн засаг, уул уурхай ихэвчлэн ярина, энэ нь хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Гэхдээ хэтэрхий нэг асуудал руу хэлтийг хазайгаад ярьж байтал нь яг үнэндээ монгол айл өрхийн амьдрал алдагдчихсан, гудамжинд гарчихсан байна. Ярьж байсан уул уурхайн орлогоороо 10 жилийн дараа мөнгө хаяад ч гэр бүлийнх нь ёс зүй алдагдчихсан, хүүхдийн сургалтын систем

алдагдчихсан сууж байвал яана. Асар их үнээр буцааж монгол гэр бүлийнхээ амьдралыг олж авахад хүрэх вий дээ. Баримжаагүй, алсын хараагүй бодлого харагдаад байна. Энэ бүхнээс үүдэн бодоод байхад гэр бүлийн нарийн ширийн асуудалд илүүтэй санаа зовж, олж хардагаараа эмэгтэйчүүд их үүрэгтэй байх болов уу. Эрчүүд олонхиороо төр бариад Монгол улсынхаа ирээдүй, хувь заяанд санаа нь зовж байгаа юм болов уу гэж эргэлзэхэд хүргэж байна шүү дээ.

**PLAYBOY:** НАМЭХ бол засгийн эрх барилцаар ирсэн нэг том улс төрийн намын харьяаллын хувьд та бүхэн энэ асуудлыг шийдэхийн тулд юу хийх гэж байна?

**Ц. ЦОГЗОЛМАА:** 20 жилийн ойн хүрээнд олон зүйлийг төлөвлөж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Бусдын өмнө үүрэг хүлээсэн гэдгээрээ ч бас. Миний хувьд төрийн тодорхой албан тушаалд ажиллаж явсны хувьд, НАМЭХ-г тэргүүлж байгаагийнхаа хувьд ч өөртөө нэг зорилго тавилаа. Юу вэ гэхээр аливаа зүйлд судалгаатай хандаа, Монгол гэр бүлийн байдлыг шийдье гэж улс төр лүү орж байгаа юм. Дэлхий нийтээрээ өнөөдөр гэр бүл, үр хүүхэд, амьдралын чанарын тухай ярьж байхад бид яаж амьдарч байгаагаа ярихгүй байна. Бодит байдал яг ямар байгааг хэн ч сонирхож барьж авахгүй байна. Тиймээс 20 жилийн ойн үеэрээ НАМЭХ-ны ерөнхийлөгчийнхөө хувьд санаачилга гаргаад “Эмэгтэйчүүдийн амьдралын чанарын судалгаа”-г улс орон даяар 21 аймгийн, 9 дүүргийн 15 мянган эмэгтэйг хамруулан хийлээ. Судалгааг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж, холбооны идэвхтэн сонгуульт эмэгтэйчүүд маань биечлэн зохион байгуулалтад оролцож явууллаа. Нийгмийн бүх давхарга, малчин, ажилгүй, гэртээ хүүхдээ асраад сууж байгаа гээд эмэгтэйчүүд хамрагдсан. Судалгаа гэхээр л конторт яваад оччихдог шүү дээ, хэдхэн хоромын дотор хэдэн асуулт асуугаад болчихдог. Бид тэгээгүй ээ, тийм учраас монголын эмэгтэйчүүдийн бодитой дүр зураг харагдана гэдэгт итгэлтэй байгаа. Судалгаагаар гарч ирсэн асуудлыг бид намд болон төрийн бодлогод суулгахын төлөө дуу хоолойгоо өргөн, зүтгэх ёстой юм. Судалгаагаа бид яг одоо анализын түвшинд

нэгтгэж байна. Эмэгтэйчүүдийн эдийн засгийн асуудлыг аваад үзэхэд банкинд лизингийн өр байхгүй нэг ч өрх алга байна./тансаг амьдралтай нь ороогүй л дээ/ Өндөр настныхаа тэтгэмжээр амьдарч байгаа гэр бүл 35 хувийг эзэлж байна. Энэ нь хөдөлмөрийн насны залуучууд ажлын байр байхгүйгээс болоод өвөө эмээ, аав ээжийнхээ тэтгэвэр тэтгэмжээр амьдарч байгаатай холбоотой. Энэ бол том эмгэнэл. Энэ судалгааны дүнг намынхаа 2016 оны мөрийн хөтөлбөрт тусгана даа. Мөрийн хөтөлбөр гэхээр л худлаа амлалт өгч нэг байшин барьдагаа болимоор байна.

**PLAYBOY:** Та бүхний асуудлыг мөрийн хөтөлбөртөө оруулахгүй гэвэл яахав.

**Ц. ЦОГЗОЛМАА:** Эмэгтэйчүүд бид сонгуульд санал өгөхгүй гэж тулгана даа тэгвэл. Эмэгтэйчүүдээр дамжин гарч ирж байгаа судалгаа бол монгол гэр бүлийн амьдралын бодит дүр төрхийг хэлж байгаа хэрэг шүү дээ. Тиймээс гэр бүлийн асуудлыг шийдэхгүйгээр бид хөгжил ярих нь утгагүй гэдгээр намын мөрийн хөтөлбөрт оруулах гэж байгаа юм. Үүгээр ч зогсохгүй, бусад улс төрийн намуудад санал болгоно. Тэд бас энэ асуудлыг авч үзэх нь чухал биз ээ.

**PLAYBOY:** Хэрвээ тэгж нэгдэж чадвал том бодлого болох нь ээ?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Тэгвэл мөн сайхан байна. Өнөөдөр хүн дэлхийн хаана амьдарч байгаагаасаа үл хамаараад амьдралын чанарын тухай ярьдаг болсон байна. Бид үүн рүү ойртох хэрэгтэй байна. Судалгааны асуулга бүрийг задалж энэ онд нийгэм рүү хандаж ажиллана.

**PLAYBOY:** Гэрэл гэгээтэй зүйл харагдана уу, судалгаанаас?

**Ц. ЦОГЗОЛМАА:** 25 асуулгатай судалгаанаас ганц л гэрэл гэгээтэй зүйл байлаа. Энэ бол боловсролын асуудал. Монголын эмэгтэйчүүд боловсролдоо их анхаарч байна. Эрүүл мэнд, боловсролын салбарт эмэгтэйчүүд давамгайлж байна. Бакалавраас гадна магистр, доктор профессорын тоо олон болсон байна. Энэ бүхнээс харахад өнөөдөр бид квот хүсч байгаа боловч тодорхой хугацааны дараа хүссэн ч эс хүссэн ч бусад салбарт эмэгтэйчүүдийн дуу хоолой давамгайлах юм байна гэсэн дүр төрх харагдлаа.

**PLAYBOY:** МАН бол эрчүүд ноёлсон нам. Эрх мэдэл, хөрөнгө мөнгө сонгуульд нэр дэвшигчдийг шийдэж байна. Гэтэл Үндсэн хуулиндаа эрэгтэй эмэгтэй тэгш эрхтэй шүү дээ. Улс төр дэх эрэгтэй эмэгтэй хүмүүсийн шийдвэр гаргах балансын түвшин алдагдаад нэг тал руугаа хэт хэлбийсэн нь улс төрийг бохир болгож байна уу?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Эрчүүд давмгайлж байгаа нь ерөөсөө л эрх мэдэл, мөнгө байгаа нь үнэн шүү дээ. Арай өргөн хараад л төлөөллийн зарчим ярин ардчиллын үнэт зүйлсээ бодох юм бол 50/50 хувьтай л байх байсан. Адилхан эрэгтэй эмэгтэй хоёр хүн байлаа гэхэд эрчүүдийн сонголт яваад л байна. Гэтэл ажиллах давуу чанараараа эмэгтэй нь илүү байгаа нь нууц зүйл биш. Эрх мэдлийн хуваарилалтыг тэнцүү л болгох хэрэгтэй байгаа юм.

**PLAYBOY:** Арга нь?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Улс төрд эмэгтэйчүүдийнхээ оролцоог л нэмэгдүүлнэ дээ. Гэхдээ бид хүлээгээд нэмэр болохгүй гэдгийг өнгөрсөн туршлага харуулсан. Өөрсдийн эрхийн төлөө тэмцэх л хэрэг гарах байх. Нэгдэх хэрэгтэй гэж бодож байна. Уг нь бол нэгдээд л акц хийж байсан л даа. Гэтэл яг шийдвэр гаргах мөчид, халуун асуудал тулаад ирэхээр худлаа болчихдог. 2016 оны сонгуульд эмэгтэйчүүд илүү нягтраасай гэж хүсэж байна. Бид жендерийн талаархи яриа хэлэлцүүлгээс зугтаж чадахгүй. Энэ асуудал бүгдэд хамаатай. Бид өөрчлөлтийг өөрсдөөсөө эхлүүлж чадна. Хүн бүрийн чармайлтаар эрх тэгш нийгэм бий болно шүү дээ. Улс орны талыг эмэгтэйчүүд удирддаг, гэр орны талыг эрчүүд авч явдаг болсон цагт жинхэнэ тэгш байдал бий болох бус уу.

**PLAYBOY:** Тэгэхээр илүү нарийн хуульчилж өгөх хэрэгтэй байх даа?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Нэг талаасаа хуульчлах гэдэг зайлшгүй, скандиновын орнууд гэхэд квот гэдгээр зохицуулж ирсэн. Тэгээд дараа нь угаасаа чадалтай эмэгтэйчүүд квотгүйгээр гарч ирдэг юм байна гэдгийг тэд баталчихсан. Өнөөдрийг хүртэл монголын улс төр мөнгөөр л явж байна. Улс төртэй мөнгө хутгалдвал ямар байгааг бид бэлхнээ харж байгаа шүү дээ.

Сонгуулийн хууль нь өнөөдрийн эрх мэдэлтнүүдэд ашигтай байгаа учраас өөрчилж гэж бодохгүй байна. Мөнгөөр бүхнийг шийдэж байгаа цагт ядуурлаас гарна гэх мэт нь зүгээр л хоосон үлгэр байсаар байх нь дамжиггүй. Ийм цөөхөн хүн амтай, ийм их баялагтай улс мөртлөө яагаад ийм ядуу амьдарч байгаа нь сэтгэлтэй улс төрчид дутагдалтай байгаагийн л илрэл биз дээ. Ядахад урд хойд хөршөө харахад юм бодогдуулж л байгаа биз? Гэтэл манайхан зөвхөн өөрсдийн эрх ашиг яриад л сууж байгаа нь үнэхээр өрөвдмөөр байна. Ирээдүйдээ сайн сайхан юу үлдээх гээд байгаа нь ойлгомжгүй, бүрхэг л байна. Нил өр. Тийм үү?

**PLAYBOY:** Эмэгтэйчүүд улс төрд олуулаа болсноор асуудал шийдэгдэнэ гэдэгт итгэлтэй байна уу?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Энэ асуулт байнга тавигддаг. Хариу нь бол авилгагүй улс төр бий болно, бүх асуудлыг шударга шийдэх эх суурь эмэгтэйчүүд олон байгаа орчинд л бий болдог. Энэ нь дэлхийн улс орнуудад батлагдсан зүйл. Хүний амьдралыг тойрсон, гэр бүлийг тойрсон, цаашлаад нийгэмд хүлээгдэж байгаа олон асуулт, хуулиуд сайжирч батлагддаг. Хууль гардаг л даа өнөөдөр. Яахав олонд таалагдахын тулд хүүхдийн эрхийн хууль батлагдлаа, гэр бүлийн хуульд нэмэлт өөрчлөлт орлоо гэх мэтээр ярина, тэр нь түүхий. Харин ч эмэгтэйчүүд нухацтай суна шүү хуулин дээр. Амьдралд ойртуулна. Улс төр нь бохир учраас маш олон чадалтай эмэгтэйчүүд төрд суухаас болгоомжилдог. Энэ бол харамсаар. Харин ч цэвэрлэхийн тулд, үр хүүхдийнхээ төлөө нэгдэж тэмцэх цаг нь болсон гэж бодож байна. Эмэгтэйчүүдийн гэсэн энэ байгууллагаараа дамжуулан тийм эмэгтэйчүүдэд ойлгуулах хэрэгтэй байна, улс төрийг цэвэрлэхийн тулд. Ер нь эмэгтэй гэлтгүй чадварлаг хүмүүсээ, нийт хүмүүсийг ашиглаж чадвал үр дүн нь сайн нь байх нь тодорхой.

**PLAYBOY:** 2012 оны сонгуульд өрсөлдөөд ялагдсан. Одоо юу гэж боддог вэ?

**Ц. ЦОГЗОЛМАА:** 2012 оны сонгуульд Сүхбаатар дүүрэг дээр өрсөлдөөд өвдөг шороодсон хүн. Би өөрийгөө

ялагдсан гэж боддоггүй. Ялсан. Юм бодитой л байх ёстой. Манайд төрийн эрх мэдлийг луйвраар авах нь бодитой болсон шүү дээ. Санал хурааж, тоолж байгаа хар машин. Би сонгуулийн үеэр нэг ч амраагүй шударга хөдөлмөрлөсөн. Унтах ч завгүй иргэдтэй уулзаж байсан. Гэтэл АН-ын өрсөлдөгчид сонгогчидтойгоо уулзалт хийгээгүй. Тэгээд л ялчихсан. Яагаад? Үнэнийг хэлэхэд тооллогын хар машиндаа найдсан хэрэг. Бүр нэг луйврын аргандаа гаршчихсан. АНУ-д санал хэрэглэхээ больчихсон тэр машиныг өчнөөн тэрбум доллар зарцуулан татвар төлөгчдийн мөнгөөр авчирсан. 800 хан мянган хүн санал өгсөн, гараар тоолж болноо доо. Гэтэл тэрбум гаруй хүнтэй Энэтхэг гараар тоолдог. Үүнээс нэг зүйл хэлэхэд эмэгтэйчүүд сонгуульд оролцохдоо тэр хар машиныг хэрэглүүлэхгүйн төлөө байх хэрэгтэй. Би боддог юм, 31,1 хувийн саналын босгоо давчихсан байсан. Сонгуулийн үеэр иргэдтэй ярилцаж байх үеийн мэдрэмж гэж байна. Дэмжсэн хүнтэйгээ иргэд амьд харилцаа үүсгэдэг юм билээ. Бодитой дэмжлэг надад байсан. Үүнийг санал хураах өдрийн сонгогчдын мессеж, залгасан дугаарын тоо гэрчилнэ. Бөөн бөөнөөрөө зохион байгуулалттай хүмүүс орж ирээд санал өгч байгааг сонгуулийн байранд ажилласан хүмүүсээс ч хэлж байлаа. Үүнийг хэлж байгаагийн шалтгаан нь нөгөө талаар өндөр хяналттай байж, олон зүйлд эмэгтэйчүүд маань суралцаж, өөрсдийгөө бэлдэх хэрэгтэй гэдгийг хэлэх гэсэн юм. Бид чинь эхчүүд учраас юманд уужуу тайван, харын сэтгэл байхгүй, бүх зүйл шударга болж байгаа гэдэгт итгээд орхихдог. Энэ нь эргээд алдаанд хүргэдэг юм гэдгийг ойлгосон доо.

**PLAYBOY:** Шүүхдэж болоогүй юм уу?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Бодолгүй яахав.

АН ялчихсан, тийм учраас цагийн гарз биз дээ гэдэг мессеж явсан. Улс төрийн ийм л муухай орчныг цэвэрлэх хэрэгтэй байгаа юм. Ганцаараа битгий хэл 10 уулаа тэмцээд ч үр дүнд хүрэхгүй, нийтээрээ тэмцэх хэрэгтэй. Эхчүүд, эмэгтэйчүүд зөв зохион байгуулалттай тэмцэлд орох л хэрэгтэй байна.

**PLAYBOY:** Эмэгтэйчүүдийн 25 хувийн

ҮРГЭЛЖЛЭЛ НЬ 99-р НҮҮРТ



Miss Mongolia














НЬЮ-ЙОРК ХОТЫН  
БРОНКСОС  
ГАРАЛТАЙ ГЭТТО  
ГАСТРО ГЭХ  
ГУРВАН ЗАЛУУТАЙ  
ТАНИЛЦЬЯ. ТЭД  
НЭГ БАГ БОЛОН  
ХООЛНЫ ЕРТӨНЦ  
ДЭХ ХАМГИЙН  
ЭРЧ ХҮЧТЭЙ  
ШИНЭЧЛЭЛИЙГ  
АВЧИРЧ БАЙНА.

ХЬЮ ГАРВЭЙ

ХООЛНЫ УРЛАГ

ДАХЬ

ШИНЭЧЛЭЛ





**Г**

это Гастро хоол хийхэд бэлэн боллоо. Нью-Йорк хотын намрын шаргал өглөө зөөлөн гал дээр бүйлсны сироп аажмаар халж байх зуур, хажууд нь буцлах цайны үнэр үнэртэй ус мэт сэнгэнэнэ. Гадаа байгаа саравчнаас саяхан татсан каннибасын үнэр аргил хоолой мэт түрэн орж ирнэ.

Энэ Лонг Айланд дахь байрыг "Hush House" гэдэг бөгөөд хип хопыг хоолны урлагтай

хослуулан буй хэдэн залуусын цуглардаг газар нь билээ. Хэдэн гал тогооны хэрэглэлээс өөр зүйлгүй энэ байранд гурван залуу савхин буйдан дээр сууна. Жон Грэй (John Gray), өөртөө ахлах аяга угаагч гэх нэр өгчээ. Урьд нь Загварын Технологийн Их сургуулийн оюутан мөн хувцасны загвар зохион бүтээгч байсан.

Лэстэр Уалкер (Lester Walker) бол булчинлаг, биеэ шивээсээр чимсэн залуу. Өөртөө "Хоол хийгч" хэмээн даруухан цол өгч. Уул нь Eleven Madison Park болон Jean-Georges гэх өндөр зэрэглэлийн ресторанд 2-р зэрэглэлийн ахлах тогооч байжээ. Харин Гэтто Гастро (Ghetto Gastro) буюу GG-ийн жинхэнэ нэрийг Малколм-Ливингтон (Malcolm Livingston) гэдэг. Жаахан хүүхэд шиг царайтай, зөөлөн дуу хоолойтой энэ залуу WD-50 гэх орчин үеийн хоолны газарт амттаны тогооч бөгөөд уг салбартаа нэлээдгүй амжилт гаргасан. Өнөөдөр Гэтто Гастро-ын амралтын өдөр парти хийнэ гээд төлөвлөөд сууж байгаа нь энэ. Партинд зориулан хөлдөөгчинд нь байгаа 3 кг стейкны махаар хоол хийж зочдоо дайлах төлөвлөгөөтэй байгаа.

"Урьд өдрийн арга хэмжээнээс үлдсэн хүнсийг бид хаядаггүй. Бид Робин Хүүд шиг найз нөхдөө дуудаад тэднийг дайлчихдаг юм" гэж Грэй хэлэв. Грэй найзууд руугаа мессэж бичээд мөн инстграмаар партинийхаа талаар мэдээлэл цацав. Тэр зуур Уалкер ерөнхий төлөвлөгөөгөө танилцууллаа: "Ногоогоо "Union Square"-ын ногооны захаас, "Pino" (махны дэлгүүр)-оос очиж мах, дараа нь Лобстэр Паласаас очиж хавч авна. Гэхдээ хаана юу байна харж байгаад л болно доо" гэв.

Маркетингийн хэлээр тайлбарлах гэж оролдвол, Гэтто Гастро бол байгууллагуудын тэмдэглэлт баяр ёслолыг уран мэдрэмжээр зохион байгуулагч гэж хэлмээр. Энэ гурван залууг таньж мэдэхгүй хүмүүс гаднаас нь хараад тэднийг хип хоп хамтлагийн дуучидтай андуурах нь олонтаа. Дээр нь тэд бүгд ижил хар футболка өмсдөг.

Нээгдээд жил хагасын дараа Гэтто Гастро ихэд завгүй байна. Залуус энэ хугацаанд продюсер Тимбэрландын CD-ний нээлт, "South by Southwest" гэх электрон тамхины нээлтийн оройн зоог, Францын Канн хот руу нисч "South of Bronx in the South of France" гэх мэт арга хэмжээг зохион байгуулжээ. "Бид олныг хамарсан мэдрэмжтэй үйл ажиллагааг гардан зохион байгуулахыг зорьдог. Яг театрт байгаа мэт мэдрэмж төрүүлэх хэрэгтэй. Бидний зохион байгуулсан үйл ажиллагаанд ирсэн зочид харсан үзсэн, мэдрсэн бүх зүйлээ насан туршдаа мартахааргүй байлгахын төлөө ажилладаг" гэж тэд ярилаа.

Тэд ханан дахь ирээдүйн төлөвлөгөөгөө "The Food Gangs of New York" хэмээн гарчиглаж. Үүнд Бронксд хоол зүйн боловсрол олгох шинэ штаб нээх, 36 Brix гэх зайрмагаа зах зээлд гаргах гэсэн ажил багтжээ. Энэ залуусын төлөвлөгөө нэлээн амбицтай санагдах боловч эднээс өөр хүмүүс уг төлөвлөгөөг хэрэгжүүлж чадахгүй мэт санагднам.

Дэлхийн гал тогооны дээд зиндаанд хар арьстан тогооч

багтаж чадсан нь ховор тохиолдол. Мөн өөрсдийн Гэтто (доод түвшний иргэд амьдардаг хороолол) хоолыг тансаг зэрэглэлийнх болтол нь хөгжүүлсэн нь бүр гайхмаар.

Заримдаа эдний хийсэн хоолноос нь илүү "cool" буюу аятайхан зан чанар нь уулзаж учирсан хүмүүст таалагддаг. Залуусын улаан фен нэг залуу "Тэдний яг юу хийдэг гэдгийг сайн мэдэхгүй ээ, гэхдээ тэд үнэхээр сайхан ааштай" хэмээн магтаж байсан удаатай.

Зар сурталчилгааны тэргүүлэх агентлаг болох "Mother"-ын ахлах ажилтан Жон Маккэйн анх Гэтто Гастрогын талаар сонсоод тэдэнтэй Францад хамтран ажиллах боломжийг олж харсан байна.

"Ирсэн зочдод тэд CEE-LO гэх тоглоом зааж өгсөн. Энэ тоглоом нь Нью-Йорк хотын ядуусын хороололд их алдартай тоглоом гэсэн" гэж Маккэйн тайлбарлав. "Зочдод Нью-Йоркоос гаралтай nutcracker гэдэг коктейль хийж өгсөн. Орой гэхэд зочид маань овоо халсан байсан шүү. Энэ үйл ажиллагаа тансаг харшид, хэн ч атаархмаар болсон доо. Гэтто Гастро түгээмэл соёлд шинэчлэл хийж, урьд нь байгаагүй өвөрмөц байдлыг мэдрүүлж байна" гэж Маккэйн нэмж хэллээ.

Матью Орландо гэх Копэнхагэнд байршилтай "Amass" рестораны ахлах тогооч хүртэл Гэтто Гастро-гийн цэвэр авьяас, гэрэлтсэн шинэхэн байдлыг хүлээн зөвшөөрч сайшаав.

Тэдний амжилтын томоохон нэг хэсэг бол: "аятайхан зан ааштай байх, өөрсдийн гарлыг сайн мэддэг бөгөөд үүнийгээ байнга санаж дээдлэх аж. Залуус Бронксоос гаралтай. Энд Грей дунд боловсролын гэрчилгээ авахаасаа өмнө католлик болон улсын сургуулиас хөөгдөж байсан. Тэр хар тамхи биедээ авч яваад баригдаж, дараагаар нь их сургуульд бүртгүүлж, ялаа хөнгөлөхийн тулд цалингүй ажил хийж байжээ. Төлөвлөгөө ч бүтэж, тэрээр хоёр жил хагасын дараа томоохон хоёр хувцасны брэнд болон чөлөөт хувцасны дэлгүүртэй түншилж ажилласан. Гэхдээ түүний хувцас зохион бүтээх сонирхол буурч эхэлжээ. "Ирээдүйд яаж амьдралаа зохицуулах вэ? гэж бодох болов. Ингэж л анх Гэтто Гастрог нээх санаа орж ирсэн байна.

Тэр хуучны найз болох Лестер Уалкертай уулзав. Лестер гэр бүл дотроо их сургууль төгсөн цорын ганц хүн бөгөөд "Johnson & Wales" их сургуулиас хоол зүйн мэдлэг эзэмшсэн байна. Малколм Ливингтон харин Грейтэй их сургуульд сагсан бөмбөгийн багт хамт тоглодог байжээ.

Төрж өссөн Бронкс нь тэдний хийдэг хоолонд маш их нөлөөлсөн. Ийм ч учраас каррибын амтлагч, хоол хийх франц арга барил болон хуучны англи сархдыг нэг меню дотор оруулж чаджээ. "Гана, Тринидад Табого, Хятад, Вьетнам, Жамайка, Пуэрто Рико зэрэг өөрсдийн уламжлалт соёлоор бахархдаг" гэж Грей хэлэв.

Хэдийгээр Ливингтон Нью-Йоркын шилдэг ресторонуудад тогоочоор ажиллаж байсан боловч улиг болсон хоолны хэвшлээс хөндийрч нээлттэй нийгмийн залууст тохирсон зах зээлийг олж харсан. Гэтто Гастрогын зохион байгуулсан үйл ажиллагааг соёл тогтоогч гэж болно. "Би ямар нэг ресторанд хоол идэхийн тулд нэг их гоёж, сайхан хувцас өмсөөд байхыг хүсдэггүй. Гэтто Гастрогийн үйл ажиллагаанд өмссөн хувцастайгаа ирж болдог. Хоол маань үнэхээр өндөр зэрэглэлийнх байна гэхдээ над шиг хувцасласан хүмүүстэй байгаа байдлаараа оройг өнгөрөөх нь хүмүүст таатай байдаг" гэж Грей онцлолоо.

Арван жилийн өмнө тогооч нарыг рок одтой зүйрлэдэг байсан бол одоо хип хоп одтой адилтгадаг болж. Жишээлбэл, Рой Чой гэх явуулын гуанзанд тако зарж бизнесээ тэлсэн Солонгос залууг Wu-Tang-тай зүйрлэх нь их. Гэхдээ энэ нь "фермээс шууд ширээ рүү" гэсэн уламжлалт ойлголтоос тэсийрч байна гэсэн үг бишээ. Манхэттанд, Union Square-ын хүнсний зах бол GG-ын ногоо худалдан авах дуртай газар. Залуус энэ захаас саяхан хураасан лууван болон хөрс үнэртсэн шинэхэн байцааг худалдан авна.

Тэд зах дээр Black velvet болон Brandywines гэх төрлийн улаан лоолийн ялгааны талаар ярилцана. Грей "шинэ ногоо Нью-Йоркын төвд төвлөрсөн байдаг. Хотын зах руу бол элсэн цөл л гэсэн үг. Дийлэнх шинэ ургац Бронксоор дамжин ирдэг, улаан лууван шууд Мэдисон Парк руу ачигддаг" гэлээ. Рипо гэх махны итали мухлагаас бид 15 кг галууны өөх, тахианы мөч мөн үхрийн мах авлаа. Гарахаар үүд рүү чиглэхэд худалдагч надаас "Энэ залуус реперүүд үү?" хэмээн асуулаа.

Манай залуус хүмүүсийн андуурах нь байдаг л үзэгдэл хэмээн тайлбарлав. Европт тэднийг хип хопчид юм уу сагсан бөмбөгийн тамирчид гэж андуураад байдаг гэнэ. "Уулзаад 30 секундний дараа таамаглал нь буруу болохыг тэд өөрсдөө мэддэг" гэж Лестер хэлэв. Энэ залуус бол яг байгаагаараа байдаг, тэдэнтэй уулзаад энэ чанарыг нь ойлгохгүй бол найзархах гээд хэрэг байхгүй хэмээн бодогдлоо.

Nash House дээр "WD-50 Line" гэх гал тогооны хэрэгсэл болон тэдний бартендер найз Жан иржээ. "Энэ коктэйлын санааг надад Елли гэх Пуэрто Рико гаралтай, хамт сургуульд сурдаг байсан залуу өгсөн юм. 40 прооф архийг аяганы 1/5 дүүргэж, Сосо Lopez-ын коконатын кремтэй зөөлөн хольдог. Өсвөр насныхны тархинд үүнээс илүү нөлөөлөх архи болон сахарын хольц байхгүй байсан даа" хэмээн Ливингтон дурсав.

Удалгүй тогооч гэх мэргэжлийн шинж чанар миний нүд чихэнд мэдрэгдэж эхлэв. Тэдэнд хоол бэлдэхэд тусалж буй залууг Пьер Серрао гэдэг. Олон ч ресторанд хоол хийж бүр дуучин Jay Z-ын хувийн тогоочоор ажиллаж байсан байна.

Серрао хэлэхдээ, "хоолны урлагт би энэ залуусаас үлгэр жишээ авдаг.


Ихэнхдээ залуус нэг нэгэнтэйгээ адил замаар явдаг бол надад GG залуусын хамтын ажиллагаа, хийж буй зүйл нь таалагддаг". GG залуусын ажилдаа өөриймсөг хандаж байгааг нь Серрао шиг үнэлдэг олон хүмүүс бий.


Гал тогооны ажил дуусч дуучин Sonos болон Wiz Khalifa-гын дуу өрөөнд цуурайтна: "We dem boys, hol up, hol up, hol up, we makin noise."

Шөнө болж хятадын хямд цаасан дэнлүү хашааг гэрэлтүүлнэ. Шүүслэг тахианы мөч гал дээр бэлэн болж, галууны өөхөнд шарсан төмсний салат, коунао өрөөстэй. Загвар өмсөгчид, бизнесмэнүүд болон GG залуусын гэр бүл, найзууд нь цугларчээ. Ирсэн хүн бүр коктэйль барьж, тэдний орон сууц Нью-Йорк хотын классик хаус парти болон хувирлаа. Amass-д ажилладаг Орландо залуус руу харангаа "энэ залуус маш нээлттэй сэтгэдэг, тийм ч учраас их олон хүмүүст хүрнэ. Тэр цагт чи бид хоёр өөрсдөөсөө яагаад ингэж их удваа хэмээн асууцгаана даа" гэв.









ХЯНАЛ ТАРАС

ГАРСАН

ДАНА ГАВАР



ОГТОРГУЙД МАРТАГДСАН НЭГЭН ГАНЦААРДМАЛ ХИЙМЭЛ ДАГУУЛ  
ДЭМИЙ 1 ХӨВӨН НИСНЭ. ХАРИН ДЭЛХИЙ ДЭЭР НЭГЭН  
МАРТАГДСАН МАКДОНАЛДС ДОТОР ХЭДЭН ГАВАЛ ТОЛГОЙТОН  
ТЭР ХӨЛГИЙГ АВЧИРХААР ТӨЛӨВЛӨЦГӨӨНӨ. ЮУ БОЛОХ БОЛ?

ПАТ ЖОРДАН



### ЭХНИЙ ӨДӨР

Үүдэн дээр зогсож байсан хамгаалагч намайг зогс гэж байгаа бололтой гараа өргөв. Түүний баруун гар ташаан дахь буугаа барьсан байв. “Ямар зорилгоор явна?” гэж асуув.

“Би макдоналдс орох гэсэн юм” гэтэл тэр гараараа даллаад, “Явуул” гэв.

Би Калифорни мужийн Сан Хосе хотод байрлах Нэгдсэн Улсын Сансар Судлал болон Удирдлагын станцын хажуугаар гарав. Барилгууд нь 1930 оны испани загвартай юм.

Тэнд маш том ногоон талбайд олон майхан барьсан байсан бөгөөд тэр хавьд хүмүүс ихэд бужигнаж байлаа. Би зогсож майхан дотор ороод хартал эрэгтэй, эмэгтэй залуу хүмүүс самбарын урд тайлан тавьж байгаа мэт зогсож байлаа. Дотор байсан ахимаг насны эрэгтэй өөрийн мэддэг зүйлийг ярьж өгч байгаа бололтой зогсоно. “Сансарын нислэгт зориулсан асаалт дэмжих бага мэдрэгчтэй хамгаалалт” “Биомэдрэгчид зориулсан карбон электрод” “Аллегин гений туршилтын микрогравитид хийсэн илрэл” гээд. Би замаараа хуучин онгоцны булш



болсон газраар өнгөрлөө. Тэнд F-18 байлдааны онгоц, U-2 онцгой өндрийн онгоц ба гэдэс хэсгээс нь хамаг эд анги нь цухуйсан пуужинг олж харав. Булшны ард макдоналдс харагдав. Шууд л үүдэнд нь машинаа зогсоогоод дотор нь оров. Лангууны ард байсан залууд “Том мак, шарсан төмс колатай авъя” гэхэд залуу инээснээ “дандаа л ингэх юмаа” гэсэн хариу өгөв. Лангуу дээр кассын машин байхгүй, хоол халаагч нь хоосон, төмс шарагч дотор нь шарсан төмс байхгүй, милкшейкний машин дотор сүү





жигжигхэн, нүдний шилтэй эр дэлгэц дээрээ баахан тоо ширтэж сууна. Ашгүй нэг тэнд сууж байсан өндөр залуу над руу зүглэв. Би энэ юун тэмдэг болохыг нь асуухад, тэр ирээд, "Наадах чинь бидний билэг тэмдэг юмаа, бид сансар судлалын хэдэн хүмүүсийг цуглуулаад, зөвшөөрөлгүй төсөл дээр ажилладаг юм" хэмээн тайлбарлав.

Дэннис Винго ба түүний намхан хамтрагчийг Кит Ковинг гэдэг бөгөөд тэд цугтаа "SKYCORP INCORPORATED" гэдэг компанийг ажиллуулдаг. Тэдний баг болох сансар судлаач нар NASA-гын үлдээсэн төсөл дээр ажилладаг байна. Тэд өөрсдийгөө "техникийн үлдвэр" судлаачид гэж нэрлэдэг. Тэд NASA-гийн хаясан сансрын хөлгийг олж ухдаг байна. Sky-corp компани 30 жилийн өмнө NASA-д сансрын хөлгөөс ирсэн мэдээллийг шинжилдэг. Голдуу тэр мэдээллүүдийг NASA тоохгүй орхисон аль эсвэл хэтэрхий их хөрөнгө шаардсан учраас анхаарал хандуулаагүй орхисон байдаг байна. Уг байгууллагад ажилладаг хүмүүс ямар ч дата мэдээллийг бурхан мэт шүтнэ. Тэд нарын олсон мэдээлэл орчин үед падлийгүй байсан ч хамаагүй тахин шүтнэ дээ. Энэ мэдээллээ ирээдүйд ямар нэгэн утга учир нээнэ гэдэгт итгэдэг. Тэр өдөр тэд "International Sun/Earth Explorer 3" буюу ISEE-3 гэх 1997 онд NASA-гийн орхисон хиймэл дагуулыг нарны тойрог замаас холдуулах ажиллагаа дээр ажиллаж байв.



хүртэл байхгүй байлаа. Таахнээ энэ макдоналдад хүн орж ирээгүй удсан бололтой. Үнэхээр хүн орж ирэлгүй 7 жил болжээ.

Энэ хоолны газрын байрыг хямдхан түрээсийн байшин болгон өөрчилсөн юм байна лээ. Тэнд маш олон дээр үеийн компьютер, шкаф шиг том эргэлддэг кассет уншигч машин байлаа. Тэнд байсан бүх зүйлс хуучин, тоосонд дарагдсан нэлээн засвар шаардсан байдалтай. Тоног төхөөрөмж нь бүгд "элэг бөөрийг" нь гаргасан, янз бүрийн утас шөрмөс унжсан, бас скочдож янзалсан харагдав. Цонхон дээр том далайн дээрэмчдийн туг унжуулжээ. Бас МАККУУНС гэсэн бичиг өлгөөстэй. Хоолны өрөөнд тавь гарч байгаа бололтой хоёр эр компьютерийнхаа дэлгэцэнд наалттай. Энэ хоёрын арай өндөр нь Skure-аар нэг хүнтэй ярьж байв. Нөгөө нь шувуу шиг

Уг хиймэл дагуул нарыг тойрон 36 жил нисч байгаа бөгөөд, сүүлийн 17 жилд бүрмөсөн хаягджээ. Харин 2014 оны 5 сард "SKYCORP" хиймэл дагуултай холбоо тогтооход, "хариу" өгч эхэлсэн байна. Амьхандаа хиймэл дагуул "би амьд байна аа, Хэн ч намайг хүсэхгүй байгаа юмуу" гэсэн хариу өгөхөд SKY-CORP өөдөөс нь "Бид чамд одоо ч гэсэн хайртай" гэж хариулжээ. Дөрвөн долоо хоногийн дараа бүх зүйл төлөвлөснөөр болох юм бол, "SKYCORP" хөөрхий ISEE-3 хиймэл дагуулыг дэлхий дээр буцаан авчрах төлөвлөгөөндөө орлоо. Хэрвээ уг төлөвлөгөө бүтэх юм бол Макмүүн дээр том парти хийж анх ISEE-3 хиймэл дагуулыг дэлхийгээс хөөрөхөд чухал нөлөө үзүүлсэн эрдэм шинжилгээний ажилтнуудыг урих төлөвлөгөө гаргасан байв.

ҮРГЭЛЖЛЭЛ НЬ 101-р НҮҮРТ



# ОРЦОНД ТАСАРСАН БҮСГҮЙ

/ӨГҮҮЛЛЭГ/

Эмэгтэй хүний бачимдан хашгирах дуунаар шөнө дөл болтол “айпад”-аа “тэврэн” хэвтэж байсан би цочин бослоо. Халаадаа нөмрөөд үүд рүү очиход хаалганы цаана эмэгтэй хүний арга ядсан дуугаар мэгшин уйлах дуу сонсогдоход хаалганд чихээ нааж, хэрэгт дурлав. Уйлах эмэгтэйтэй хамт нэг эмэгтэй хүн, нэг эрэгтэй хүн ярилцаад байгаа сонсогдов. Дурангаараа харах гэтэл хэн нэгэн байрны дэггүй багачууд бохь наагаад “бөглөж” орхижээ. “Хаалганы хонх дуугаргаад амар заяа үзүүлэхгүй нь ээ. Цагдаа дуудаад өгчихвөл яасан юм бэ?” гэж эмэгтэй хүн хэлэхэд эрэгтэй хүний аргил бүдүүн дуу гарч “Ингээд орхисон нь дээр. Цагдаа ирвэл “ухаж төнхөөд” шал балай юм болно” гэж цааргалах ажээ. “Чам муу “банзлаас” хамаг хэрэг үүсэж байгаа юм. Зүгээр мөрөөрөө явахгүй хаа явсан газраа охид хүүхнүүдийн толгой эргүүлж явдаг дүүрчихсэн хулгайч шүү. Би унтаж амармаар байна шүү. Энэ муу сэгсийсэн алмасаа эндээс түргэн зайлуулаач чи” гэж эмэгтэй хоолой нь хянтан хэлэхэд эрэгтэй нь цаад эмэгтэйд хэлж байгаа бололтой “Чи яасан хүний амьдралд гай болсон новш вэ. Эндээс хурдан далд ор” гэж хөөх аж. “Яваач ээ тэнэг ээ, битгий хүнд гай болоод бай. Босооч. Хурдан зайлаад өг” гэж эрэгтэйд зандрахад эмэгтэй нь хажуугаас нь “Чи одоо хэнд эрхлээд байгаа юм бэ? Наад залуу чинь миний нөхөр. Чам шиг хөдөөний сайран хацартад олдохгүй сайхан залуу. Дахиж “нүдүүл” гээгүй юм бол нүднээс хурдан далд ор” гэж давшила. Нөгөө бүсгүй нь босохгүй байгаа бололтой уйлаад байх юм. “Өргөөд доошоо шидчих. Яасан хүний үгэнд ордоггүй дургүй хүргэсэн хог вэ. Алив, Буянаа, дороос нь өргө... Новш минь чи юу гэж далимдуулаад байнаа?” “Яасан юм бэ? Санаандгүй мөөмөнд нь хүрчихлээ”

Арай доошоо шат руу шидэхгүй байлгүй дээ гэж бодож байтал түсхийгээд шат руу бүгдээрээ өнхөрч унах сонсогдов. Ёо ёо гэж зэрэг орилдоод, нуруу бөгс гэж хараах дуулдана. Тэр хооронд би хаалгаа хурдан онгойлгоод дуранд наасан бохийг авч амжлаа. Шатны

доошоо харвал тэр дор хүмүүсийн хүндээр амьсгалах, хараал зүхэл болох дуу хадна. Хаалганы дуугаар эхнэр нөхөр хоёр “Хүн гарч ирэхээс өмнө гарч зугатъя. Энэний толгойноос цус гоожиж байна” гэж хэлэх сонсогдлоо.

Шат тожигнуулан тэднийг доош “зугатсаны” дараа би бүрэн чөлөөтэй болж шатны дор орцны хана түшин ёолох бүсгүйг олж харав. Задгай унжих өтгөн хар үснээс нь улаан цус нүүр рүү нь олгойдон урсана. Ийм юм харсан эмэгтэй хүн яаж зүгээр байх вэ дээ. Би бүсгүй рүү очиж “Яаж байна? Босож чадах уу? Манайд ороод цусаа цэвэрлэ” гэж гуйлаа. “Зүгээр ээ, намайг орхи.” “Юу ярьж байгаа юм бэ? Толгойноос чинь цус гараад байна. Цус алдаад үхвэл яана” “Хамаагүй хамаагүй. Чи намайг орхи. Үхсэн нь дээр надад...”

“Чи ингэж болохгүй. Манайд ороод цусаа тогтоохыг бод. Босох гээд үз дээ” гээд би түүнийг хүчээр татлаа. Надаас нэг олон насаар эгчгүй тэр бүсгүй лав хорин гурваас хэтрэхгүй. Харин өндөр нуруулаг болохоор хүнд юм аа. Ер нь махлагдуу талдаа шүү. Их эршүүд ажээ. Намайг сугадан босгох гэж хамаг хүчээ шавхаж байхад нэг гараараа шал тулаад өөрөө босоод ирлээ. Түүний дэргэд бол би хариугүй хүүхэд шиг намхан байлаа.

Бүсгүй миний тусалцаагүй хана түшин алхсаар гэрт минь орж ирэв. Хаалгаа дангинатал түгжсэнийхээ дараа би бүсгүйг дагуулан усны өрөөндөө орлоо. Түүнийг хүйтэн усаар толгойныхоо цусыг шавших хооронд би марль хөвөн олж ирэв. Учир явдлыг нь оньсого шиг тааварлаж ядан байсан би толгойгоо хананд хэгз цохиулсан бүсгүйг дотроо өрөвдөж байлаа. Цусыг нь тогтоож толгойг нь боож өгөөд цус болсон цамцыг нь тайлуулж угаагаад, банны өрөөний хэцэн дээр байсан ахынхаа угаасан цамцыг өмсгөв.

Хэдэн хормын дараа бид хоёр гал зуухны өрөөнд өөд өөдөөсөө харан халуун кофе ууж суулаа. Одоо тэр бага зэрэг тайвширсан боловч нүдний аньсган дээр нь нулимс гялтагнаад, мяраалаг том хөхтэй цээж нь

уралдааны морь шиг түхэлзэн амьсгаадна. Гил хар үстэй, торомгор том алаг нүдтэй бүсгүй ажээ. Түүний сэтгэлийн шаналан далайн хар шуурга цунамигаас дутахгүй “шуурч” байгаа даа гэж бодсон би орцонд юу болоод өнгөрсөнийг асууж зүрхэлсэнгүй.

Кофе ууж, бас миний найрсаг занд талархсан бүсгүй хэсэг чимээгүй сууж байсанаа өөрөө яриа өдлөө. Тэр нилээд аманцар бололтой гал зуухыг эргүүлэн тойруулан харсанаа,

-Гал зуухаа сайхан тохижуулжээ гээд миний зүг сайхан алаг нүдээрээ тунаран харж,

-Чи гэртээ ганцаараа байгаа юм аа гэлээ.

-Тиймээ. Ганцаараа...

-Нууц биш бол чи хэдүүлээ амьдардаг юм бэ?

-Ахтайгаа хоёулаа.

-Ах чинь байхгүй байгаа юмуу?

-Байхгүй. Ах хөдөө уурхайд ажилладаг юм.

-Чи оюутан уу?

-Тиймээ, сурч байна.

-Чи энэ хажуу айлаа сайн мэдэх үү?

-Хорин таван номер уу?

-Тиймээ, хорин таван номер...

-Авгай нь саяхан төрсөн шүү дээ. Нэг ах эгч хоёр амьдраад хэдэн жил болж байна.

-Өөр хүмүүс байдаг уу?

-Байсан юм аа. Энэ Буянаа ахын хадам аав ээж хоёр байсан л даа. Гурван жилийн өмнө хөдөө явж байгаад машинтайгаа осолдож, нас барцгаасан. Хуучны хур хөрөнгөтэй баян хүмүүс байсан гэж хүмүүс ярьдаг. Хүргэн хүүтэйгээ таардаггүй байсан тул хүргэн хүү нь машиныг нь засах нэрээр нэг “муу юм” хийчихлээ гэгцээдэг. Уулын уруу гэнэт тооромсоггүй болоод эрчээрээ өнхөрсөн гэдэг... Гэхэдээ би сайн мэдэхгүй. Байрны хүмүүс эд нарт жаахан дургүй байдаг юм. Юунаас болоод тэгдэгийг нь ч би мэдэхгүй. Гаднаас нь харахад нүдэнд дулаахан л хосууд байдаг гэж би түүнд хамаг мэддэгээ ярилаа.

Гэвч Буянаа ахын надтай тааралдах болгондоо талимаарсан харц шидэж “Орцны гүнжээр юу байна даа?” гэж инээмсэглэдэгийг хэлсэнгүй. Заримдаа ментолтой бохь халааснаасаа гаргаж өгдөгийг дурьдсангүй. Надтай нас ойролцоо энэ залуу бүсгүйгийн толгойг “эргүүлж” ямар нэгэн муу зүйл хийсэнийг гадарлаж эхэлсэн тул бүсгүйг Буянаа ахтай “танилцсан” түүхээ хуучлахаас өмнө тэр хүнийг “ямар муухай хүн бэ?” гэж хар буусан байсан юм.

-Орой болжээ. Хоноод яв даа гээд би түүнд ахын орны даавууг сольж ор засах гэтэл бүсгүй,

-Танихгүй хүний орон дээр унтаад яах вэ. Хэрүүл уруул хийж яваа хэсүүл хүн эр хүний орон дээр унтаж таарахгүй. Чи шалан дээр дэвсэх юм шидчих. Хөдөөний бориг надад нөмрөөд хэвтвэл юу ч байсан яах вэ гэж татгалзав. Би орныхоо өмнө гудас дэвсэж түүнд унтах газар бэлтгэв. Орондоо ороод гэнэт мартсанаа санасан мэт би,

-Толгой чинь өвдөж байна уу? Анальгин бий шүү гэхэд тэр тоосон шинжгүй,

-Зүгээр дээ, толгой өвдөх нь гайгүй байна.

Харин зүрхний эм байвал... гэж зөөлөн асуув.

-Зүрхний эм гэж харин байхгүй шүү. Ах бид хоёр тийм эм хэрэглэж үзээгүй гэхэд

-Ах чинь хань ижилгүй залуу хүн үү? гэж бүсгүй эмэгтэй хүний зангаар сонирхов.

-Би хорьтой, ах гуч хүрч байгаа. Миний ах чинь сайн хүн шүү дээ. Хөдөө уурхайд экскаватор барьдаг хүн.

-Уучлаарай, ахаас чинь өөр хүн байдаггүй юмуу?

-Аав ээж минь намайг аравтай байхад өнгөрсөн юмаа...

-Уучлаарай... Миний ээж ч гэсэн өнгөрөөд удаж байна. Аавтайгаа л хоёулаа хүн шүү дээ. Ээжээс хойш аавын архинд донтох нь тэвчишгүй болсон. Нээрээ, хоёулаа танилцаагүй байгаа юм байна шүү дээ. Намайг Энхмаа гэдэг. Чамайг?...

-Ямар сонин юм бэ? Бидний нэр ойролцоо юм аа.

-Бас Энхээ юу?

-Үгүй ээ, тун ойролцоо. Энхриймаа гэдэг.

-Нээрэн, ямар адилхан юм бэ? Энхмаа,

Энхриймаа... Чи унаган хотынх уу?

-Тиймээ би хотынх...

-Би бол Сэлэнгийн охин доо. Манай сум төмөр замын өртөөтэй болохоор явуулын хүмүүс их явдаг газар. Архи спирт тасрахгүй. Аавын архи уудагыг болиулах гэж би их хөөцөлдсөн. Сүүлдээ дийлэхгүй болоод зөнгөөр нь орхисон л доо. Аав комбайнчин хүн болохоор жилийн гурван улиралд “салгалаад” комбайн, трактор бариад тостой хутгалдаад явна. Ажилгүй үедээ нөгөө шилтэй цэнхэртэйгээ “найзална” шүү дээ. Хэлээд үгэнд орохгүй хүнийг үхэхгүй амьд мэнд явбал боллоо гэж бодох болсон.

Ээжээс хойш би сургуулиа орхиод үнээ малтай “зууралдсан” хүн. Хэдэн гахай, тахиатай. Аав хүнсний ногоо тарина. Тэр бүгдийг боловсруулж, хадгалж, борлуулж худалдах хамаг ажлыг би хийнэ. Эхлээд ганц эмэгтэй хүн хэцүү байсан л даа. Яваандаа тэгээд сурчихсан шүү... Өртөөний дэргэд дэлгүүртэй. Сүү, цагаан идээ, ааруул хурууд, төмс ногоо, дарсан жимс жимсгэнээ худалдана. Өртөө зөрлөгтэй тул суудлын вагон зогсох хооронд овоо хэдэн төгрөг олно. Ноднин жилээс би өөрийн нэр дээр хоршоо байгуулсан юм.

Жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжих төсөлд багтахаар хотоос ирсэн төлөөлөгчидтэй очиж уулзахаар сумын буудалд очлоо. Тэнд би нүдэнд дулаахан, биерхүү өндөр залуу олж харсан нь энэ Буянаа билээ. Нутгийн давжаа, хөөрүү залуучуудыг бодоход жинхэнэ эр хүн шиг харагдсаныг нуугаад яах вэ. Эр хүн болохоор намайг хараад сээтэн хаяж байгааг би ч нэг муу юм мэдэлгүй дээ. Тэгэхээс







тэгэх гэсэн шиг наалинхайтан аашилж, Буянаагийн сэтгэлд "итгэл" төрүүлээд орхилоо.

Хоёр хоногийн дараа үнээгээ сааж байтал Буянаа машинтай давхиж ирлээ. Тэр хоёр хоногт би ч түүнийг үгүйлсэн юм шүү. Хэзээ ч хүнд уруу татагдаж байгаагүй би эрэгтэй хүнийг чин зүрхнээсээ тэгж хайрлана гэж огт бодоогүй. Царайлаг, соёлтой, албаны "том" хүн. Миний амьдрал аж ахуйтай танилцаж, хэд хоног манай гэр, ногооны талбай, дэлгүүрээр эргэлдэж, найз хүүхнүүдийн минь нүдийг "бүлтийлгэв". Найз хүүхнүүд маань намайг төрөл арилжтал будаж гоодож, тэрийгээ өмс, энийгээ соль гээд намайг нийслэл хотод миссийн тэмцээнд явуулах гэж байгаа юм шиг хөл хөөрцөг боллоо.

Миний "буянаар" найз хүүхнүүдийн маань хоёр нь "төсөл"-д хамрагдаж, зээл авахаар болов. Би ч түүнийг гэртээ ирэхэд байгаагаараа зочилж, ааваар хонь гаргуулж, тогооны хорхог амсуулав. Аавд архи өгч "авилгадаад" Хараа руу загасанд явуулж, тул загасны махаар дайллаа. Аав ч "хүндэт зочны" хөлд хэд хоног нэвширтэл уув. Түүнийг явахад би найз хүүхнүүдтэй нийлэн "үдэн гаргалтын бяцхан цайллага" зохиож, дарсан жимс, ногоо, өөрсдийн гараар "нэрсэн" нэрмэл ч өгч явууллаа... Түүнийг явсанаас хойш би сэтгэл минь гэгэг гэгэг хийгээд хэдэн өдөр газар олж гишгихгүй, зүрх минь хөөрөн булгилж байсан юм.

Арайхийн тайвшраад ажил төрлөө эрхэлж явтал тэр над руу утастадлаа. Аймаг дээр ажлаар ирсэн гэнэ. Намайг ирж уулзаач гэж урилаа. Зээл авч, гурван хүн ажилдаа туслуулахаар авсан би барьж байсан үнээний фермийн дулаан саравчаа дуусгалгүй орхиод, хамаг өөдтэй хувцсаа сольж өмсөөд аймаг руу гарч одов. Түүний буусан буудал руу таксигаар очиж явахадаа би өөрийгөө удирдан зогсоож чадахаасаа өнгөрсөнөө мэдсэн юм. Ой ухаан минь "хяналт"-аа алджээ. Зүрх минь түүнд тэмүүлж байсан болохоор төрсөн биеэ түүнд "тушаахаас" бэлэн амьтан буудлын хаалгаар орлоо.

Тэр надад зориулж өрөөндөө ширээ засчээ. Алим, жимс, чихэр чавга, мэдээж миний аавын хайр зарласан чамин савтай архи. Эмэгтэй хүн гэхэд хар бор ажилтай багаасаа зууралдаж өссөн болохоор миний бие хаа ч хадуун, зан ааш ч хурц юм. Барагтай эрийг сээтэн хаяад байвал "нульдаг" амьтан. Нуруу өндөр болохоор жаахан махлаг нь мэддэгддэггүй. Миний нүдэнд нутгийн тоодгор дээлтэй харчуул дэнгийн эрвээхэй шатдаг тул эмэгтэй хүний "зэвсэг" болсон наалинхай нүдээ тормолзуулаад... тэр ч миний нүдэнд татагдсанаа яриад... их л дотно үдшийг өнгөрөөв.

Түүнийг намайг үнсэх гэж ойртоход нь би ичээд золтой л түүнийг сандал дээрээс түлхээд унагаачихсангүй. Уухаа болбол би "ус" шиг ууна. Харин согтохгүй. Нүд нь талимаараад инээгээд суудаг билээ. Эмэгтэй хүнийг нутгийн эрчүүд согтоож байгаад хэргээ бүтээдэг гэдгийг мэдэх тул муу санаалаад согтдоггүй юм. Харин гэнэт ирсэн гэнэн хайр минь нүдийг минь сохиолж, ухаан бодлыг урвуулаад хаячихжээ. Утаанд угаартсан хүн шиг эргүүтэж өгсөн.

Нэг хартал надад хайрлан дурлахын "онолын хичээл" зааж байсан хайрт залуу минь "тасраад" уналаа. Түүнийг өргөж оронд нь хувцсыг нь тайлан хэвтүүлээд түүнийхээ цэвэрхэн царай, шулуун хамар, өтгөн хөмсөг, нүдний дор байх хар мэргийг бахархан ширтэж хэвтсэн би өөрөө "нам" унтжээ. Нойрон дунд л нэг уухчиж амьсгаадсан дуу... Бурхан минь тэр намайг нүцгэлээд үг зүггүй амьсгаадан, үнсэж үлгэнэ... "Би хүнтэй унтаж үзээгүй шүү дээ. Үзээгүй" гэж би нулимс дуслуулан хэлж байсанаа санадаг.

Өглөө сэрэхэд минь тэр босож хүйтэн ундаа ууж суусанаа хөнжлөө сөхөж, цусан толбо болсон орны цагаан даавууг заан инээмсэглэнэ. "Биеийн юм чинь ирсэн юмуу?" "Зүгээр байгаарай. Чиний хийсэн ажил. Согтоод унахад минь чи ашигласан байна шүү дээ" "Тэгвэл чамайг шалганаа" "Шалга шалга. Шалгалтанд би бүдрэхгүй"... Тэр миний эрхтнээр оролдож, тэгэх бүрд нь би дуу алдаж... Учлаарай. Би хамаа намаагүй ярьдаг хүн шүү дээ. Гэхэдээ би чамд итгэж байна. Тэгж би "хүүхэн" хүн болж, эрэгтэй хүнтэй анх ойртсон минь тэр. Халуун янаглал, хайрын далайд умбасан би энэ хэдэн хоног савангийн үнэр шиг арилаад өнгөрсөнийг анзаарсангүй.

Түүний ярьж байсан, хэлж байсан үг үсэг бүрт итгэж байлаа. Тэр эхнэрээсээ салаад жил болж байгаа гэж ярьсан. Надтай амьдаръя. Удахгүй чамайг хот руу дуудана. Эхнэртээ байраа өгсөн тул одоохондоо найз нөхдөөрөө хоног төөрүүлж байна. Өөрийн гэсэн байртай болоод хөдөө газрын үзэсгэлэн гоо чамайгаа үүрд хайрлан амьдарна гэж хэлсэн. Жинхэнэ монгол бүсгүйчүүд хөдөө л байдаг юм байна. Зоримог, хатуужилтай, үнэнч ариун сэтгэлтэй, эрүүл чийрэг бие махбодтой, үнэхээр эйр хүнд хань болж, өмөг тшиг болох бурхны охид байна. Тэр дотроос хээрийн зэрлэг жимс шиг чиний ааг амт, уруулын бал энэ хорвоод миний амталж үзээгүй, огт мэдэрч байгаагүй шинэ мэдрэмж, исгэлэн гашуун улаалзганаас өөрцгүй анхилам амттай. Хотын хүүхнүүд бол туниа муутай, яагаа ч үгүй өвчин ярьсан, ёолсон ярвайсан, гоёлж гангалж, хов ярихаас өөр юмгүй юмнууд байдаг юм. Ямар азаар би танай суманд ирж, ямар тавилангаар би чамайгаа олж авав аа гээд тэнгэрт өргөтөл намайг магтдаг байлаа.

Түүний томиллолт дууссан тул тэр намайг бүхлээр нь залгичих шахан үнсэж долоож, бараг уйлчихсангүй эргэн эргэн харсаар толгойгоо унжуулан явсан юм. Гэртээ хариад би түүний үгийг дахин дахин санаж, түүний ирж авахыг хүлээлээ. Биеийн юм маань ирэхээ больсон тул эмчид үзүүлээ. Хоёр сартай жирэмсэн болжээ. Хүүхдээ төрөхийг хүлээгээд хайрт түүнийгээ ирэхийг хүлээгээд хэдэн сар өнгөрөв. Тэр явсанаасаа хойш утсаар огт ярьсангүй. Ямар нэгэн юм болж дээ гэж муугаар бодон шөнө орондоо уйлж унжина. Хавар нь би өвөл хүйтрэхээр дутуу орхисон үнээний фермийн саравчаа засаж байгаад саравчин дээрээс хальтирч унаж, хүүхдээ зулбачихлаа. Төрөхөд ганц хоёр сар дутуу байсан юм шүү дээ. Эмнэлэгт очоод хүн болсонгүй өнгөрсөн.

ҮРГЭЛЖЛЭЛ НЬ 90-р НҮҮРТ

# NOMIN

Ганболдын Номин нь дунд сургуульд сурч байхаасаа л загварын шоу, уралдаан зохион байгуулахад багш, сурган хүмүүжүүлэгч нартаа байнга тусалж, санаачилж, оролцдог дуу бүжиг, соёл урлаг, кино жүжигт их сонирхолтой охин байжээ. Тэрээр энэхүү төрөлхийн авъяасаа олон жилийн тууштай хөдөлмөр, шургуу зүтгэлийнхээ эцэст гоёл, загварын ертөнцийн өндөрлөг болох Mercedes Benz Fashion Week (MBFW) New York-т шоу продюсерийн нэр хүндтэй үүргийг гүйцэтгэн мэргэжлийн түвшинд дэлхийн дэлгэцэнд хүргэж байна.

Ээжийнхээ хөдөлмөрч, тууштай занг нь эрхэмлэн мэргэжлийг нь өвлөхөөр шийдэн Boston хотын Newbury College-д банк, санхүү, эдийн засгийн мэргэжлээр суралцаж баклаврын зэргээ 2009 онд амжилттай хамгаалжээ. Удалгүй загвар өмсөх ажлын завшаан гарсанаар багын хүсэл мөрөөдлөө биелүүлэх гараагаа модел, жүжигчин, бүжигчнээр эхэлсэн юм. Үүний зэрэгцээ тэрээр хүлээн авалт, арга хэмжээ, шоу наадам зохион байгуулах (show producer) мэргэжлийн зэрэг 2011 онд хамгаалж 2010-2012 онуудад Boston хот орчимд 40 гаруй шоу зохион байгуулжээ. Түүнчлэн Asian Boston Models & Talent Agency болон Boston Fashion Awards гэх мэт нэр хүндтэй агентлагт уралдаан, шалгаруулалтад удаа дараалан уригдан шоу зохион байгуулах, удирдах, хөтлөх, менежмент хийх зэргээр ажилласаар ирсэн. Загварын ертөнцийн урлагийг бүтнээр нь ойлгож, моделийн зөв алхалт (catwalk)-аас эхлэн бүрэн ижил хувцаслалт (styling), нүүр будалт (make up), дизайнер сонголт, файшн шоу зохион байгуулах (producer) хүртэлх бүх нарийн ажлыг гартаа авч чадсан тэрээр "Nomi G Productions" компаниа 2011 онд нээжээ. Компанийн гол зорилго нь олонд танил болоогүй, дөнгөж гарч ирж буй, ялангуяа Монголын авъяаслаг загвар өмсөгч болон зохион бүтээгчдэд бүх талын боломж олгох юм.

Nomi Ganbold нэрээрээ алдаршиж, загварын хүрээг нь тэлсэн Boston хотоо 2013 онд орхин дэлхийн гоёлын нийслэл болох New York хотыг зорин нүүж ирсэн нь энэ салбартаа илүү их амжилт гаргаж чадах хүний алхам яах аргагүй мөн билээ. Угийн сэргэлэн, хичээнгүй зангаараа төдөлгүй 2 ба 9-р сард жилд хоёр удаа болдог New York Fashion Week (NYFW)-т хөлөө олон байр сууриа эзэлжээ. Тэрээр 2013 оноос NYFW-ийн олон нийтэд нээлттэй хувилбар болох Couture Fashion Week (CFW) New York-т International Casting Director буюу олон улсын загвар зохион бүтээгчдийг олох, сонгох, шалгаруулах ажилд уригдан ажиллаж эхэлсэн юм. Энэхүү хүндтэй үүргийг биелүүлж байхдаа Номин маань Монголоос загвар зохион бүтээгчдийг дэлхийд гаргах юмсан гэсэн Монголч сэтгэлээрээ Катя Золыг уриж авчиран түүнийг дэлхийн гоёлын давцанд анх гаргаж ирсэнийг хүн бүр төдийлөн сайн мэддэггүй байж магад.

NYFW-н олон нийтэд хаалттай, зөвхөн нөлөө бүхий хүмүүс, алдартнуудын хамрагддаг MBFW New York бол загварын ертөнцийн оргил нь билээ. Swagunir ([www.swagunir.com](http://www.swagunir.com)) хэмээх амьдралын хэв маяг бренд (lifestyle brand) компанид Chief Operations Officer (COO) буюу модел, жүжигчин, загвар шалгаруулагч, шоу зохион байгуулагч ажлуудыг гарамгай удирдаж байсан Номинд маань 2015 оны хаврын MBFW New York-т загвар зохион бүтээгч шалгаруулах, улмаар түүнийхээ цомгоор (collection) бүтэн шоу хийх урилга ирсэн юм. Тэрээр Умард болон Өмнөд Америк, Европ, Ази, Австралын 100 гаруй загвар зохион бүтээгчдээс нарийвчлан сонгох, шалгаруулах, урих, шоу продюсер хийх хүндэт боловч хүнд хариуцлага хүлээсэн билээ. Олон сарын уйгагүй хөдөлмөрийн эцэст, Баярхүүгийн Баярмаагийн MONGOL нэртэй үслэг эдлэл, ноос ноолууран бүтээгдэхүүний бренд ([www.mongol-brand.com](http://www.mongol-brand.com))-г сонгосон нь Номингийн Монголоо гэх сэтгэлийнх нь дахин нэг илрэл яах аргагүй мөн. Тэрээр өөрийнхөө New York дахь загварын нэр хүнд болон авхаалж самбаагаа ашиглан MBFW-н хамгийн том танхим (майхан) буюу Theatre хэмээх тайзыг хамгийн эрэлт хэрэгцээтэй өдөр буюу Баасан гариг (MBFW-н 2 дахь өдөр)-т тусгаарлан авч чадсан нь том амжилт юм. Учир нь энэхүү тайзыг MONGOL брендээс гадна бусад өдрүүдэд нь зөвхөн ВСВГМАХАЗРИА, LACOSTE, CAROLINA HERRERA, BADGLEY MISCHKA брендүүд л шоугаа хийх эрх авсан гэдгийг дурьдахад илүүдэхгүй биз ээ. (<http://newyorkfashionweeklive.com/NYFW-Live/new-york-fashion-week-2015-schedule>). Тиймээс Номингийн маань хүлээсэн үүрэг, хүч чармайлт нь дэлхийд алдаршаад олон жил болж байгаа, хүн болгоны өмсөж зүүх дуртай брендүүдийн шоу зохион байгуулалттай дүйцэхүйц мөр зэрэгцэж байгаа гэдэг нь ойлгомжтой. Одоо Номин маань удахгүй болох шууныхаа бэлтгэл ажилд нойр хоолгүй зүтгэж маш завгүй хөдөлмөрлөж байгаа нь мэдээжийн хэрэг. Номин ба түүний багт амжилт хүсье!



Photographer: Thomas Concordia  
Makeup: Wenya Chang  
Hair: Corey Tuttle  
Stylist: Alisha Crutchfield  
Location: Hayden5 Studio



Gold mask  
Spider web ring by Ayaka Nishi  
Abby Carnevale earrings



Abby Carnevale earrings  
Baci Lingerie, White Label Collection, Style 3043,  
baby pink soft cup mesh  
bra, panty and garter belt set.  
Butch Diva vintage bolero  
Wolford thigh highs



Baci Lingerie, White Label Col-  
lection, Style 3043, baby pink  
soft cup mesh  
bra, panty and garter belt set.  
\*Face Mask

Baci Lingerie, MASQ Collection,  
Style EM10, Innocence Lost



Eve's Temptation bra and panty  
Body Binds bodywear  
Stella Hues gladiator boots  
Marc Bouwer ears

ORANGE  
www.orange.com



Sonja Baram coat  
Chanel pearl necklace  
Stella Hues shoes

# PLAYMATE-Н БЯЦХАН ЕРТӨНЦ



Нэр: \_\_\_\_\_ Ганболдын Номин \_\_\_\_\_

Жил: \_\_ЛУУ\_\_\_\_\_ Орд: \_\_МАТАР\_\_\_\_\_

Төрсөн газар: \_\_\_\_\_ Улаанбаатар, Монгол \_\_\_\_\_

Өндөр: \_170\_\_ Жин: \_51\_\_ Биеийн харьцаа \_\_32В-24-34\_\_\_\_\_

Хобби: \_\_Ном унших, биеийн тамираар хичээллэх\_\_\_\_\_

Хэлэх дуртай үг: \_\_Боломжгүй зүйл гэж үгүй бүх зүйл зөвхөн хувь хүн өөрөөс нь шалтгаална

Ирээдүйн зорилго: \_\_Өөрийн компаниа улам өргөжүүлэх, бэлгийн хүчирхийллийн эсрэг, хүйсийн эрх тэгш байдлын төлөө эерэг өөрчлөлт хийхэд эмэгтэйчүүдэд тусалж дэмжих, Монгол АНУ-ын хооронд загварын болон энтертайнмент салбарыг хөгжүүлэхэд гүүр болох

Хүсэл мөрөөдөл: \_\_дуртай ажлаа хийгээд хайрт хүмүүс гэр бүл, найз нөхдөөрөө хүрээлүүлэн бусдад тустай, үлгэр жишээ энтрепренер болон жүжигчин болохыг хүсэж мөрөөддөг.

Жинхэнэ эр хүн гэдэг таны бодлоор: \_\_Өөртөө итгэлтэй, өөрийгөө хайрлаж мөн зөв илэрхийлж чаддаг, эмэгтэй хүнийг эхэнд тавьж чаддаг бол тэр хүн жинхэнэ эр хүн гэж боддог.

Бүсгүй хүнийг юу чимдэг вэ?: \_\_”Царай муутай эмэгтэй хүн гэж байдаггүй. Залхуу эмэгтэй хүн гэж байдаг” гэж ярьдаг. Эмэгтэй хүнийг үргэлж өөртөө арчаатай, үзэсгэлэн гоо, тачаангуй байдал, эелдэг зөөлөн зан нь чимдэг. Миний хувьд манлайлагч, өөрийгөө чөлөөтэй илэрхийлж чаддаг, бусдыг удирдан авч явж чадах хүчирхэг зан чанар бол эмэгтэй хүний жинхэнэ чимэг гэж боддог.

Амьдралаас юуг эрэлхийлдэг вэ?: \_\_Амьдрал богинохон....Муу сайн үргэлж ээлжилдэг энэ хорвоод юу ч болж байсан гэсэн хэзээ ч бууж өгөлгүй заавал даван туулж чадах хэрэгтэй гэж боддог.



Body Chain by Biko  
Baci panty







Шөнө оройтож ирсэн нөхөр нь эхнэрээ сэрээлгүй тусдаа өөр өрөөнд унтжээ. Хэсэг хугацааны дараа эхнэрийнхээ хашгирах чимээнээр сэрэн өрөөнд нь ортол цонхоор хүн гараад зугтаж байгаа харагдав.

Эхнэр нь:

- Нэг хүн намайг 2 удаа

хүчиндчихлээ гэхэд нөхөр нь:

- Тэгээд шууд тусламж дуудахгүй яагаав гэтэл эхнэр:

- Эхлээд чамайг юм байх гэж бодсон, хоёрдохоо хийнгүүт л чамайг биш гэдгийг мэдсэн юм чинь

- Манай эхнэр тамхинаас гарахгүй бол надтай ахиж загас наадуулахгүй гэж тулгасан гээд боддоо.

- Тэгээд чи тамхинаас гарсан уу?

- Нууц амраг маань үхэж, хоёр гар минь тасарч унахаас нааш гарна гэж ярихгүй ээ хөө.

Нэг шав шалдан хүүхэн таксинд суув гэтэл таксиний жолооч нөгөө хүүхнийг толгойноос нь хөл хүртэл цоо ширтэв. Нөгөө хүүхэн уурлаад: хаашаа юм шалдан хүүхэн хараагүй юм уу гэхэд таксиний жолооч харсаан харсан, харин чамайг хаанаасаа мөнгөө гаргах бол гэж бодоод...

Ээж нь хүүгийнхээ өрөөгөөр өнгөртөл хүүгийг нь өрөө үнэхээр эмх цэгцтэй, ор мороо хураагаад цэмбийцэн байна гэнэ.

Тэхээр нь гайхаад орсон чинь дэрэн дээр нь "Ээжид" гэсэн захиа байв. Айж гайхах зэрэгцээд захиаг дэлгэтэл:

Хайрт ээжээ, Танд энэхүү захиаг бичиж байгаадаа маш их харамсаж бас өөрийгөө зүхэж байна. Би найз охинтой болсоон, түүнийгээ дагаад гэрээсээ явлаа.

... Би түүнд үнэхээрийн хайртай, тэр маань хамгаас сайхан. Тэхдээ тэрний маань шивээс, цоолтуур, мотоциклийн бариу савхин хувцас болон надаас хамаагүй эгч гэдэг нь танд таалагдахгүй л дээ. Тэхдээ энэ бол жинхэнэ хайр.

Ээжээ тэр маань одоо жирэмсэн. Тэр маань бас надаа маш их хайртай гэсэн.

Тэр маань ойд нэг вагончикд амьдардаг бөгөөд энэ өвлийг давчих их түлээ нөөцөлчихсэн. Бид

2 дахиаад зөндөө хүүхэдтэй болно гэж мөрөөддөг.

Хар тамхи бол муу зүйл биш гэдгийг Янжилдулам маань надад ойлгуулж чадсан. Бид 2 гэртээ марихуана тарьж түүнийгээ зарж мөнгөтэй болно гэж боджаагаа.

Цаашлаад эрдэмтэд ДОХ өвчинг эдгээдэг эм тариа гаргаасай гэж бид 2 залбирч байгаа, яагаад гэвэл Янжжа маань эрүүл болох боломж гарна шүү дээ.

Битгий санаа зовдоо ээжээ, би одоо насанд хүрлээ, өөрийгөө аваад явчиж чадахаар боллоо. Хэзээ нэгэн цагт бид 2 тан дээрээ ирж ач ээ нартай чинь танилцуулнаа гэж найдаж байна.

Хайрт хүү Сөөсөг

Жич: Ээжээ дээр бичсэн бүх юм худлаа шүү. Би Батаагийн гэрт байна. Зүгээр таньд рс тоглохоос илүү дорд зүйл амьдралд байдаг юм шүү л гэж сануулах гэсийн. Хайртай шүү. Уураа арилахаар дуудаарай

Олон улсын архи уултын тэмцээн болж байна. Хамгийн эхэнд хятадын тамирчин ууж эхлэв 1 шанага.....6 шанага тасарлаа, тасарсан тамирчныг гаргаж байх хооронд монголын тамирчин нэрмэл архиар биеэ халаасаар. Оросын тамирчин ууж эхлэв 1 шанага.....9 шанага тасарлаа, тасарсан тамирчныг гаргаж байх хооронд монголын тамирчин нэрмэл архиар биеэ халаасаар л. Монголын тамирчны уух ээлж болов 1 шанага.....12 шанага тасарлаа, ишээрээ тасарсан шанагыг гагнаж байх хооронд монголын тамирчин нэрмэл архиар биеэ халаасаар л

Нэг шумуул яаж цус сорох вэ гээд бодож байтал завжаараа цус дуслуулсан вампир явж байв. Түүнээс:

- Чи хаанаас цус олов? гэж асуутал вампир:

- Чи тэр шонг харж байна уу?

- Харж байна

- Тэгвэл би харсангүй...

Хоёр загвар өмсөгч хүүхэн ярилцаж байна гэнэ.

-Ингэхэд нисдэг тэргэнд яагаад

тийм том сэнс тавьдаг юм бол?

-Юу яагаад гэж нисгэгчийг

хөлрүүлэхгүйн тулд сэрүүцүүлэгч

болгож тавьдаг юм байхгүй юу.

-Худлаа битгий яриад бай.

-Нээрээ. Долоо хоногийн өмнө тэрбумтан Гомбоо намайг хувийнхаа нисдэг тэргээр зугаацуулсан юм. Тэгсэн чинь яг газарддагийн даваан дээр нисдэг тэргийнх нь сэнс гэнэт эргэхээ байчихсан. Тэгсэн чинь хөөрхий тэр нисгэгчийнх нь хар хөлс нь яах ийхийн зуургүй цутгачихсан гээд л бодчих.

Дарга үдийн завсарлагаагаар гэртээ хооллож суухад нь эхнэр нь:

-Чи чинь шинэ нарийн бичгийн даргатай болсон гэлvv?

-Ямар шvv юм бэ?

-Яахав дээ, энгийн л хvvхэн

-Хөөрхөн юм уу?

-Yгvvй, яахав зvгээр.

-Яаж хувцаслаж байна?

-Өө, их хурдан шvv гэж ам алджээ

Орос англи хэлтэй, дээд боловсролтой, харьцааны өндөр соёлтой, багаар ажиллах чадвартай 180 см-ээс дээш өндөртэй өөртөө итгэлтэй царайлаг охид, хөвгүүдээр ууц чануулна.

Нэг хvvхэн найз залуу дээрээ гvйн ирж:

-Сая орцонд гурван залуу намайг "Дуу дуул, vгvй бол хvчиндэнэ" гэлээ.

-Миний найз ямар дуу дуулав?

-Тэд нарт яг дуулж харагдаач.

Эхнэр нөхөр 2 амьдардаг байжээ. Гэтэл нөхөр нь гэнэт үхэж гэнэ. 49 хоног нь өнгөрсний дараа эхнэр нь нөхрөө нөгөө ертөнцөд юу хийж байгааг нь мэдэхээр шийдээд сүнсийг нь дууджээ.

- хонгор минь энэ чи юу?

- Тиймээ хонгор минь би байна

- Чи наанаа юу хийж байна

- Өглөө босоод хоол иддэг. Тэгээд сексдээд

- Тэгээд

- Өдрийн хоолоо идээд сексдээд

- Тэгээд

- Оройн хоолоо идээд сексдээд

- Гэхдээ хайрт минь би нөгөө

ертөнцөд хүмүүс секс хийдэг гэж

сонсоогүй юм байна?

- Юун нөгөө ертөнц, би фермд

үржлийн эр туулай болчихсон

байна.

Нэг 90 гарсан хөгшин эмчид



үзүүлжээ. Эмч өвгөнд нэг таглаатай варений шил өгч, маргааш наадхаа “Үрийн шингэнээр” дүүргээд ирээрэй, шинжилгээ хийнэ гэв. Маргааш өглөө нь нөгөө өвгөн хоосон шилтэй орж ирэв. Эмч юу болсныг асуухад, өвгөн өгүүлэв: - Эхлээд манай эмгэн баруун гараараа үзээд болдоггүй, дараа нь зүүн гараараа үзээд болдоггүй, дараа нь 2 гараараа үзээд болдоггүй, дараа нь амаараа үзээд тэр байтугай хиймэл шүдээ хүртэл авч үзээд болдоггүй, тэгээд бүүр арга бараад хөрш авгайг дуудлаа... Эмч тэсэлгүй: - Хөрш авгайгаа дуудсан гэнэ ээ? гэж асуухад. Өвгөн: -Тийм ээ, бид 3 бүр янз бүрийн аргаар үзээд л байсан, үзээд л байсан, гэхдээ энэ хараал идсэн варений шилний тагийг онгойлгож чадсангүй ээ гэв...

Усан онгоц живж, хөлгийн ахмад бусдыгаа орхин, цорын ганц завиа аваад зайлж байна. Багийн гишүүд хашгирна: -Та чинь яаж байна аа, хөлгийн ахмад хүн чинь хамгийн сүүлд хөлгөө орхидог алтан дүрэмтэй шүү дээ! -Та нар дотроосоо нэгийгээ хөлгийн ахмадаар сонгогчоорой.

Сонгинохайрхан дүүрэгт МАН-аас нэр дэвшсэн “Өгөөж” компанийн захирал Х.Түмэнгэрэлийн талаар нэгэн эмэгтэй телевизийн мэдээгээр ярихдаа Түмэнгэрэлийн “боов” тун сайхан амттай бас жил ирэх тусам тослог сайхан болж байгаа. Би үнэхээр дуртай гэсэн бол өөр нэгэн залуухан бүсгүй “боов” нь амттай гэж жигтэйхэн жил ирэх тусам томорсоор байгаа гэжээ. Харин Х.Түмэнгэрэл нэгэн уулзалт дээрээ “Би 17 жил зөвхөн “боовоо” л оролдож байна” гэжээ.

Багш: -Вовка чи яагаад хичээлд хоцров?  
Вовка: -Хичээлд явж байсан чинь бүлэг дээрэмчид таараад...  
Багш: -Тэд нар тэгээд чамайг яав?  
Вовка: -Тэд нар харин гэрийн даалгавраа хийсэн байсан дэвтэр дээрэмдчихлээ.

-Аав аа, найз охиноо болзоонд урьсан юм аа, нэг орой машинаа зээлдээч.  
-Тэг тэг. Гэхдээ бензингүй л байгаа

байх даа.  
-Зүгээр дээ, бид хоёр бензиний хэрэг ч байхгүй юм чинь

Хүү нь 10 мөнгө залгичхав. Эх нь:  
-Түргэн дуудъя аа. Эцэг нь:  
-Жаахан харзная аа.  
-Яагаад?  
-Эмч ирэхээр чинь 10 мөнгийг минь авч өгчхөөд 50 мөнгө нэхнэ шүү дээ.

Английн нэгэн зоо паркаас заан хашаагаа эвдэн алга болжээ. Нэгэн иргэн цагдаагийн газар руу утасдаж байна:  
-Нөхөр цагдаа, манай ногооны талбайд нэг том хулгана орж ирчхээд сүүлээрээ байцаа тараагаад байна! Цагдаа:  
-Тэгээд тэр байцаагаа яаж байх юм?  
-Та үнэмшихгүй л дээ...  
-Хэл л дээ.  
-Сүүлээрээ байцаа ороож аваад хошног руугаа чихээд байна.

Энэ юун үнэр вэ?  
-Сарнай...  
-Сарнай цэцэг дэлбээлж байгаа юм уу?  
-Үгүй ээ, Сарнай хувцсаа сольж байгаа юм.

Өглөө дарь эхийн автобусанд огцом тоормозлоход намайг эвлэгхэн тэвэрч твшиж өгсөн царайлаг залууг хайж байна. Гар утас өгөөдөх новшоо!!!

-Улаан вино эрүүл мэндэд сайн гэж байна  
-Зөв хө, эрүүл байж л арай хатуу юм ууна шт

Секс зүйр үгс  
Дассан буудлын даавуу зөөлөн

Дээшээ тааз хол доошоо ор хатуу

Цувж хийсэн бгаас Цуглаж хийсэн секс гоё

Хүний эрхтэн гаднаа Хүхний эрхтэн дотроо

Долоо хөдөлж нэг тавь

Царай муут яван хатна Цайчихсан хүхэн мөнгөнд хатна

Сэрэлгүй явснаас Сексдэж үхсэн нь дээр

Эм хүний дотор эрэгтэй хүний юу бэлгэвчтэйгээ багтана

Эр хүний доодохыг харж Эхнэр нь удаж үхэв.

Эрийг бvv бас Эрхтнийг бvv гол

Их тавьсан ч хvvхэд Бага тавьсан ч хvvхэд

Гудамжинд хүмүүс машинуудыг зогсоож байв

-Ерөнхий сайдыг маань дээрэмчид барьцаалжээ. 10 сая доллар нэхэж байна. Өгөхгүй бол шатаана гэнээ. Хүн болгон л чадах чадахаараа л хандив өгцгөөж байна. Та хандивлахгүй юу  
-За тэгье. Би 5 литр бензин өгье  
-Цагаан сараар гэр бүлээрээ манайд зочлоорой  
-Бид амжихгүй  
-За, ёстой баярлалаа  
Хоёр найз уулзаад энэ тэрийг ярилцана.  
-Ингэхэд би өчигдөр Чернобылиос ирсэн хvvхэнтэй унтаж үзсэн ш дээ.  
-Үгвй байлгвй дээ. Яаж байна тэгээд, шөнө гэрэлтээд л цацраг идэвхт бодис ялгаруулаад байна уу?  
-Нэг тиймэрхvv. Их санаачлагчтай, дайчин юм билээ. Хоёр толгойгоороо зэрэг хөхөөд л...

Гудамжинд хүмүүс машинуудыг зогсоож байв

-Ерөнхий сайдыг маань дээрэмчид барьцаалжээ. 10 сая доллар нэхэж байна. Өгөхгүй бол шатаана гэнээ. Хүн болгон л чадах чадахаараа л хандив өгцгөөж байна. Та хандивлахгүй юу  
-За тэгье. Би 5 литр бензин өгье

-Цагаан сараар гэр бүлээрээ манайд зочлоорой  
-Бид амжихгүй  
-За, ёстой баярлалаа

Хоёр найз уулзаад энэ тэрийг ярилцана.  
-Ингэхэд би өчигдөр Чернобылиос ирсэн хvvхэнтэй унтаж үзсэн ш дээ.  
-Үгвй байлгвй дээ. Яаж байна тэгээд, шөнө гэрэлтээд л цацраг идэвхт бодис ялгаруулаад байна уу?  
-Нэг тиймэрхvv. Их санаачлагчтай, дайчин юм билээ. Хоёр толгойгоороо зэрэг хөхөөд л...









2020

Т. САНЧИР



## Q1

PLAYBOY: Ярилцлага өгч байгаад баярлалаа. Санчиртай уулзсаных сагс ярихгүй бол өөр юу ярих вэ? Өнгөрсөн намар Азийн наадмын сагсан бөмбөгийн тэмцээн манайхны урмыг сэргээсэн сайхан болж өнгөрсөн. Ялангуяа сагсчид. Ямар ч амралт байхгүй тоглолтууд өдөр бүр болж байсан шүү.

Т.САНЧИР: Тиймээ, Инчёоны Азийн наадам манай сагсан бөмбөгчдийн төдийгүй монголчуудын сэтгэлийг сэргээсэн сайхан наадам болж өнгөрсөн. Монголчууд сэтгэл зүрхээрээ бидэнтэй хамт байж цаг үргэлж дэмжиж байсан тэр хүмүүстээ бас баярлалаа гэж хэлэх нь зүйтэй болов уу. Маш шахуу хувиартай байсан л даа. Нийтдээ 10 тоглолт хийсэн. Дунд нь нэг хоёр хоног амарсан. Гэхдээ бид нарт хамгийн их урам зориг, эрч хүч өгч байсан зүйл бол Солонгост ажиллаж амьдардаг мөн Монголд байгаа хөгжөөн дэмжигчдийн дуу хоолой бид нарыг өдрөөс өдөрт хурцалсан. Сошиал ертөнцөөр дүүрэн урам хайрласан маш их сэтгэгдэл, бичлэг тавигдаж байлаа. Эрэгтэй, эмэгтэй баг өөрсдийн хамаг байдгаа шавхаж тоглосон. Ер нь Ази тивдээ өрсөлдөх ур чадвар

бүрэн байна хэмээн дүгнэж болно. Харин манайхан арай намхан биетэй учир асуудал байна. Энэ наадамд Азийн шилдгүүд л өрсөлдсөн. Тэднээс сурах зүйл их, өндөр зэрэглэлийн сайн багтай тоглох нь манайхны хувьд маш чухал.

## Q2

PLAYBOY: Дэлхийн бусад орны тамирчид янз бүрийн витамин тэжээл их хэрэглэдэг юм билээ. Манай топ спортын төрлийнхөн ч хэрэглэдэг болсон. /допингийн төрлийн бус/ Сагсчдын хувьд ердийн хоолноос гадна нэмэлт тэжээл, витамин хэрэглэдэг үү?

Т.САНЧИР: Орчин үеийн спорт гэдэг бол өндөр хөгжилтэй орнуудад шинжлэх ухаан болтлоо хөгжөөд байна. Тамирчдад уураг витаминуг тухайн нөхцөл байдалд тааруулж хэрэглэж байгаа нь тамирчдыг удаан хугацаанд спортын талбарт өрсөлдөж, хүч үзэх боломж олгодог. Харин манай сагсчдын хувьд яг үнэндээ одоогоор ямар нэгэн тусгай витамин тэжээл хэрэглэдэггүй. Одооноос эхлээд бэлтгэл сургуулилтаас гадна нэмэлт витаминууд уураг хэрэглэх хэрэгтэй болоод байгаа. Сая Инчёоны Азийн наадмаас ч харагдлаа. Богино хугацаанд өндөр ачаалал

авахад хүний биед юу юу хэрэгтэй болдог гэх мэт энэ бүгдийг судалж, мэргэжлийн тал руугаа орох цаг болсон болов уу гэж бодож байна. Энд нэг зүйлийг нэмж хэлэхэд биднийг ажил хийхийн хажуугаар сагс тоглодог гээд гадны хэвлэлүүд дээр спортын наадмын үеэр бичээд байсан даа. Энэ нь бас нэг юм хэлээд байгаа юм.

## Q3

PLAYBOY: 2013 онд ОХУ-ын Казань хотод болсон Дэлхийн универсиад наадмын үеэр Монголын сагсчдаас ганцхан Санчираас допингийн шинжилгээ авсан гэж сонссон. Энэ үнэн үү? Яагаад ганцхан өөрөөс чинь авсан юм бол ...?

Т.САНЧИР: Тиймээ, энэ наадам дээр бас л Азийн наадам шиг шахуу тоглож байсан. Надаас авсан шалтгаан нь бол уг наадамд бэлтгэл сайтай, жигд өндөр темптэй тоглож байсан болохоор хардсан байх л даа ./инээв/

## Q4

PLAYBOY: Тэгээд хариу нь тэр дороо гарсан уу?

Т.САНЧИР: Тийн тийн. Ямар ч асуудал гараагүй. Шинжилгээний хариу нь одоо ч надад байгаа.



**THAT**

**100**

**SHOW**







Хорин жилийн өмнө NBA өөрчлөгдөж эхэллээ. Мэжик Жонсоны "Lakers" Ларри Бердийн "Celtics" гэсэн тухайн үедээ улиг болох шахсан тоглолтоос аажмаар холдож, өнөөгийн дүр төрхөө олж байлаа. Мэжик-Бердийн цаг үе NBA-г үнэхээр урьд байгаагүйгээр алдартай болгосон боловч 1990 оны эхэнд энэ нь ч гэсэн жамаараа өндөрлөсөн. Детройтын "Bad boys" -ууд хөгширч байхад, дараагийн үе нь хэн бэ гэсэн асуулт сагсныхан дотор эргэлдэж байв.


**1990-ЭЭД ОНД АМЕРИКИЙН ҮНДЭСНИЙ САГСАН БӨМБӨГ ЯМАР БАЙСНЫГ МАРТАХАД ХЯЛБАР БАЙХАА. ТӨВИЙН ТОГЛОГЧ ТАЛБАЙД ӨӨРИЙН БАЙРАА ЭЗЭЛЖ, ХАМГААЛАЛ ЧАНГА БАЙЛАА. ШИНЭ ТОГЛОГЧ НАР ИХ СУРГУУЛЬД ГУРАВ ДӨРВӨН УЛИРАЛ ТОГЛОЖ ҮЗСЭНИЙХЭЭ ДАРАА АВАРГУУДЫН ЛИГТ ОРДОГ БАЙЛАА. ГЭТЭЛ ОДОО ГАНЦХАН УЛИРАЛ ТОГЛООД Л ДЭЭШЭЭ ГАРЧ ИРЖ БАЙНА ШҮҮ ДЭЭ. 1990 ОНД РАДИОГООР "ACE OF BASE", ТЕЛЕВИЗЭЭР "ER & HOME IMPROVEMENT" НЭВТРҮҮЛЭГ ГАРЧ О ЖЭЙ СИМПСОН ЭХНЭРЭЭ АЛСАН ХЭРГЭЭР ШҮҮГДЭЖ БАЙЛАА. КОМПЮТЭРЭЭР "WARCRAFT: ORC AND HUMANS" ТОГЛОЖ, ХӨЛДӨӨ "AIR JORDAN RETROS" -ЫГ УГЛАЖ БАЙЛАА.**

**МЭЖИК ЖОНСОН:** "Los Angeles Lakers"-ын холбогч асан алдартны жагсаалтад орсон:

[1991 оны 11 сарын 7] Би ДОХ-ын вирус тээгч болсон тул өнөөдөр "Lakers" багаас гарч байна. Би ДОХ-ын вирусын эсрэг мэдээлэл, сурталчилгаа түгээж ажиллана. Миний амьдрал үргэлжилсээр байх бөгөөд энэ вирусыг зөвхөн гомо хүмүүс авдаг гэсэн ташуу ойлголттой байдаг. Үнэндээ энэ вирусыг хэн ч авч болон би хүртэл... Би өвчнөө ялан дийлнэ ээ.

Бид түүнийг ингэж хэлэхэд нь нөгөө л өөдрөг Мэжикийн зан байна даа гэж бодсон. Гэхдээ 1991 онд ДОХ-ыг даван туулсан нэг ч хүн байгаагүй. Тэр үед Мэжикийн өвчин маш ноцтой гэгдэж удаан амьдрахгүй хэмээн бүгд бодож байлаа. Мэжик Жонсоныг ДОХ-ыг анагаах эмийг дэмжин бүр гаргаж авахад нь туслалцаа үзүүлэх хүн болно гэж хэн ч бодож байсангүй. Тэр ирээдүйд хэдэн зуун сая долларын орлогтой бизнесмэн бас "L. A Dodgers" багийн хамтран эзэмшигч болсон нь гайхалтай. Тэр хэлэхдээ "Би урьд хачин хачин юм ярьж байсан байж болно оо. Гэхдээ тэр үед миний сэтгэл зүрхнээс гарч байсан болохоор, би харамсахгүй байна" гэлээ.

**ДОМИНИК ВИЛКИНС:** "Atlanta Hawks" багийн довтлогч асан, алдартны жагсаалтад орсон: Мэжик багаасаа гарахдаа өөрийн орон зайгаа хоосон үлдээгээд явсан. Ларри Берд бас "тэтгэвэрт" гарч багаа орхих гэж байсан. Тэгээд хэн сагсан бөмбөгийн нүүр царай болох вэ гэсэн





GRENO





# ЛЕННИ КРЭВИТЦ -СЕКС СИМВОЛ

**ЛЕОНАРД АЛБЕРТ "ЛЕННИ" КРЭВИТЦ 1964 ОНЫ 5 САРЫН  
26-НД ТӨРСӨН. АМЕРИКИЙН РОК ДУУЧИН, АЯ ЗОХИОГЧ,  
ХӨГЖИМЧИН, ПРОДЮСЕР, ЖҮЖИГЧИН. ЦОМГИЙН  
БИЧЛЭГЭЭ ХИЙХДЭЭ ТЭРЭЭР ГОЦЛОЛ ГИТАР, БАСС,  
БӨМБӨР, ДАРАЛТАТ ХӨГЖИМ ЗЭРГИЙГ ӨӨРӨӨ ТОГЛОДОГ.**

50 настай хэдий ч дуучин эр өөрийнхөө дуунуудаар одоо ч гэсэн эмэгтэйчүүдийг байлдан дагуулсан хэвээр: 11 сард тэрээр өөрийн шинэ цомгийнхоо тоглолтыг хийн Герман улсаар тойрон аялсан. Энэ удаад бид түүнтэй бур булаам бүсгүйчүүд, үймээн бослого болон сайн хүмүүжлийн талаар ярилцсан юм.

Ярилцсан: Марсел Андерс

# Л

**PLAYBOY:** Ноён Крэвитц, яагаад та шинэ цомгоо "Бардам алхах" гэж нэрлэсэн юм бэ?

**КРЭВИТЦ:** Миний хувьд "Бардам алхах" гэдэг нь өөртөө бүрэн дүүрэн итгэл төгс байх гэдэг үгтэй утга нэг мэт санагддаг. Ямар ч хүн өөрийнхөө хэн ч байх, юу ч хийж байсан түүндээ бардам, бахархалтай байх хэрэгтэй. Юуг гоё сайхан гэж хүлээж

авах, юуг хүлээн зөвшөөрөх эсвэл үгүйгээ бид хэн нэгнээр заалгах эсвэл захиргаадуулах ёсгүй.

**PLAYBOY:** Энэ нь эрэлхэг, дайчин байх ёстой мэт сонсогдож байна.  
**КРЭВИТЦ:** Яг зөв. Өнөөгийн энэ амьдарч байгаа цаг үед бид хаа сайгүй алхам бүрдээ л ёс жаяг, дэг журам, зааварчилгаагаар бөмбөгдүүлж байгаа шүү дээ: юу өмсөх, юу идэж уух хэрэгтэй, биеэ хэрхэн авч явах ёстой гэх мэт. Хүн өөрөөрөө байх үнэхээр хэцүү болсон ба энэ нь бараг л эсэргүүцэл гаргахад хүргэж байна. Эрүүл хүний ухаанаар бодоод үзсэн ч гэсэн хүн өөрийгөө маш олон буруу тогтоосон хэв маяг болон ёс дүрмээс хамгаалж байх хэрэгтэй.

**PLAYBOY:** Орчин цагийн эсрэг тунхаглал гэж ойлгож болох уу?  
**КРЭВИТЦ:** Илүү их энгийн болон хүнлэг байхыг л уриалж байна.

Яг одоо тэгээд энэ сэдвээр үргэлжлүүлэн ярихгүй байхыг хүсч байна.

**PLAYBOY:** Таны дуунууд ихэвчлэн олон сайхан бүсгүйчүүд болон сексийн тухай байдаг. Хаанаас энэ их тестостерон ялгардаг байнаа?

**КРЭВИТЦ:** (инээв) Үүнийг би хариулж чадахгүй нь, учир нь дуунууд минь аяндаа л өөрөө бүтчихдэг.

**PLAYBOY:** Үргэлж бүсгүйчүүдийн талаар дуулах нь аажимдаа уйтгартай биш байна гэж үү?

**КРЭВИТЦ:** Мэдээж үгүй. Тэр тусмаа намайг юу гэж хэлнэ гэж бодож байна: Эмэгтэйчүүд гэдэг чинь хэзээ ч шавхагдаж барагдахгүй агуу сэдэв, учир нь тэдэнтэй үргэлж л ямар нэгэн шинэ содон зүйлс тохиолдож байдаг шүү дээ.

**PLAYBOY:** Эмэгтэй хүнээс та яг юуг хайж эрэлхийлдэг вэ? Та бүсгүйчүүдийг "Beast"- сайхан дамшиг, сайхан амьтан гэж зүйрлэж дуулдаг.

**КРЭВИТЦ:** "She's A Beast" гэдгийг хүмүүс үгийнх нь утгаар нь шууд хүлээн авах хэрэггүй. Энэ дуугаараа би бүсгүй хүний гоо үзэгсэлэн, гайхамшигтай байдал болон тийм ч амархан өөрийн болгох хэцүү гэдгийг л илэрхийлэхийг хүссэн юм. Гэхдээ миний цомгийг хэвлэдэг европ дахь компани маань ч бас хүмүүс үүнийг ялгаварлан гадуурхал гэж хүлээж авахвий гэхээс маш их санаа зовж байсан.

**PLAYBOY:** Иймэрхүү текстүүд таны секс символ гэдэг нэр алдарт нөлөөлөөсэй гэж та хүсэхгүй л байх.

**КРЭВИТЦ:** Үгүй, би ямар нэгэн хэв маяг, дүр зурагт баригдахгүй байхыг хүсдэг ба зүгээр л хийж байгаа зүйлээсээ сэтгэл ханамж, зугаа цэнгэлийг л авахыг хүсдэг. Би юуны тухай дуулах, юу гэж хэлэх ёстой гэх мэт зүйлийн талаар нухацтай боддог хүн биш л дээ, би зөвхөн өөрийнхөө мэдрэмжийг л дагадаг.

**PLAYBOY:** Та яагаад секс символ байхыг хүсдэггүй гэж?

**КРЭВИТЦ:** Үүнээс ч муу муухай зүйл гэж байдаг байх л даа (инээв). Секс символ байхыг би хэзээ ч хичээж чармайж байгаагүй ба би одоо 50 настай бас насанд хүрсэн том охинтой хүн шүү дээ.



**PLAYBOY:** 50 нас хүрээд та өөрийгөө хэрхэн яаж мэдэрч байна?

**КРЭВИТЦ:** Гайхамшигтай. Айгаад байх зүйл огтхон ч биш.

**PLAYBOY:** Хөгжмийн салбарт ямар өөрчлөлтүүд гарав?

**КРЭВИТЦ:** Мэдээж өмнөх үеэ бодвол их өөрчлөлт гарсан. Техникийн дэвшил, хөгжмийг хэрхэн, яаж хүлээж авах хүмүүсийн ойлголт гээд. Намайг бага байхад цомог худалдаж авах нь бараг л ёслол төгөлдөр үйл явдал мэт л байдаг байсан. Энэ нь мэдээж 5000 телевизийн суваг, видео тоглоомууд болон интернетийн өмнөх эрин үе.

**PLAYBOY:** Танд энэ бүхэн хааяа илүүч мэт санагддаг уу?

**КРЭВИТЦ:** Энэ өөрчлөлт, дэвшил нь тийм ч муу зүйл биш л дээ. Хүмүүс хэлэхдээ: "Энэ хөгжимчин, дуучид хараал идмээр баян. Тэдэнд энэ их мөнгө хэрэггүй. Бид тэдний дуунуудад мөнгө төлж байгаа нь тэдэнд үнэндээ хамаагүй". Зүгээр, хүмүүсийн энэ мэт хэлж байгаа зүйлс нь л гунигтай санагддаг.

**PLAYBOY:** Үүнийг та эсэргүүцэж байна уу?

**КРЭВИТЦ:** Макдоналдс бүр ч илүү баян ш дээ, гэсэн хэдий ч чамд нэг бургер үнэгүй бэлэглэдэггүй биз дээ. Энэ талаар харин хэн ч гомдолдоггүй. Миний хөгжим талханд хавчуулсан зүсэм махнаас үнэ цэнэгүй гэж үү?

**PLAYBOY:** Та зөвхөн дуучин биш бас жүжигчин тэгээд ч зогсохгүй өөрийн гэсэн загварын компанитай. Энэ бүхнийг та хэрхэн амжуулж байна?

**КРЭВИТЦ:** Долоо хоногийн долоон өдөр хаана ч байсан би үргэлж л ажилладаг. Надад мөнгө хэрэгтэй дээ бус харин надад энэ бүхэн зугаатай байдаг.

**PLAYBOY:** Өмнө нь та Америкийн Иракын эсрэг дайралтыг эсэргүүцэж

байсан. Ирак дахь одоогийн Америкийн армийн үйл ажиллагааны талаар та ямар байр суурьтай байгаа вэ?

**КРЭВИТЦ:** Энэ удаад бид яалт ч үгүй оролцохоос өөр аргагүй.

**PLAYBOY:** Яагаад?

**КРЭВИТЦ:** Тэнд байгаа олон олон хүмүүсийг дарангуйлал, хүчирхийллээс хамгаалах нь ёс суртахууны талаасаа авч үзвэл бидний үүрэг юм. Нийт хүн амыг нь хамтатган нэгтгэж чадахгүй төр засгийг тэнд байршуулснаараа одоогийн энэ байдлыг бид өөрсдөө л бий болгосон шүү дээ. Олон алдаануудын доторх хамгийн том алдаа.

**PLAYBOY:** Америкийн ерөнхийлөгч эмэгтэй байвал улс төрийн байдлыг өөрчилж чадах бол уу?

**КРЭВИТЦ:** Би дэмжих болно. Эмэгтэйчүүд эрчүүдээс илүү энэ дэлхийг удирдаж чадна гэдэгт би итгэж байна.

**PLAYBOY:** Мишэль Обама эсвэл Хиллари Клинтон хоёрын хэн нь байвал танд илүү тааламжтай вэ?

**КРЭВИТЦ:** Мишэль? Түүнийг нэр дэвшинэ гэж хэн хэлж байна?

**PLAYBOY:** Тэр тохирохгүй гэж үү?

**КРЭВИТЦ:** Түүнд хангалттай туршлага байхгүй. Америк алдаануудаа ахин давтахгүй л гэж байгаа бол түүнийг сонгохгүй байх.

**PLAYBOY:** Та өөрийгөө улс төрд зүтгэж байгаагаар төсөөлж байна уу?

**КРЭВИТЦ:** Төсөөлөхгүй байна. Гэхдээ би дуртайяа өөрийнхөө чадах зүйлээр гар бие оролцох болно. Энэ дэлхий дээрх асуудлууд зөвхөн улс төрийн бодлогоор хязгаарлагдахгүй шүү дээ, ядуурал, өвчин, терроризм гэх мэт олон хүчин зүйлс байна. Хэрвээ хүмүүс бид илүү өгөөмөр бас тусч байсан бол энэ бүх байдал бий болохгүй ч байсан ч юм билүү.

**PLAYBOY:** Тэгэхээр таны санал болгож буй зөвлөгөө?

**КРЭВИТЦ:** Бид хүүхдүүдээ мөнгөний болон эд зүйлсийн шуналтай, ичгүүр сонжуургүй мангасууд болгон хүмүүжүүлэхгүй байх нь чухал. Яг л улс төрийн зөв бодлого шиг эцэг эхчүүд хүүхдэд хэрэгтэй.



O/ivi

















# ОРЦОНД ТАСАРСАН БҮСГҮЙ

Түрүүч нь 57-р нүүрт

Буянаа ч сураггүй. Газар тэнгэр ээлжлэн дайвалзаж, хорвоо ч бөөрөнхий шүү дээ, хүний зовлонд цадах болоогүй юу гэж кинон дээр гардаг шиг Хараа голыг урийн шар үертэй байхад нь харайх л дөхсөнгүй. Хүн жаргал даадаггүй зовлон даадаг болохоор тэр бүх зовлон гунигийг тэсч гарахаас өөр арга байсангүй. Хир барагтай бол усан нүдэлж үзээгүй би тэр нэгэн сохор хайраасаа болж, байсхийгээд нулимсаа бөмбөрүүлдэг уяхан сул амьтан боллоо. Гэвч би шазруун, хор шартай амьтан байж. Хот орж байгаад чамайг олж, тооцоо хийнэ дээ гэж шүд зуун боддог байсан.

Тэгж тэгж нэг өдөр хот орлоо. Ажлын газрыг нь төслийн нэрээр баримжаалан хайж яваад оллоо. Тэгтэл тэр төслийн мөнгө "идсэн" хэрэгт ороод ажлаасаа хөөгджээ. Нутгийн итгэлтэй хүний зөвлөсөнөөр хувийн мөрдөгч олж авлаа. Зах дээр зарах гэж авчирсан ачааны машинтай хүнсний ногоогоо "бөөнөдсөн" тул хэдэн төгрөгтэй байсан болохоор ажлаа амархан бүтээлээ. Түүний тусламжтай энэ гэрийг нь заалгаж ирсэн юм. Хонхыг нь дараад гэрт нь орсон. Эхнэр нь хаалгаа тайлж өгсөнийг огт тоосонгүй. Буянаатай уулзах гэж яваагаа хэллээ. Юун хүн бэ? гэхээр нь сүйт бүсгүй нь гэж шуудхан хэлсэн.

Гэтэл тэр үгийг сонсоод эхнэр нь муухай хашгираад нөгөө өрөөндөө ороод мань Буянааг чирээд гараад ирлээ. Тэр намайг таниад гайхан харсанаа хойшоо ухрав. Энэ юун хүүхэн бэ? Надад чи хэлээд өг гэж эхнэрээ шаардахад Буянаа ингэж хэллээ. "Тиймээ, энэ хөдөөний хүүхэн

чинь тэр жил намайг ажлаар очиход зээл олгож өгөөч гээд буудалд ирж, намайг согтоож унагасан хүүхэн мөн шиг байна. Өглөө сэртэл миний өвөрт хэвтэж байсан юм. Чи намайг зөвөөр ойлгоорой. Энэ намайг согтоож "урхидсан" хүүхэн" гэж өчихөд эхнэр нь "Энэ анхны удаагийнх биш шүү. Энэ тэгээд яах гээд байгаа юм бэ? Хурдан хөөж явуул" гэж ориллоо. Угаасаа би тэсрэх бөмбөг шиг тэднийд орсон хүн шүү дээ. "Буянаа гуай та бузар явдлаа яаж ингэж булзааруулж чадна вэ? Надтай сууна. Ганцаараа амьдардаг. Чамд би ухаангүй хайртай гээд явсан чинь худлаа гэжүү? Би зүгээр чиний улаан нүүрийг харж чиний юу гэж хэлэхийг өөрийн биеэр үзэх гэж ирсэн юм. Чи ч дээ ийм увайгүй, явсан газраа "хүүхэд" хийж явдаг ухна байсан юм уу? Намайг чи хүүхэдтэй болгоод явсанаа мэдэх үү? Харин чиний энэ хуурамч худалч, хүний амьдралаар тоглодогы чинь мэдээд тэр хүүхэд хүн болсонгүй" гэж би уйллаа.

Уул нь муусайн юмнуудад нулимсаа үзүүлэхгүй гэж бодсон ч тэссэнгүй уйлж орхив. "Тэгээд чи юу хүсээв? Мөнгө үү? Энүүнд хэдэн төгрөг өгөөд хөөгөөд гарга. Чиний шалигаас болж, эцэг эхийн минь хураасан хэдэн төгрөг дуусах нь. Чи ер нь энэ гэрт юутай ирсэн юм бэ?" гээд эхнэр нь Буянааг цохилд авахад би хаалга нуруугаараа даран "Би эндээс явахгүй. Та нарын мөнгө надад хэрэггүй. Та нар намайг яавал яа. Цонхоороо гаргаад шид" гэж хэллээ. Тэгтэл эхнэр нөхөр хоёр намайг чирч гаргах гэж бөөн юм болсон. Тэд намайг арай гэж гаргаад үүднийхээ гадаа орхиход нь би Буянаагийн хөлөөс гараасаа зуурчихлаа. Буянаагийн хөлийг тавиулах гэж эхнэр нь миний гараас хазаж, Буянаа нөгөө хөлөөрөө миний мөр рүү өшиглөв.

Тэгэхэд нь "Та нар намайг ал. Цагдаа иртэл би эндээс явахгүй" гэж хашгирсан. Гэтэл тэд намайг шат руу түлхэх гээд би хоёулангаас нь зэрэг зуурсан тул хамтдаа гурвуулаа доошоо өнхөрлөө. Намайг толгойгоороо хана мөргөөд, нүд нүүр рүү цус урсахад тэр хоёр намайг орхин зугатсан. Харин чи гарч ирээд намайг татахад миний толгой эргэн нүд харанхуйлж байсанаа танайд орж ирээд хүйтэн усаар толгойгоо угаахад гайгүй болсон. Чамд би маш их баярласан шүү гэж Энхмаа санаа

алдан ярилаа.

Ямар ч гэнэн итгэмтгий юм бэ дээ гэж хэлэх гэсэнээ би болив. Гомдсон хүнийг дээрээс нь гомдоож яаж болох вэ. Түүний төөрөлдсөн хайр цээжин дотроо борооны үүл шиг зангирч, хариугүй түүнийг багалзуурдах гэж байгаа. Тэгээд би сэтгэлийг нь засах санаатай,

-Таныг би ойлгож байна. Та энэ бүгдийг болоогүй гэж бодоод тайван унтаж амар даа гэлээ.

Энхмаа тайвширч чадахгүй байгаа бололтой хоолой нь зангирч,

-Намайг чи та гээд яахав. Зүгээр Энхмаа гэл л дээ. Би чамаас олон эгч биш. Хорин дөрөв хүрэх гэж байна. Надад тусалсанд баярлалаа. Чамд би бөөн төвөг болчихлоо доо гэж гунигтай хэлэв.

-Өглөө яая гэж бодож байна даа? Миний бодлоор бол ахиж түүнтэй уулзаад хэрэггүй биз дээ.

Тэр хэсэг чимээгүй болсоноо уртаар санаа алдаж,

-Яахаа мэдэхгүй байна. Тэгэхэдээ л надад хэцүү байна. Би Буянаатай уулзахаас өмнө эр хүнтэй учирч яваагүй. Эр хүнийг хайрлаж үзээгүй. Зүв зүгээр явсан амьдралд минь гэнэт орж ирээд, сэтгэлийн тамд унагаасан энэ хүнийг зүгээр орхимооргүй байна гэв.

-Өс хонзон авах гэжүү?

-Тэгсэн ч яадаг юм. Нүүрий нь тэр гэхийн тэмдэггүй болтол маажгаад хаячихъя аа...

-Тэгж болохгүй байх аа. Сайн бод. Тэглээ гээд тэр хүн дахиж чамайг хайрлахгүй.

Энхмаа дуугарсангүй. Эмэгтэй хүн болохоор надад ч хүнд байлаа. Хэдийгээр би Энхмаа шиг зовлон үзээгүй ч надаас түрүүлж, хүнд хууртагдаж, хүүхдээ дутуу төрүүлж, түүн шигээ хайр сэтгэлээ "оршуулсан" Энхмаа бол миний дэргэд хал үзэж халуун чулуу долоож яваа бүсгүй. Түүнийг дуугарахгүй болохоор би хэсэг хэвтэж байгаад унтаж орхихжээ.

Өглөө намайг сэрэхэд Энхмаа босчихсон банны өрөөнд байсан цамц хувцсаа янзалж зогсоно. Ахын цамцыг угаагаад тавьчихаж. Индүүдэх үү гэвэл над руу ичингүйрэн харж "Индүүдсэн нь дээр үү? Би барагтай бол хувцсаа индүүддэггүй юм. Нойтон дээр нь сайн сэгсрээд, татаж тэнийлгээд хатаачихдаг. Тэгээд ч надад юм индүүдэж байх зав гардаггүй" гэж

өөрийгөө харин шударгаар хүлээлээ. Түүний шулуун зан надад таалагдаж байсаныг хэлэхийн аргагүй. Манай ах ч бас ийм шулуун шударга хүн. Маягтай зантай хүнд дургүйгий нь яанаа.

Цайгаа уугаад би сургуульдаа явлаа. Энхмаа харин зах орно гээд толгойгоо боосон шархан дээрээ лент наагаад надаас алчуур гуйж зангидаад одлоо. Орой гэртээ ирээд хоолоо хийж байтал хонгилд бөөн шуугиан болоод явчихав. Хаалга руу очиж чагнавал нөгөө Энхмаа ирчихсэн Буянаа ахын хаалгыг гараараа цохиж, хөлөөрөө өшиглөн "Та нар наад хаалгаа тайл даа. Буянаа би чамд хэдэн үг хэлээд явах минь. Чи ямар муухай хүн бэ? Яаж тэгж хүний сэтгэлээр тоглож чадаж байна вэ? Эр хүн юм бол чи гараад ир дээ" гэж хашгирна.

Би гарах гэсэнээ битгий дахиж хэл ам гаргаарай гэсэн миний үгийг үл хэрэгссэн түүнд гомдол төрж, хаалгаа нээсэнгүй. Тэгсэн ч холдож чадахгүй хаалган дээрээ чанган зогссоор... "Новшнууд аа, хаалгаа тайл даа. Би сүүлчийн удаа чамд ганц нэг үг хэлчихье. Хаалгаа онгойлго доо. Би... би... чамайг ийм хүн гэж мэдээгүй шүү дээ... Би... би..." Тэгсээр хаалга цохих гар нь суларсаар... түүний дуу багассаар чимээгүй болчихов.

Шатаар олон хүний өгсөх чимээ гарч "Согтуу байна шүү дээ" "Энэ хүүхэн агсам тавиад байна гэсэн юм аа" гэх дуу гарах нь цагдаа нар ирсэнийг гэрчилнэ. "Цаанаас нь өргө" "Чи юугаа хараад байгаа юм бэ? Цээжнээс нь өргө" гэх дуугаар би ухасхийн гарч "Уучлаарай. Наад хүн чинь манай эгч байгаа юм. Манай гэрт оруулаад өгөөч" гэж хоолой чичрүүлэн гуйлаа.

Энхмаа "тас үсэрчээ". Түүнд өөрийн гэсэн ухаан алга. Шөнө дундын үед Энхмаа сэрж, жорлон руу ум хумгүй гүйсээр ороод таг болов. Би яасан юм бол гэж араас нь эмээн очвол Энхмаа суултуур дээр толгойгоо наачихсан байдагаараа огьж байлаа. "Энхриймаа нуруун дээр дараад өгөөч. Бишээ голоор нь... Аан зөв. Дахиад дороос нь дээшээ... Чи яасан гарын дүйгүй юм бэ? Хөөш дахиад... Боль боль ингэж дардаггүй юм. Би аавынхаа нурууг дараад сурчихсан юм. Ах чинь архи уудаггүй юмуу? Шартдаггүй юмуу? Бөөлждөггүй юмуу? За яахав, гомдоогүй биз дээ.

Ахиад нэг оролдоод үз дээ"

Ердийн үед бол тэр маш хөгжилтэй хүн байх аа. Гэвч түүнийг яаж ч муухай "ааш" гаргасан би "тэвчиж" чадахаар байлаа. Яагаад ч юм бэ, түүнтэй дөнгөж өчигдөр танилцсан хирнээ надад нэг л дотно хүн шиг... Хоёр сар уулзаагүй ахыгаа би санасан байлаа. Ах маань нэг иймэрхүү хөгжилтэй, шударга яриатай хүнсэн. Ахтай минь адилхан зантай эмэгтэй хүн байдаг гэж төсөөлөөгүй явжээ.

Бөөлжиж чадахгүй огиод байсан тул Энхмаад маш хэцүү байсан байх. Тэгээд өөрөө баахан хүйтэн ус уусаны эцэст овоо бөөлжлөө. Үс нь сэгсийсэн, нүднээс нь нулимс бөмбөрсөн түүнийг харахад хичнээн өрөвдөлтэй байсан ч тэр энэ донжгүй байдлаа нуух гэж оролдохгүй байлаа. Жаахан дотор нь онгойсоны дараа тэр надад болсон явдлыг нуулгүй ярьсан юм.

Зах дээр очиж, дахиж хойноос нь ирсэн ногоогоо зарсан Энхмаа жолооч нарыг хоолонд орох уу гэхэд дагаад явжээ. Солонгос хоол идэж, солонгос архи уужээ. Яасан зөөлөн архи вэ? гээд Энхмаа өгсөн болгоныг нь "залгиад" байж. Орой нь надад миний алчуурыг авчирч өгөнгөө жаал жуул жимс ногоо хүргэж өгөх байсанаа орь мартжээ. Нэг мэдэхэд Буянаагийн хаалгыг цохиод зогсож байсан нь санагдсан гэнэ. Тэгээд гар хөл, дуу хоолой нь сулран суларсаар нам "унасан" байна. Түүний хөгжилтэй сэргэлэн зан нь эргэж ирсэн бололтой үс гээгээ гараараа янзлаад,

-Маргааш хагас сайн өдөр. Чи надтай явж зах дээр оч. Хоёулаа

захаар явъя. Хаанаас юу авахыг минь зөвлө. Чамд би жаахан жимс ногоо өгнө. Ах чинь загасанд дуртай бол уу. Манай нутгийн хэдэн жолооч ирсэн. Давсалсан загас өгье. Хоёулаа сайхан танилцлаа. Бүсгүй хүн болохоор чи миний зовлон жаргалыг сэтгэлээрээ ойлгож хуваалцлаа. Би яагаад ч юм бэ чамайг хараад сэтгэл онгойгоод явчих юм. Чи зэрэг энергитэй, сэтгэл сайтай охин байна. Дахиж би хэзээ ч "агсам" тавьж айл амьтан үймүүлэхгүй.

Энэ Буянаа гэдэг бухан бяруутай ахиж хэзээ ч харьцахгүй. Би түүнийг чиний хэлдэгээр аман дотроо тас тас заглаад, шүлстэйгээ хамт гаргаад шидчихсэн. Нутгийн жолооч ах нар гэрий нь заагаад өг. Бялба нүдээд өгье гэсэн л дээ. Гэхэдээ би хэл ам гаргаад яахав гээд зөвшөөрөөгүй. Тархи толгойгоо харуулаад цагдаад өргөдөл өгвөл чадах л байсан. Би тэгээгүй. Амьдралд минь том сургамж өгсөн "гавъяа"-гийн үнэлээд зүгээр "хаячихъя". Цаас шиг базаад хаячихъя. Тэр шидсэн цаас чиний хөлд тааралдвал чи шууд өшиглөөд хогийн сав руу чиглүүлчихээрэй гэж Энхмааг хэлэхэд би тэссэнгүй инээд алдав.

-Тэр муу бухан бяруу охид хүүхнүүд болгон руу хайрын харц шиддэг байх даа. Чамайг тэгж харвал чи шулууухан нүд рүү нь нулимаарай. Өвлийн амралт чинь хэзээ болох вэ? Манайд нэг яваад ирээч. Ах чинь өвөл амардаг бол хамт дагуулаад ир. Би та хоёрыг сайхан дайламз. Аав бид хоёр идшээ идэж бардаггүй хоёр шүү дээ. Мах идэж махсаагаа гарга. Манайд төрөл бүрийн дарсан даршилсан ногоо бий. Сүү тараг ид. Чи ингэхэд



зун юу хийдэг хүн бэ? Манайд ирж надтай ажиллаач. Жимс ногоо тарьж арчилж ургуулж сур.

Өглөө голын хүйтэн усанд нүүр гараа угаагаад хөл нүцгэн нойтон шүүдэр дээгүүр алхвал өвөл ханиад ч хүрдэггүй юм. Манай гэрийн хойд талд шүд хага ташим булгын хүйтэн ус байдаг. Ёо ёо хага ташна. Толгой таштал хүйтэн. Чи үзээрэй. Шүд өвдөхөө больдог юм шүү дээ. Аав энэ бол аршаан гэдэг юм. Хүмүүс болохоор аавын нэрсэн "сархад" гэж тоглодог.... Ямар ч байсан хоёулаа жирийн биш найзууд болно шүү. Чи тэгнэ гэж амла л даа. Миний нүд рүү харж байгаад баруун гараа зүрхэн дээрээ тавьж байгаад амла.

Би нэг итгэсэн хүндээ үхтлээ үнэнч. Чи ч надад итгэ. Айлын хаалга нүдээд "агсам согтуу тавьдагыг" минь хүнд битгий хэлээрэй дээ. Ахдаа ч бүү хэл. Би аавдаа ч хэлэхгүй. Манай аав хэдий уух дуртай ч агсам тавьдаггүй хүн. Би харин "аймаар" байгаа биз. Айлын хаалга өшиглөсөн гэлүү?... Аав сонсвол сур бариад хөөнө шүү... Ахиад ийм "алдаа" гаргахгүй гэдгээ "алдааг" минь дэндүү сайн мэддэг тул чамд л гэж хүлцэл өчье.

Тоост хорвоод "хүн" болох гэж "хөл"-д орохыг алдан явахадаа томоос том "алдаа" хийсэнийг минь чи л мэднэ. Эр хүнд итгэхээр эрхий хуруундаа итгэ гэж над шиг духаараа хана мөргөсөн эмэгтэй хүн л хэлсэн буйзаа. Би бүр толгойгоо "хагартал" мэдлээ. Хэзээ "том" болж ухаан орно доо. Өнөөдөр дахиад агсам тавьдаг юм билүү. Эхнэртэй мөртлөө илүү харж билүү долоодог эрчүүдийг эгнүүлж зогсоож байгаад "хосыг нь урт авах" уу? Чи юу гэж гэж бодож байна. Тэднийг өмөөрөөгүй биз дээ. Бүгдийг нь нүцгэн зогсоож байгаад халгайгаар ороолгоё гэхэд нь би инээд муутайг хэлэх үү даган инээлээ.

Бид төрсөн эгч дүү хоёр шиг нэг гудсан дээр хэвтчихээд эрчүүдийг шоглон дооглож жаал инээлдэв.

-Муусайн эрчүүдийг дооглох яах вэ. Намайг чи хар даа. Нүднээс гарчихсан байгаа биз. "Нөхөр"-тэй хаягдчихсан юмуу? Хүний нөхөр "хүзүүдээд" өөрөө буруутсан биз дээ?... Намайг харин дооглох ёстой бишүү. Нармийчихаад нус нулимстайгаа холилчихсон... Ийм дагина байж болох уу? Дагинаа хат даа, Буянаагийн эхнэрийн дэргэд бол хоронд мансуурсан ялаа юу? Юу вэ? Буянаа ялааны алуур барьчихсан

дутуу үхсэн бол гүйцээгээд өгье гээд зогсож байгаа бус уу. Буянаа руу соотолзож харсан ч сохоож харсан ч тэр зээл өгөх л байсан.

Харин би өөрөө гүйж очиж түүнийг "даврасан" юм. Надаас агь гангийн үнэр үнэртдэг гэж тэр хэлж байсан. Тэр эхнэрийнхээ этгээд чамин үнэртэй гадаад усны үнэрт уйдахадаа тэгж хэлсэн. Хаалга үүд нь шорон шиг байнга "битүү" улсууд харшилтай ч болсон юмуу. Хамраа онгойлгох гээд хээрийн салхи үнэрттэл би таарсан юм. Би чинь хүнд дурлаж үзээгүй танхил охин байлаа. Ханцуйгаа шамалсан тоодгор дээлтэй "аавын цээж" болсон хөдөөгийн залуусаа харж залхсан би нар салхи үзээгүй үүлэн цагаан залууг хараад үлгэрт итгэдэг бага нас шигээ хөл алдан сэтгэлээ "өгсөн" нь үнэхээр харамсалтай.

Гэнэн томоогүй хөдөөх охины онгон талын салхи шиг хайрыг тэр уушигнахаа хэмжээгээр амьсгалж аваад, өөртөө дутагдаж байсан хүчил төрөгчөөр цэнэглэж дүүргээд одоодоо салхины чигээ өөрчилж, дахиж хэзээ ч надтай уулзахгүй гэдгээ мэдсэн атлаа бал бурам шиг хуурамч үгээрээ надад "итгэлийн бялуу" зүсэж өгөөд явжээ. Амсах төдий хуурсан "хайрын бялуу" чихэрлэг биш гашуун байсаныг би хожим ойлгосон. Өчүүхэн жаахан үрийнхээ бахирах дууг нэг удаа сонсоод, дараа нь хаврын урь унасан зөөлөн хөрсөн дор "нутаглуулахадаа" алсад дутаан одсон "аав"-ынх нь хүн чанарыг хамт оршуулсанаа мэдэрсэн.

Олон хүмүүс түүнтэй очиж уулзана гэхэд хориглож байсан. Найз хүүхнүүд маань "Хөсрийн булай амьтныг март. Дахиж түүнтэй бүү холбогд" гэсээр байтал зүтгэсээр байгаад ирж уулздаг би "галзуурсан" хүнээс ялгаа байна уу? Хувийн мөрдөгч түүнийг дөрөв дэх удаагаа гэрлэсэнийг анхааруулсаар байхад "Худлаа байгаасай. Түүний ажил нь болохгүй, зав гарахгүй байсан юм биш биз. Тэр намайг жирэмсэн болсоныг мэдээгүй. Үрээ алдсаныг сонсоогүй. Тэр гэр орноо төвхнүүлж байгаад намайг "авах" гээд утсаар ярих завгүй байгаа" гэж өөртөө хэлсээр бурханд залбирсаар орсоныг яах вэ.

Тэгтэл үнэн аль талд байсан гэвч. Нүдээ бөлцийтөл дарвайтлаа будаж оо энгэсэгдсэн ярвайсан

хүүхний өвөрт байж байх нь тэр. Тэр хүүхний хөхөвчин дотроос Буянаа гуай толгойгоо цухуйлгаж, намайг гүтгэсэн. Би түүнийг согтоож унагаад өөрөө эхэлсэн гэнэ л дээ. Хуцдаг хулгай ч шүү. Түүнтэй унтахыг биш түүнийг хайрлаж, түүнд хайрлуулахыг би хүссэн. Тэрнээс бус хүчил төрөгчийн цэнэглэгч болохыг хүсээгүй. Бие биеэ цэнэглэсэн нэмэх хасах цэнэг байхыг мөрөөдсөн.

Ийм л юмтай учирлаа. Чи залуу охин эрчүүдээс болгоомжилж явах ёстой шүү. Тэдэнд нүүр өгч огт болохгүй. Сургуулиа төгс. Ажилтай бол. Хүнтэй суух гэж яараад яадаг юм бэ. Мөнгөтэй төгрөгтэй, байртай, машинтай болчихвол тэд өөрсдөө чиний өмнө өвдөг сөгдөөд ирнэ. Тэр үед нь чи дух руу нь чанга няслаад, ёо гэж хэлээгүйгийг нь сонгож ав гэж түүнийг хэлэхэд би түүний сэтгэлийн шуурга намдаж чадахгүй байгааг ухаарч,

-Энхмаа би чиний юу хэлэх гээд байгааг үнэн сайн ойлгож байна. Гэхэдээ эрэгтэй хүн бүхэн "Буянаа" биш шүү дээ. Эрэгтэй хүнийг би ахаараа зүйрлэж бодоод сурчихжээ. Миний ах бол хүнд "Буянаа" биш "буян" болох хүн. Та ахыг минь хараарай. Тан шиг ийм үнэн шударга яриатай, шулуун гүдэс...

-Намайг битгий "та" гэж хэлээрэй гэж анхааруулсан байх аа...

-Уучлаарай. Хайрын зовлон гунигыг надаас өмнө амссан болохоор "та" гээд байгаа юм. Дурлалын гунигт түүх чинь хүүхэд гаргаж ч үзээгүй надад дэндүү "ахдаад" байна. Өвөл би амралтаараа ахыгаа дагуулаад очноо. Хувцас хунар, хов жив ярьдаггүй чам шиг эмэгтэй ахад минь таалагдах ч юм билүү мэдэхгүй шүү дээ...

-Би одоо хүнтэй суухгүй. Хичнээн "бурхан" байсан ч эгцэлж харахгүй. Унтъя хоёулаа. Өглөө бантан хийж идье. Харин чи зах хамт ороод миний авах юмыг тааруулаад авч өг. Эрэгтэй хүнд юу дээр...

-Эрэгтэй хүний тухай дахиж дурсахгүй гээ биз дээ? Юун эр яриад унав?

-Аавыгаа л хэлж байна. Аавдаа юу авах вэ? Өмд, цамц, гутал, хувцас бүгдийг нь авах хэрэгтэй. Тэгэхэдээ аль нь зүгээр үү, чи зааж өгнө шүү. За хоёулаа унтъя...

Намайг бантан хийхийг хараад Энхмаа "Чи нэг л сурамгай биш байна. Алив би хийе" гээд өөрөө

гялалзууллаа. Түүний хийсэн бантан ёстой амттай байсан шүү. Бантанг сайхан хийвэл цуйвангаас гоё амттай болдог юм билээ. Зах дээр очиж түүний авах юманд тусалцахад тэр зөндөө баярласан. Миний сонирхож байсан хүзүүний ороолтыг зүгээр ээ гэсээр байтал хүчээр авч өгөөд өөрөө надад ороож өгөөд... их сэргэлэн мэдрэмжтэй бүсгүй юм.

Тэдний нутгийнхан байрласан зах дээр очиж би түүнийг үдэж өгөхөөр очлоо. Энхмаа надад шуудай дүүрэн ногоо, шил сав дүүрэн дарсан жимс, өргөст хэмх өгсөн тул явах замдаа намайг гэрт минь хүргэж өгсөн. Энхмааг гаргаж өгөөд эргэж харахад гурван давхрын нэг айлын цонхны хөшигний цаанаас эр эм хоёр хүний толгой цухуйж байсаныг хараад би Буянаа ахыг, авгайтайгаа тийн нууцаар харж байсаныг мэдсэн юм. Намайг гэртээ орохоор түлхүүрийн нүхээ эрж байх зуур тэдний гэрт хүн орилох, эд хогшил түжигнэх чимээ гарч байсан билээ.

...Энхмаа харьсанаасаа хойш өдөр болгон утсаар ярих тул би шинэ жилээр ахыгаа дагуулан тэднийд очлоо. Аав нь их сайхан намбатай хөгшин байсан. Архи их уудаг л гээд байсан хөөрхий өвгөн нас ахиад даахаа больсон юм билээ, дуртай дуртай гэхэд гурав дөрвөн дугарааны дараа сандал дээрээ суугаагаараа дурандаа таг. Хангай газар болохоор ой модон дунд их хүйтэн байсан л даа. Морь унаж, үнээ сааж, тугал хариулж, гахай хооллож, тахиатай хөөцөлдөж яасан зугаатай байсан бэ?

Цас багатай их хүйтэн байсан тул Энхмаагийн аав "Хар зуд болох нь дээ" гэж дурамжхан байсан. Ах Энхмаагийн аавтай өвс ачиж ирэхээр ууланд өвс нуруулдсан газар руу тактортой явсан тул би Энхмаатай хамт сүү тараг боловсруулж, хайлмаг, ээдэм хийсэн. Өвлийн тэр тэсгим хүйтнийг бид бүхний найз нөхөрлөл, халуун сэтгэл гэсгээж чадсан билээ. Хөдөөний хүмүүст хийх ажил захаасаа ундардаг ажээ. Өглөө босоод Энхмаа үнээгээ саахаар гарна. Би даараад гал түлж гэрээ халаахаас нааш чонон дахан дороос босохгүй тул ах өөрийн сайн дураар босчихсон тугал татаж өгнө.

Эр хүн гэсэн дээ овоо доо гэж би баярлана. Зовлонд учирсан үед нь "тусалж" байсан миний сэтгэл муу найзыгаа ахтайгаа ч

болов танилцуулаад сэтгэлийг нь онгойлгох юм сан даа гэж боддог байсан. Гуч хүртлээ эмэгтэй хүнтэй нийтийн бүжиг ч хийж яваагүй манай "шударга" ах түүний сэтгэлд хүрээ ч үү, үгүй юу би сайн мэдэхгүй. Гэрээгээр хот суурин газар руу сүү өгдөг болсон Энхмаагийн үнээний фермийн ажилд цаг нар үгүй. Дөчийн бидонтой сүү сэвсхийтэл өргөх түүнийг хараад ах "Муухан эр хүнийг хавьтуулалтгүй сүрхий бүсгүй юм аа. Ажилсаг, гүжирмэгийг нь хэлэлтгүй" гэж уулга алдсанаа "Хүлээж бай Энхмаа. Би ачаад өгье" гээд түүний зүг хөл алдан гүйнэ.

Миний амралтын хугацаа нүд ирмэх зуур дууссан тул би хот руугаа буцахаар боллоо. Ах "Өвгөнтэй би ууланд үлдсэн өвсөө зөөж дуусгаад харина" гээд явсан учир Энхмаа намайг мотоциклоор өртөөнд хүргэж өглөө. Намайг ороссон чонон дахаа тэр хуйлан мотоцикль дээрээ тавих зуур,

-Ахыгаа аваад явахгүй яасан юм бэ? гэж инээсэглэлээ.

-Чамд би ахыгаа үлдээгээд явлаа шүү. "Дүү"-гийн ёсоор сайн харж хандаарай. Даварч өөр асуудал гаргах юм бол би хариуцахгүй шүү. Битгий араас очоод согтуу хаалга нүдээд байгаарай. Орцонд "тасраад" уначихвал өдөр унасан мах авахгүй гээд цагдаа дуудаад өгчихнө гэж мэдээрэй гэж намайг хэлэхэд Энхмаа алаг сайхан нүдээ тормолзуулан аальгүйтэж,

-Харин чи намайг хот ороход хажуугийн айлаа "хөөгөөд" явуулчихаарай. Гай болж мэдэх муу хүмүүс шүү гэж аминчлан захив.

-Би чиний сэтгэлийг зовоогоод яах вэ гээд хэлээгүй юм. Тэднийх сарын өмнө нүүгээд явчихсан шүү дээ

-Хаашаа?

-Хаашаа нүүсэн нь чи бид хоёрт хамаатай гэжүү? Холхон явбал сайн бус уу?

-Нээрэн, үнэн үг. Хорвоогийн мухар руу "зайлсан" ч хэнд хэрэгтэй юм бэ. Чихэнд сонсогдож, нүдэнд харагдахгүй газар бол бүүр сайн даа

-Чи түүний нэрийг сонсохоороо бачимдах юм. Арай "хайртай" хэвээрээ байгаа юм биш биз дээ?

-Юу гэж дээ. Мартаад "нулимчихсан". Чи харин найзаасаа "урвах" гээд байна уу? Өнгөрсөн баларсан зуд турханы үеийн юм яриад...

-Чамаас би юунд урвах вэ. Харин ах минь надаас "урвах" вий дээ.

-Танай ах сайн залуу байлаа. Удвал би "дурлаж" магадгүй еэ. Даанч...

-Даанч гэнээ? Таалагдахгүй байна уу?

-Үгүй өөр утгаар хэлж байна. Даанч "эхнэргүй" юм даа.... Би эхнэртэй хүнд "дурладаг" хүн шүү дээ. -Намайг "эхнэр" нь гээд бодохгүй юу.

-Тэгээд үзье л дээ. Тэр нь ч дээр юм байна. Чи намайг ямар ч байсан шат руу "түлхэхгүй".

-Ахыг минь "хайрлахгүй" бол түлхэж магадгүй шүү...

Галт тэрэг хөдлөхөд мотоцикль дээрээ суугаад нэхий бээлийгээ тайлчихаад гараараа даллах Энхмааг хараад түүний дэргэд би "нялх амьтан" гэдгээ ойлгож билээ. Би бол бээлийгээ гараасаа тайллаа бол хуруу минь "царцана" шүү дээ. Тэр ганцаараа одоо буцаад ой модон дундуур гэрийн зүг явна. Хөвчид алсаас дуулдах чонын улианыг сонсон, хад чулуун дундуур уулын горхи мөстөж хөлдсөн замаар явна. Тэгж бодохоор би түүнийг бишрэхээс өөр яах вэ.





## THAT 90'S SHOW

Түрүүч нь 59-р нүүрт

асуулт аргагүй гарч ирсэн л дээ.

Гурван сарын дараа, Мэжик хэвлэлийн хурал хийн, багтаа ирж 1992 оны бүх оддын тоглолтод 25 оноо авч байсан. Зургаан сард тэр Берд, Жордан, Барклей болон долоон алдартай сагсан бөмбөгчидтэй хамт Барселонагийн олимпын наадамд амжилттай оролцлоо. Тэд 117-85 оноогоор Хорват улсын багийг бут цохиж алтан медалийн эзэд болсон. Үүнээс өмнө Чарльз Барклей тохойгоороо эсрэг талын тоглогчийн хөлийг нь газраас хөндийртөл цохисон. Энэ талаар "Sport Illustrated" сэтгүүлийн сурвалжлагч Жак Маккалум асуухад тэрээр "Би танай сэтгүүлийн нүүрэн дээр үүнээс болж гарах юм уу?" хэмээн асуусан сан. Зураг авалт дундуур Барклей "Хөөе Жак, дараа нь бид нарыг чи саамаар байна уу?" гэж наргиж байсан нэгэн. 2012 онд гарсан "Dream Team" / Мөрөөдлийн баг/ номдоо сэтгүүлч Маккалум тэднийг "Спартанчуудын дараа тохиосон хамгийн их аман таашаал авах дуртай дайчид" гэж онцолжээ.

**ЖАК МАККАЛУМ**, "Seven Seconds or Less" (7 секунд эсвэл богино) ба "Dream Team" (Мөрөөдлийн баг) номын зохиогч:

Мөрөөдлийн баг энэ хорвоод байсан хамгийн шилдэг сагсан бөмбөгийн баг байсан уу? Одоохондоо тийм. Тэд сагсан бөмбөг Мэжик-Бердийн үеэс Жорданы эрин рүү шилжих үеэр гарч ирсэн. Надад эдний хамгийн том амжилт бол 1990 оны тоглолтоороо өөрсдийн оргил үеийг ч давж гарсан юм. Гэхдээ хэн Майкл Жорданаас илүү байхав дээ? Тэр тийм л байсан.

**МАЙКЛ ЖОРДАН**, "Chicago Bulls" багийн довтлогч ахлагч, алдартны жагсаалтад орсон: [1997оны

ярилцлага] Би анх 1987 оноос гоол оруулж эхэлсэн. Энэ нь надад маш чухал байсан бөгөөд яагаад вэ гэвэл үүгээр би олон хүний бодлыг няцааж чадсан. Миний энэ чанар дандаа давуу байдал олгодог. Хүмүүс "Жорданыг 20 оноогоо авахад хэн сургах вэ? Каролина мужийн дасгалжуулагч Дин Смит" гэдэг байсан. Би үүнтэй санал нийлж байгаагүй. Буруу. Би байнга хориос дээш оноо авч чадна гэдгээ мэддэг байсан. Дин Смит надад оноо авахаас бусдыг зааж өгсөн, жишээлбэл хамгаалалт, дамжуулалт гэх мэт.

*Жордан 1982 онд NCAA-д Хойд Каролинагийн багт тоглох үеэс олон тэмцээнд түрүүлж нэр алдрын зам руу орсон. Тэр их сургуулийн 1 дүгээр курсын оюутан, 19 настай байжээ.*

**ЖОРДАН:** Би яг бөмбөг сагсанд орж байгааг хараагүй. Тал талаас хамгаалалт ирж байсан. Тэгээд заал дүүрэн дуу чимээ гарахад юу болсныг мэдсэн. Энэ бол зүгээр л миний ажил амьдралын эхлэл. Үүний дараах хамгийн хэцүү зүйл нь бусдын шаардлагад хүрэх байлаа.

"Детройтын сахилгагүй залуус"-ын (Detroit's Bad Boys), 1989-90 он бол амжилт нь бараг дуусаж байсан үе. Жорданы "Chicago Bulls" 1991 онд тэднийг ялсан. Мөн "Pistons"-той хийсэн нэгэн тоглолтод хэдхэн секунд үлдсэн байсан боловч "Bulls"-ын эсрэг маш хүчтэй тоглосон билээ. Жордан "Pistons"-ын холбогч Исиа Томас өөрийнхөөрөө сайн тоглоогүйд "маш гайхсан" гэж байжээ. Томас 1992 оны Мөрөөдлийн багт багтаагүй юм.

**СЕКУ СМИТ**, [www.nba.com](http://www.nba.com) сурвалжлагч: Би Мичиган мужийн Гранд Рапидст өссөн. Гэхдээ би "Lakers"-ийн улаан фен байсан, мэдээж энэ бол шидэт Межикийн чадвараас болоод шүү дээ. 1990-ээд онд энэ спорт яаж өөрчлөгдөж байгааг харахад үнэхээр гайхалтай байлаа.

**ВИЛКИНС:** 1990-ээд онд 1980-аад оны үе шиг бие бялдрын хувьд тийм сайн байгаагүй. Гэхдээ өнөөдрийг бодвол 1990 оныхон хамаагүй илүү л дээ.

**СМИТ:** Тэр үеийн сагсан бөмбөг бөхийн спортод илүү төстэй байсан. Детройтын баг ганцаараа ийм байгаагүй шүү. "Knicks Heat" мэтийн багууд сагс тоглохоосоо илүү бөх

барилддаг байсан.

**ВИЛКИНС:** Би сагсыг контактай байхад дуртай. Гар, тохойгоороо эсрэг талын тоглогчдыг хамгаалан зогсоож болдог байсан. Бас нэг өөр зүйл нь юу байсан бэ гэхээр бид тэр үед чинь их сургуулийн дараа аваргуудын багт ордог байсан. Би өөрийгөө хамгийн шилдэг ахлах ангиас гарсан гэж боддог. Манай ангид Жеймс Ворти, Исиа Томас, Ралф Самсон, Байрон Скотт гээд бүгд байсан, гэхдээ бидний хэн нь ч NBA руу шууд ороогүй. Би 12 дугаар ангид байхдаа 28 оноо авлаа ч аваргуудын лигт шууд орно гэсэн бодол төрж байгаагүй. 1990 онд үнэхээр сайн сагсчин олон байсан. Сайхан ч зантай, бас агуу агуу хочтой.

*Аллен Айверсон гэдэг залуу дэлхийн хамгийн хурдан залдгаар нь "Мөнгөний уут", Сеатл мужийн Гэри Пейтоныг "Glove" буюу "Бээлий" гэдэг бөгөөд эсрэг тоглогчийг яг бээлий шиг барьж авдаг болохоор энэ хочийг өгчээ. Юта мужийн Карл Мелоуныг "Mailman" буюу "Шууданч" гэдэг нь байнга сайн дамжуулдаг болохоор ийн нэрлэсэн байна. Портландын Trail Blazer Clyde Drexler гэх тоглогчийг "халтирдаг Clyde" гэж нэрлэдэг бөгөөд агаарт яг халтирч буй мэт нисдэг байсан юм.*

**ВИЛКИНС:** Намайг "Тодруулагч" гэж хочилдог байсан. Надад энэ нь таалагдаагүй. Мэдээж би бөмбөгөө шууд л сагсанд оруулдаг байсан, гэхдээ бүх оноогоо ийм маягаар оруулсан биш дээ. Би хамгаалалтын зураасанд олон удаа ойртдог байсан гэхдээ яг цаг тулаад ирэх үед л бөмбөгөө шиддэг байсан. Энэ бол хамгийн шилдэг тоглогчийн чанар. Жордан энэндээ үнэхээр сайн. Тэр Number one байсан, хэнийг ч урдаа гаргахгүй шүү. Гэхдээ тэднээс бие бялдрын хувьд хамгийн сайн нь Жюльюс Эрвин байсан. Тэр үнэхээр орчин үеийн сагсан бөмбөгийг үүсгэсэн тоглогчдын нэг.

**СМИТ:** 1990 онд Жорданы шүтэн бишрэгчид үнэхээр их байсан.

**ВИЛКИНС:** Фенууд маань та нарын тоглолтын онцлого нь юу байсан бэ гэж асуухад бид тактикаа л боддог. Жордан, Берд эсвэл Мэжикийн эсрэг багт тоглож тэднийг ялбал үнэхээр онцлох тоглолт мөн. Би нэг удаа Бостонтой тоглоод 54 оноо, Чикаготой тоглоод 57 оноо авч байсан. Тоглолт дуусахад нь

“Сайн боллоо” гэж байсан гэж бодож байна уу? Тэр үедээ найзууд шиг шалан дээр суугаад ярьж байсан уу? Үгүй. Жордан юм уу Берд хажуугаар өнгөрөхөд бие бие рүүгээ хүйтэн харц шидэлцдэг байсан. Чи өнөөдөр намайг ялсан байж болно гэхдээ хоёулаа дахиж уулзана аа гэж харцаараа хэлдэг байсан.

**СМИТ:** Фенүүд минь “Lakers”, “Celtics” эсвэл “Pistons”-ыг хожихыг харсаар байгаад сурчихсан байсан гэхдээ удалгүй Жорданы “Bulls” давамгайлж эхэлсэн.

1991 он хүртэл “Chicago Bulls” сагсан бөмбөгийн аварга болж байгаагүй. Жорданы эхний тоглолт ба Мэжикийн хамгийн сүүлийн тоглолт энэ үеэр болж байсан. Жилийн дараа “Sports Illustrated” сэтгүүлийн эхний нүүрэнд Портландын багийг Майклын хамгийн хүчтэй өрсөлдөгч гэж бичив. Удалгүй Майкл Жордан MVP /хамгийн үнэтэй тоглогч/ шагналын 6 дахь удаагаа авсан юм.

**ЧАРЛЬЗ БАРКЛЕЙ, “Phoenix Suns”-ын довтлогч, алдартны жагсаалтад орсон:** [2013 онд сэтгүүлч Маккалумд бичсэн нь] Чак Дейли надад хэлэхдээ (Олимпын үеэр) намайг дэлхий дээрх 2 дахь сайн тоглогч гэж байсан. “Надаас өөр хэн сайн байхав дээ?” гэж бодохдоо би асуултынхаа хариуг мэдэж байсан. Гэхдээ тэр үед би өөрийгөө Майклаас үнэхээр дээр гэж бодож байсан. Энэ бүхэн төд удалгүй өөрчлөгдсөн л дөө.

**ПОЛ ВЕСТФАЛ, “Phoenix Suns” багын дасгалжуулагч:** [2013 онд сэтгүүлч Маккалумд бичсэн нь] Шакын хажууд Чарльз түүхэн дэх хамгийн муу хамгаалагч байсан байж болзошгүй. Бид Ютагийн багтай энэ улирлын эхэнд тоглох гэж байгаа, Чарльз бас л буруу байрандаа байна. Би түүнд “Чи надад яаж тоглохоо хэлдээ” гэхэд тэр “Түүнийг над руу ойртоод ирэнгүүт шууд тойрон хажуугаар нь гарна. Би энийг л хиймээр байна” гэсэн гэв.

Финикс мужийн “America West Arena” гэх ордонд, Барклей эсрэг талын тоглогч Скоти Пиппенийг хамгаалж байлаа. Барклей бөмбөг авахыг оролдсон ч болсонгүй. Пиппен бөмбөг аваад шидэх гэтэл Хораце Грант бөмбөг булаахыг оролдов. Гэвч Грант дайрахаасаа эмээв. Бөмбөгөө шидэхээ болиод, Жон Пакстонд дамжууллаа.

**ЖОН ПАКСТОН, “Chicago Bulls” багийн холбогч:** [2013 онд сэтгүүлч Маккалумд ярьсан нь] Барклей яаж тоглох нь бидэнд их нөлөөтэй байсан. Скоти, Майкл руу очих ёстой байтал, бүх зүйл өөрчлөгдсөн...


**ЖОРДАН:** [1993 оны 10 сарын 6-нд спортоо орхиж байгаагаа мэдэгдсэн нь] Би танил хүмүүстээ дандаа үүнийг хэлдэг байсан, хэрвээ сагсан бөмбөгийн спортод зорилго болон сонирхол байхгүй болвол би спортоо бүр мөсөн орхиноо гэж. Би амжилтынхаа дээд оргилд хүрсэн.

*Ингэж хэлэхдээ тэр 30 настай байлаа. Дэлхий түүнээс яагаад гэж асуухад аавынхаа тухай яриу. Аав минь тэр зун хэдэн өсвөр насны хүүхдүүдэд дайруулаад өөд болсон. Хамгийн хэрцгийг тамирчид хүртэл ийм юм тохиолдоход спорт чухал бус санагдах бизээ гэв.*

**ЖОРДАН:** Би дахиад энэ спортоо

хайртай болох болов уу гэж хүлээсэн л дээ. Тоглох хүсэл надад төрөхгүй л байсан. Эцэст нь спортоо бүр мөсөн хаяагүй зөвхөн сагсан бөмбөг тоглохоо больсон гэдгийг би ойлгосон. Тун удалгүй аавынхаа мөрөөдөж байснаар бэйсбол сонирхож эхэлсэн.

**ЖОРДАН:** [1997 он] Бейсбол сагс хоёрын соёл их өөр байсан. Би зажилдаг тамхи амандаа хийж үзээд толгой өвддөг болоод хоцорсон. Сагсчид костюм пиджак их өмсдөг. Бид дандаа талбай дээр шорт өмсдөг болохоор гоё хувцас өмсөхийг хүсдэг байсан байж магадгүй. Бейсболынхон жинс өмсдөг, тэгээд ч тамирчид нь хамтдаа илүү их цаг өнгөрүүлдэг юм байна лээ. Тэд миний энэ спортыг харж буй өнцгийг их сонирхож байсан. Харин би тэднээс хүссэн зүйл бол арай өөр л дөө. Би бейсболын техникийг сурахыг хүсч байсан. Нэг спортыг ингэж эхнээс нь сурч байсан нь надад эхэндээ сонин санагдлаа.



Тоглоод л, инээгээд л, телевизийн шоуны тухай маргалдаад л. Тэд оройтож унтсан ч гэсэн маргааш нь яагаач үгүй мэт байдаг. Энэ бол залуу нас. Хөзөрдөж, даалуудаад, үгэн тоглоом тоглоод л. Бид ундааны саван дотор самарны ясаа шиддэг байсан. Ясаа гоолдож сурахад надад нэг жил хэрэгтэй байсан. Бейсболын хамт олон хамгийн найрсаг юм байна лээ.

*Жордан самрынхаа ясыг ундааны сав руу шидэж сурч байхад, NBA шинэ баатар хайж байлаа.*

**РИК ТЕЛАНДЕР, "Chicago Sun-Times" сонинны сэтгүүлч:** Тэр үед яг л Чикаго хотоос бүх агаар нь сорогдсон мэт санагдсан. Гурван жилийн баяр, амжилт гэв гэнэт л алга болсон. Скоти Пиппен топ нь биш хоёр дахь нь байсан учраас багийн ахлагч болно гэж хэн ч бодоогүй.

**МАККАЛУМ:** Тэд 1994 он хүртэл долоон улирлын тоглолтод тэргүүлсэн гэхдээ үүгээр Майклын цаг үе дууссан. Жордан байхгүй олсноор шагналын төлөөх тэмцэл улам ихэссэн. Рилей, Жон Старк, Оаклей ба Патрик Юингээр ахлуулсан "Knicks", Хакеем Оложуан ба "Houston Rockets", Мелоун ба Жоноор ахлуулсан Stockton, Грей Пейтоноор

ахлуулсан "Seattle"-ын багуудын хооронд цомын төлөөх өрсөлдөөн ширүүссэн.

**РЕГГИ МИЛЛЕР, "Indiana Pacers" довтлогч хамгаалагч ба алдартны жагсаалтад багтагч:** [Спортын тайлбарлагч Дан Патрикт өнгөрсөн 6 сард бичсэн захидал] Тэр үнэхээр агуу хүн байсан, орчлонгоос тасарсан тамирчин.

**ВИЛКИНС:** Майкл Жордан надад юу ч хэлээгүй. Хэлэх ч шаардлага тэрэнд байгаагүй. Түүнийг өдөх юм бол тэр чамайг шараа болгож магадгүй. Чамайг 40 юм уу 60 оноогоор хожоод л хаяна.

**ЖОРДАН:** Хэдэн хүмүүстэй маргалдаж байсан. Нэг бөмбөг оруулаад л "Өнөө орой би хэдэн бөмбөг хийх үү?" гээд л толгойд бас бодол орно шүү дээ. Чарльз Барклей тоглолтод хожсон бол тэрний хэлэх үгийг сонсоод хэрэггүй.

*Гэри Пейтон бол Майкл Жорданы багт хамгаалагчаар тоглодог байсан залуу бөгөөд маш бохир яриатай нэгэн. Тэр Жерси Нет, Жэйми Фейк рүү дайран "Чи ч дараа жилийн аваргуудын лиг тоглохгүй хүн дээ!" гэсэн удаатай.*

**МАРВ АЛБЕРТ, спортын домогт тайлбарлагч:** Тиймээ энэ бол Миллер байлаа... Тиймээ! Миллер 17 оноо

авлаа, одоогийн байдлаар "NY Knicks" есөн оноогоор тэргүүлж байна. МАТТ ГУОКАС спортын мэдээ хөтлөгч: Одоо Ренни урд талын эгнээнд сууж буй хэдэн хүмүүстэй маргаж байна.

АЛБЕРТ: Миллер дахин гарч ирлээ. Онолоо! Регги Миллер үнэхээр дүрэлзэж байна. Миллер дахин нээгдлээ. Ингээд хоёр оноо авлаа. Регги Миллерийн Спайк Литэй ярилцсан яриа түүнийг асаасан бололтой.

Ли талбайн дунд гараа өргөөд Миллер лүү хашхирахад өөдөөс нь Миллер мөс мэт хүйтэн харц шидэв. АЛБЕРТ: Миллер хүзүүгээ хоёр гараараа багалзуурдаад Спайк Ли рүү харав. /энэ тоглолтын үеэрх Спайк Ли болон Миллерийн үйл хөдлөлийн зураг өнөөг хүртэл хамгийн алдартай байсаар/ Тогтолтын сүүлийн хэсэг нь харанхуйлж, ямар ч л байсан Миллер Спайк руу муухай харц ахин нэг чулуудаж байсан.

АЛБЕРТ: Дахиад орлоо, "Pacers" 75-72-оор ялж байна. Миллер эргэн ирлээ. Тиймээ, Пат Рилей дахиад завсарлага авлаа. Регги Миллер үнэхээр яаж оруулдгийг ёстой үзүүлж байна. Сүүлийн хэсэгт Миллер нийт 35 онооноос 21 нь хийлээ.

АХМАД РАШИД, спортын хөтлөгч: [тоглолтын дараах ярилцлага] Регги, Спайк Ли яасан юм бэ?

МИЛЛЕР: Спайк гэж хэн бэ?

"New York Knicks" "Indiana" багийн долоон тоглолтод хожсон.

АЛБЕРТ: Старксын гурван оноо арай л дутлаа даа!

...ингээд "Knicks"-ийг дахиж гаргаж ирэхээргүй тамын ёроолд хийсэн юм даа.

ВИЛКИНС: Хакеем бол үнэхээр агуу биетэй тоглогч байлаа. Тэр өсвөр нас хүртлээ сагс тоглож байгаагүй. Африкт өссөн болохоор хөл бөмбөг тоглодог байсан. Гэхдээ одоогийн амжилтаа Майкл Жорданы ид үед олж чадах байсан болов уу? Бид хэзээ ч үүнийг мэдэж чадахгүй байх.

ТЕЛАНДЕР: Гоё байна аа! Бүтэн жилийн турш бидний хүлээж байсан асуулт: "Майкл Жордан юу хийгээд байна аа? Мөрийтэй тоглосноос болоод байгаа юм болов уу? Тэр бейсбол тоглож чадахгүй. Чаддаг юм болов уу? Тэр үнэхээр Алабама мужийн Бирмингхам хотод доогуур зэрэглэлийн бейсболчидтой автобусанд суугаад явж байгаа юм уу?". "Bulls"-ын фенүүд түүнийг





хүлээж байлаа. Хүн болгон Жорданыг эргэн ирэх ёстой гэж бодож байв. Түүний аав нь нас барсны дараа тэр өөрийнхөө ур чадварыг өөр салбарт үзэж буй нь энэ. Түүнийг байхгүйд "Chicago Bulls" дахин амилав.

Жордан буцаж ирсэн ч тийм сайн биш байлаа. "Birmingham Barons" багаас гарснаас долоо хоногийн дараа сагсан бөмбөгтөө эргэн ирсэн ч Миллерийн "Pacers" багт хожигдсон. Удалгүй "NY Knicks"-ыг 55 оноогоор ялсан ч "Orlando"-гийн 23 настай Шакил О'Нилийн хажууд үнэхээр сул харагдсан. Жордан тэгэхэд хийморьгүй байдлаа өөрчлөхийн тулд 43-аасаа болиод буцаад 23 гэсэн дугаараа авсан.

ФИЛ ЖЭКСОН, "Chicago Bulls" багийн дасгалжуулагч: [1995 онд өгсөн ярилцлага] Майкл хэлэхдээ бейсболд 45-аар 0.202 оноотой цохиж байсан гэсэн. Тэгэхэд нь би "Чи ч бас шидэхдээ ийм оноотой шидэж байгаа. Буцаад 23 номероо аваа" гэж хэлж байсан.

Хэтэрхий оройтсон бололтой. "Chicago Bulls" баг сүүлийн арван жилд зөвхөн хоёр удаа ялагдаж байсан. 1995 оны аврагын тэмцээнд сүүлийн 18.7 секунд үлдсэн байхад "Knicks" "Indiana"-г 105-99-өөр тэргүүлж байжээ. Баталгаатай ялалт гэж бодож байна уу? Миллер гоол оруулж, бөмбөг аваад дахиад гоол оруулж байсан.

ЭНТОНИ МЕЙСОН, "NY Knicks" довтлогч: [Хэдэн жилийн дараа] Бид шоконд орсон байсан. Сэрье гээд ч сэргж чадахгүй хар дарсан зүүд мэт байсан.

МИЛЛЕР: [Тоглолтын дараах ярилцлага] Би зүрхэнд нь хадаас шаамаар байсан.

МАККАЛУМ: "NY Knicks"-ийн залуучуудад боломж байсан. Яг алтан мөч дээрээ байсан шүү дээ. Тэгээд тэд ялагдсан, түүнээс хойш тэд хаачив?

"Indiana" тэр тоглолтод тэргүүлсэн ч гэсэн хоёр дахь улиралдаа "Houston Rockets" энэ дайнд тэргүүлсэн.

ДЕННИС РОДМАН, "Spurs" багын довтлогч, алдартны жагсаалтад орсон: [1997 онд] Би оноо авдаггүй. Үнэнийг хэлэхэд хамгаалалтад би яг юу хийгээд байдгаа мэддэггүй. Хариу цохилт? Тэрийг бол маш хөдөлмөрлөж байж олно. Урдаас төлөвлөж байж оноо авна. Би эсрэг талынхаа бөмбөг шиддэг тоглогчдын

арга барил, талбай дээр юу хийж болмоор байна бүгдийг нь судалдаг. Тэгээд ирэхээр тоглолт маань яг шоо шидэхтэй адил болдог. Заримдаа 7-ын тоо бууна гэдгийг мэдрээд ирдэг. Сагсан бөмбөг нэг тиймэрхүү шүү дээ. Би тоглолтыг заримдаа телевизороор үзээд л шууд баруун тийшээ явах уу аль эсвэл зүүн тийшээ явах уу гэдгийг мэдрээд ирдэг.

МАККАЛУМ: Жорданыг явсны дараа бүх зүйл өөрчлөгдсөн. Нэр хүнд ч өөрчлөгдсөн. Хакеемаас өөр бодогдож байсан хүн байхгүй. Тэр үнэхээр довтолгоо болон хамгаалалтандаа сайн. Түүнийг хүмүүс агуу тоглогчдын нэгд зүй ёсоор оруулдаг. Хэрвээ тэр хэд дараалж аваргуудын цом аваагүй бол би түүнийг одоогийн нүдээр харахгүй байсан.

Хэрвээ Жордан бейсболын спортоо хаяагүй байсан бол яах байсан бол? Бид Хакеемын тухай ярих байсан болов уу? Хэрвээ Жордан сагсан бөмбөгөө орхиогүй байсан бол "Bulls" сүүлийн хоёр жил аварга болох байсан нь мэдээж. Тэдний юу нь өөр байсан бэ гэхээр, өдөржин шөнөжин ялалтын төлөө шүдээ зуугаад зүтгэсэн нь шүү дээ. Тэд эсрэг багаа зүгээр ялах биш алахыг хүсдэг байсан. Тэд эсрэг тоглогчдоо алаад, шившигийг нь хутгаад, уурыг нь хүргэхийг хүсдэг байсан. Энэ бол мэдээж Жорданы нөлөө.

ТЕЛАНДЕР: Хэвлэл мэдээллийнхэн бид нэг тоглоом тоглодог байсан юм. Майкл Жорданыг аль багт оруулбал тухайн баг ялах вэ? гэж. Бид тооцоолж байгаад найман өөр багийн жагсаалт гаргаж ирсэн. Хэрвээ Майкл тэр багт тоглосон бол аваргын цомыг бас тэдэнд дагуулан авчрах байсан. Майкл тийм хүчтэй хурц байсан. Бие бялдрын хувьд тэр бол арслан бар. Сэтгэл санааны хувьд бол няцашгүй ба хэрцгий байсан.

МАККАЛУМ: Түүнийг зайгаа тавихад хүн болгонд амжилт олох боломж нээгдэж байгаа мэт байсан. "NY Knick" ба "Pacers" аваргын цомд их ойртсон. "Orlando" ба Шак хоёр NBA-д өөрийн гэсэн байр суурийг олж авлаа. Шак бол Жордан, Берд шиг агуу байгаагүй. Тэр Мэжик Жонсонтой төстэй байсан, хошин зантай бас тэгээд олон сайхан тоглолт үзүүлсэн.

ЖОРДАН: Хүн болгон сайхан тоглолт үзүүлж чадна. Гэхдээ тогтмол сайхан, сайн тоглолт үзүүлж чадах нь ховор. Энэ бол хэцүү асуудал.

ТЕЛАНДЕР: Шакил бол Майкл Жордантай харьцуулахаар хүн байгаагүй.

1995-1996 оны улирлын хамгийн сүүлийн сард "Bulls" Вилл Пердуг "Spurs"-ын Родманаар сольсон. Родман бол хамгийн сайн довтлогч нарын нэг байсан.

ТЕЛАНДЕР: Үүнд Жерри Краус (Bulls-ын менежер) Жексоныг тамын чөтгөр гээд "Фил, май энийг аваад ялах гээд нэг үздээ" гэсэнтэй л адил юм болсон. Энэ нь Фил Жексоны багийн зохион байгуулалтын хувьд хамгийн буруу сонголт байсан байж болно.

Родман нэг удаа талбай дээр Пердугтэй маргалдав. Тэр Пиппенийг талбайгаас гаргаад бүр Жорданыг үнэхээр гайхмаар гэж боддоггүй гэж хэлсэн.

РОДМАН: NBA-д надад хамаатай нэг ч хүн байхгүй. Жордантай хамт цаг өнгөрөөх нь сенсаци тарих зүйл гэж үү. Өооё ...

Ворм "Chicago Bulls"-д өөрчлөлт хийсэн. Тэр өөрийгөө сайжруулахын тулд дасгал бэлтгэлдээ илүү цаг зарцуулж Жордан болон Пиппенд хариу цохилт өгсөн.

Бэлтгэл дасгалын үеэр Фил Жексон 32 настай Жордан өөрчлөгдсөнийг олж харжээ. Бейсбол Жорданыг илүү сайн тоглогч бас хүн болгосон гэж бодож байсан. "Жордан бусад хүмүүстэй сэтгэлийн холбоо үүсгэхийн жаргалыг мэдэрдэг болсон байна" гэж Зэн мастер өөрийн "Долоон цагираг: Амжилтын сүнс" гэдэг номдоо бичиж байжээ.

ЖЕКСОН: Жордан бусдыг байлдан дагуулах өөр нэг аргатай болсон. Зарим тоглогчтой Жордан "шидэт биет" байхаар шийдсэн. Чадлаа үзүүлээд ч юм уу, Скотигийн хувьд бол зүгээр хажууд нь зогсоход л хангалттай. "Скотигын хувьд бол би хажууд нь байх шаардлагатай байсан. Би амарвал тэр амардаг байсан. Гэхдээ би тэнд өдөр болгон байсан бол тэр ч бас надтай өдөр болгон байх байсан. Бусад тоглогчтой сэтгэлийн хөдөлгөөнөөр харьцаж болох боловч "Денис рүү хашхирч болохгүй. Түүнд елдэгээр хэлж тайлбарлах шаардлагатай байсан" гэж Жордан ярьж байсан. Бусадтай нь Жордан ам хэлээрээ ойлголцож

болдог байсан. Жишээлбэл Скот Буррел байна. "Скот луу би хэдэн ч удаа хашхирсан сэтгэл санаа, өөртөө итгэх итгэлийг нь сэвтээдэггүй байсан"

1995-1996 онд "Bulls" Жорданыхаас бусад бүх хүний шаардлагыг хойш тавин тоглосон билээ.

СМИТ: Хамгийн сүүлийн шувтаргын тоглолтыг хүмүүс ихэд хүлээдэг байсан, гэхдээ тэр нь аажмаар алга болж байсан л даа. Би "Bulls"-ыг хожигдоно гэж нэг ч удаа төсөөлж байгаагүй.

ВИЛКИНС: Тэр үед "Bulls" төгс байсан яг хуучны «Мөрөөдлийн баг» шиг. Энэ бүхэн зөвхөн Жорданоос болсон юм биш. Тэдэнд үнэхээр сайн тоглогчид байсан- Родман, Кукко гэх мэт. Тэгээд дээр нь Пиппенийг хар л даа. Майкл тэр хоёр хоюулаа маш сайн тоглолттой байлаа. Пиппен сайн хамгаалагч, дамжуулагч бас гоолдогч.

РОДМАН: Форрест Гампын хэлж байснаар "Амьдрал бол яг хайрцагтай шоколад шиг: ямар төрлийн шоколадаа авахаа сайн мэдэхгүй" гэдэг дээ. Энэ дагуу бүх юм өрнөж дууссан.

ТЕЛАНДЕР: Би Родманыг маш их сэтгэл зүйн асуудалтай гэж бодож байсан, энэ нь түүний өсөж торнисон нөхцөл байдлаас болсон байхаа. Тэр Даллас-Портын онгоцны буудалд цэвэрлэгч хийж байгаад цаг хулгайлсан хэргээр хэрэгт орж байсан хүн шүү дээ. Муу санаатай хүн бишээ, жаахан хурц. Тун бага хугацааны дотор тэр Дейтройтод алдартай од болсон. Тэр "Spurs" багт

ороод ёстой новшийн байсан. "Bulls"-т ирэхэд нь Майкл Жордан түүнийг талбайд элдвээр аашлахыг нь дарж чадсан. Тэр хувиа хичээдэг, түрэмгий, муухай зан ааш гаргадаг ч хурдан эргэж довтлоход түүнээс сайн хүн байгаагүй. Зарим тоглолт дээр тэр нэг ч гоол хийдэггүй нь их сонин байсан. Фил түүнийг "ядаргаатай" гэж ярьдаг байсан. Родман том асуудалтай байсан ч түүнтэйгээ тэнцэхүйц авьяастай. Тэгэхээр түүний муухай занг тэвчихгүй байхаас өөр яах билээ. Фил ч сайн мэддэг байсан.

МАККАЛУМ: Бусад багийн залууст тухайлбал "Jazz" д хоёр боломж байсан.

1997 оны улирлын финалын тоглолтод "Chicago Bulls" "Utah Jazz" хоёр 82:82-ын харьцаатай. Родман Мелоуныг энэ тоглолтод балласан. "Шууданч" (Карл Мелоуны хоч) 9.2 секунд үлдсэн байхад хоёр оноо авсан. Скоти Пиппен талбайд оронгуутаа "бүтэн сайн өдөр шуудан ирдэггүйг санаарай" гэсэн гэдэг.

РОДМАН: [Тоглолтын дараа] Муусайн мормон шашинтнуудаас болоод ердөөсөө тоглолт эвлэг байж чадсангүй.

Тоглолтод хоёр баг ижил оноотой байхад Жордан ханиад хүрэв. Тэрээр алдарт "Ханиадтай тоглолт"-ндөө 38 оноо авсан. "Bulls" 90-86 оноотойгоор NBA-ын ялагч болсон.

ВИЛКИНС: Тэднийг "Utah"-г хожсон ялалтыг домог бүтэж буй хоромтой зүйрлэхэд болно. Чи багтаа хамгийн сайн тоглогч байсан байж болно. Чи All-Star байж болно. Гэхдээ чи тэрхэн

хоромд "Chicago"-г хараад эдгээр залуусыг ялж чадах баг энэ хорвоо дээр байхгүй гэж бодох байсан.

ТЕЛАНДЕР: Тэр тоглолтын дараа 10 сард "Bulls" Парист очиход тэднийг яг "Битлз" шиг хүлээж авсан. Ерөнхийдөө галзуу, яг рок хамтлаг шиг л байсан даа. Жордан, Родман хоёр хаа ч явсан бие хамгаалагчтай явдаг байсан. Үүнээс өмнө өөр ингэдэг сагсан бөмбөгийн баг байсан юм уу?

МАККАЛУМ: Майкл яахав Майкл Жордан юм чинь тоглолтыг дуусгадгаараа л дуусгасан. 1998 оны 6 дахь тоглолт, "Bulls"- "Jazz" хоёрын тоглолт ахин болсон. 4-р шат дээр "Bulls" нэг оноогоор хожигдож байх үед Жордан Мелоуны гарт байсан бөмбөгийг доош нь цохисон. 10, 9, 8... секунд. Тэр Брайан Расселыг замаасаа холдуулаад 20 фийт буюу 6 метр гаруй үсэрсэн.

ЖОРДАН: [Тоглолтын дараа]

Би өөрийгөө чадна гэдэгт хэзээ ч эргэлзэж байгаагүй. Би тоглолтондоо эргэлзэж байгаагүй.

ТЕЛАНДЕР: Юу болсон бэ гэхээр, Мелоуныг NBA-ын MVP-/хамгийн үнэтэй тоглогч/ын өргөмжлөлөөр шагнасан. Гэхдээ Жордан Мелоуноос хамаагүй дээр байсан. Энэ нь төрний уурыг хүргэсэн шүү дээ. Түүнээс ямар нэгэн зүйл хулгайлж авахад маш дургүй байсан.

"Bulls"-ын хоёр дахь довтлолт тэднийг орчин үеийн сагсан бөмбөгийн түүхэнд хамгийн шилдэг нь болгов.

ТЕЛАНДЕР: Хэрвээ Жордан сагсан бөмбөгөөсөө "түр чөлөө" аваагүй байсан бол "Houston Rockets" баг хоёр титэм авахгүй байсан байх. "Bulls" найман тоглолт дараалан хожих байсан.

МАККАЛУМ: Найман удаагийн хожлоо? Маркетингийн үүднээс бодох юм бол лиг найм дараалсан хожилд дуртай биш байх байсан гэж бодож байна. Гэхдээ Жорданоос агуу тоглогч үнэхээр байхгүй. Өнөөдөр ч би түүний тухай бодоод алмайрдаг. Би спортын хичээл заадаг, тэгээд сурагчдаасаа хамгийн дуртай тоглогч хэн бэ гэж асуухад, хагас нь Майкл Жорданыг гэж байсан. Тэр карьераа дуусах үед галт бамбараа өөр хүнд өгч магадгүй юм шиг харагдсан. Майклын эрин үе Шакын эрин үе рүү шилжиж магадгүй байлаа. Тэр үед Шак алдартай хүмүүсийн хүсэн хүлээж байсан тоглогчдын нэг



болсон. Пенни Хардвей, Грант Хилл гээд хоёр тоглогч байсан ч Шак шилдэг нь. Тэр 40 ба 22 гэсэн үзүүлэлтийг өөрөө хичээсэн бол авч болох л байв. Гэхдээ тэр үргэлж хамгийн дээд зэргээрээ тоглодоггүй мөн олон бэртдэг. Энэ үүднээсээ Майкл Жорданы дайчин байдалтай зүйрлэшгүй.

Шакд бурхнаас заяасан урт хөл, гар бие бялдар заяасан. MVP шагнал, бас уран сайхны кинонд дүр бүтээгээд амжсан. Тэр гэрийнхээ дэвэрээс үсэрч, нисэж чадахаа үзүүлэх гэх оролддог байжээ. 216 см энэ аврага залуу нэг удаа жорлонд сууж байгаад эвдэлсэн гэдэг. Тэр дуулдаг байсан бөгөөд аргагүй л Майклын дараах хамгийн алдартай тоглогч байсан.

МАККАЛУМ: Гэхдээ Шак дараагийн Майкл байж чадаагүй. Одоо ч гэсэн түүнтэй энэ тэнцэх од алга байна. Хүмүүс Кобид дургүй. Лебронд “шийдвэр”-ээс нь болоод нийт олон дуртай байгаагүй. Леброны түүх их сонин. Тэр Майкл, Мэжик шиг нэг л багтаа үлдээгүй. Тэр бас цагаан арьстай хүмүүст дуртай биш. Майкл, Мэжик хоёр тийм илэн далангүй байгаагүй. Тэр Америкчуудын нүдэнд хэтэрхий гудамжны хулиган мэт харагддаг.

Жордан 1999 оны 1 сард сагсан бөмбөгөө орхиод, 2001 онд “Washington Wizards” багт элссэн. Өнөөдөр 51 настай тэрээр “Charlotte Hornets” багийг хамтран эзэмшдэг. Түүний “Air Jordan” 104, 765 америк доллараар үнэлэгдэж байна. Түүний найз 53 настай Родман сая нөхөн сэргээлтийн эмнэлэгт хэвтжээ. Тэдний “Зэн мастер” 69настай, одоо “New York Knicks” багын ерөнхийлөгч.

СМИТ: Өнөөдөр би аливаа нэг тамирчид, багийг сайн муу гэж хэлж чадахгүй, гэхдээ ямар ч байсан NBA өөр болсон.

Амжилтаас нь харах юм бол “Boston Celtics” хамгийн олон 17 NBA-ын шагналтай, түүний дараа “Los Angeles Lakers” 16 шагналтайгаар удаалж байна. Тэдний араас “Chicago Bulls” 1991-1998 оны бүх шагналыг авсан бөгөөд ингэхдээ нэг ч ялагдаагүй. Лигийн 68 жилийн түүхэнд ямар ч баг таваас илүү удаа дараалан хожиж байгаагүй.

МАККАЛУМ: Майклын талаар сонин юм мэдмээр байна уу? Тэр талбайгаа орхисны дараа харизматик зан ааш гаргаагүй, тэр тийм хүн биш. Харин Леброн эсрэгээрээ. Майклтай харьцуулах юм бол түүнээс 100 дахин илүү жүжигчин. Гэхдээ хамгийн сайн агуу тоглогч нь хэн бэ? Би дахин Майкл Жордан гарч ирнэ гэж бодохгүй байна. Энэ хорвоод зөвхөн ганц л МАЙКЛ байгаа.



## Ц. ЦОГЗОЛМАА

Түрүүч нь 39-р нүүрт

квотын асуудлын тухайд бодоход энэ нь нохойд юм шидэж өгч байгаа юм шиг санагддаг. Уг нь эрэгтэй эмэгтэй нь тэгш эрхтэй адилхан л хүмүүс шиг санагддаг. Угтаа энэ квотынх шүү гэж хэлүүлэх хэрэггүй л дээ. МАН 2012 онд квотоор жагсаж байгаа эмэгтэйчүүдээ жагсаалтынхаа тээр хол бичсэн байсан. Энэ талаар ямар бодолтой байдаг вэ?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Сонгогчдын боловсрол дээшилж байгаа. Гэтэл тийм арчаагүй, хоцрогдсон, ардчилалгүй байдлаар хандсан нь үнэн. Цаашид ойлгоно гэж найдаж байна. Ойлгуулахын тулд гараа хумхиж суухгүй. Намын даргадаа нэг шударга зарчмыг ойлгоосой гэж хүсэж байна. Сонгуулийн үед намын ялалтын төлөө эмэгтэйчүүд илүү ачаа үүрч ажилладаг, тиймээс ажилласан нь цалингаа авах шударга зарчмыг! Мөнгөөр зодчихоод дараа нь тэрийгээ нөхөж авдаг хүмүүсээс ангижрах явдлыг хэлж байна. Намын нэрийн жагсаалтад суулгаж байгаа том цөв юм даа энэ бол. Хэн ажил хийж хэн зүтгэсэн нь ажил албан тушаал томилгооны эхэнд байна. Энэ бол НАМЭХ-ны зарчим байх болно.

**PLAYBOY:** Эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмждэггүй гэж ярьдаг. Үүнтэй санаа нийлдэг үү?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Энэ бол үнэн хэрэгтэй эрэгтэй улс төрчдөөс явуулдаг мессеж байдаг. Үүгээр ам тагладаг. Үгүй ээ, үүний эсрэг манай холбоо дайн зарлах гэж байгаа. Эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмждэг гэдгийг энэ сонгуулиар харуулахын төлөө ажиллах болно. Бүх эмэгтэй сонгогчтой уулзана. За яахав өмнө нь мэдээлэл хаалттай байлаа, үзэл суртал нэг намаас явдаг байлаа гээд үгүйсгэх

аргагүй. Цаг үе өөрчлөгдсөн, бид чинь хэддүгээр зуунд амьдарч байгаа билээ дээ.

**PLAYBOY:** Манай улс төрийн сонгууль ердөө мөнгө санхүүгийн дайн, өрсөлдөөн болдог. Үүнийг тархиараа, бодлогоор өрсөлддөг болгомоор байгаа юм.

**Ц. ЦОГЗОЛМАА:** Улс төрийн намуудын санхүүжилтыг төрөөс даадаг туршлага гадныханд байдаг. Нэр дэвшиж байгаа улс төрчдөд мөнгөний жишиг тавьж өгдөг. Герман гэх мэтийн орны сайхан туршлага байна, хэвлэх зүйлийнх нь тоо хэмжээтэй, санал худалдан авч болзошгүй зүйлсийг нь хуулиар хориглочихсон, бүх нэр дэвшигчдийн сурталчилгааны самбар ижил хэмжээтэй байх жишээний. Нэг самбар дээр 3 нэр дэвшигчийн зураг байлаа гэхэд зургийн байрлалыг нь өдөр өдрөөр сольдог. Иймэрхүү эрүүл саруул юмыг шууд авах хэрэгтэй байгаа юм.

**PLAYBOY:** Улс төрч эмэгтэй хүнтэй ярилцаж байгаагийн хувьд сэдвээсээ хазайгаад ганц хоёр зүйл сонирхоё гэж бодож байна. Нөхрийн тань тухай асуумаар санагдлаа. Эмэгтэй хүн эсвэл карьераа хөө, эсвэл гэрийн сайхан эзэгтэй бол гэсэн хуучинсаг уламжлалт үг байдаг. Гэр бүлээ аз жаргалтай байлгахын тулд эхнэр нөхрийн үүрэг хариуцлагын тухайд юу хэлэх вэ?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Бид хоёр хоёулаа ажилтай, хүсэл тэмүүлэл мөрөөдөлтэй, бас гэр бүл гэж том зүйл байна. Бид дөрвөн хүүхэдтэй. Тэдэнд анхаарал халамж тавих хэрэгтэй. Энэ бүхнийг зохицуулах нь эхэндээ хэцүү байсан. Их ажилтай гээд хэн нэг нь гэр бүлээ орхихгүй байх нь л хамгийн чухал гэдгийг ойлгосон. Гэр бүлийн ачааг бид хоёулаа эн тэнцүү нуруун дээрээ авч явдаг. Ингэх нь илүү ойлголцдог юм. Ажлын 5 өдөр ачаалалтай, тэдэндээ цаг гаргаж чадаагүй бол амралтын 2 өдрийг гэр бүлдээ 100 хувь зарцуулдаг. Гэр бүлийнхээ өмнө хариуцлага хүлээнэ, үүргээ тэнцүү авч явах ажилтайгаа хольж болохгүй л дээ. Нэг зүйл онцлоход нийгмийн сөрөг ойлголтуудаас болоод эмэгтэй хүн эрэгтэй хүнээс хүчирхэг байж болохгүй

гээд өөрсдийгөө дутуу үнэлэх явдал байна эмэгтэйчүүдэд маань. Тэгээд л гэр бүлийн ажлаа ганцаараа хийж зорилго карьераа орхиж байгаа нь харамсалтай.

**PLAYBOY:** Таны үнэнч зөвлөгч нөхөр тань байх тийм үү?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Тэгэлгүй яахав, нөхөр маань хэлдэг юм “Буух газраа сайн мэдэж байгаарай” гэж. Ажил чинь нэг өөр хэрэг, дарга цэрэг чинь хамаагүй, эцсийн бүлэгт үр хүүхэд чинь чухал гэдэг юм. Нэг түүх ярихад Шинэ жилээр буюу 12 сарын 31 нд намайг өөрөө мэдээгүй байхад араар эрчүүд хуйвалдаад албан тушаалаас огцруулж байлаа. Тэр үед огцорсноо мэдэхгүй, талбай дээр хүмүүсийг баярлуулах гээд давхиж явсан хэрэг. Яахав хажууд маань бас сэтгэлтэй хүмүүс байсаан. “Дарга, аа та гэртээ харихгүй юм уу?” гээд л. Он гаргаад явнаа, төрийн ажил хаяж болохгүй гээд л байлаа. Намайг явчихаа гээд л байдаг нөгөөдүүл маань. Дүүргийн нэг албан хаагч араар болсон хорыг сонсчихоод надад хэлж чадахгүй байсан юм байна лээ. За тэгээд талбай дээр шампанскаа буудуулчихаад гэртээ иртэл хүүхдүүдийн царай хачин болчихсон сууж байлаа. Нөхөр дүнсгэр. Юу болсныг асуухад чи мэдээгүй байгаа юм уу, танайхан чамайг огцруулах шийдвэр гаргачихсан байна гэсэн. Ингэж л мэдсэн. “За тэр яах вэ, энэ тэгээд тийм чухал зүйл үү, энэ албан тушаал амьдрал уу?” гэж хэлсэн дээ тэдэнд. Тэр үед нөхрийн маань “ямар ч тохиолдолд буух газраа мэдэж бай” гэсэн үг орой руу орсон юмдаг. /инээв/ Эмэгтэй эрэгтэй хүнийхээ сул давуу талуудыг цаг үедээ зөв тохируулж гаргах нь чухал санагддаг эхнэр нөхрүүд. Ажлын нерв гэрийн хаалганы цаана үлдэх ёстой. Гэртээ гаргасан нервээ ажлын хаалганы ард үлдээх хэрэгтэй.

**PLAYBOY:** Таныг таван өнчин дүүгээ өсгөсөн гэж дуулсан.

**Ц. ЦОГЗОЛМАА:** Сайн ханьтай таараад сайхан амьдарч байгаа маань аз боловч, бага залуу байхдаа өнчин 5 эрэгтэй дүүгээ аваад үлдэж байсан маань нөхөртэйгөө ойлголцож явах ухааныг түрүүлээд суулгачихсан байсан. Байхгүйн зовлон гэж юу байдаг билээ тиймээ, хэрвээ би ээж аавтайгаа элэг бүтэн

эрхэлж өссөн бол улс төрийн энэ хатуу тоглоомыг дийлэхгүй байсан байж магадгүй. Би наснаасаа эрт хат суучихсан хүн шүү дээ. Хүн амьдралдаа үнэт зүйлтэй байх нь чухал юм билээ. Аав ээжийнхээ нэрийг муугаар гаргахгүй юм шүү гэж боддог байсан, дүү нараа чирч явахдаа. Тийм л нэг сигнал тархинд суучихсан. Өөрийн амьдрал болохгүй байхад л дүү нараа зөв явуулах ёстой гэж зүтгэдэг байлаа.

**PLAYBOY:** Айлын том хүүхдүүдийг харахаар ер нь менежер тал руугаа харагдаад байдаг. Танайхны хувьд харахад том нь эгч байсан нь оножээ тийм үү?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Харин тийм, би бас тэгж боддог юм. Эрэгтэй байсан бол олон эрэгтэй дүү нарт уян “менежмент” хийж чадахгүй байж магадгүй л юм. Одоо л тэгж боддог ш дээ. Дүү нар маань нэг үеэ бодвол гараас гарч байна даа.

**PLAYBOY:** Өнөөдөр дүү нараасаа сайхан зүйл юуг хардаг вэ?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Баярын өдрүүдээр тэднээс ирдэг чин сэтгэлийн талархлын сайхан үгэнд нь баярладаг. Тэдэнд би баярлуулах зүйл хийж дээ гэж боддог юм. Эрэгтэй хүүхдүүд бас л хэцүү шүү дээ. Тэр үедээ хатуу, уйлдаггүй байсан хэрнээ, одоо бол тэднийхээ талархлын сэтгэлд нулимс унагадаг. /сурв. Ингэж хэлэхдээ ярилцагч маань уйлсан/

**PLAYBOY:** Улс төрд байгаа эмэгтэйчүүд янз бүрээр л хэлүүлдэг. Таны хувьд хүүхдүүд тань ээжийнхээ тухай хэлсэн муу үгсийг хэрхэн хүлээн авдаг бол?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Харин ч би хүүхдүүдээсээ урам авдаг. Сүхбаатар дүүргийн Засаг даргаас огцроод л, одоо ч гэсэн дэвшигдэх яриа болгонд ямар коментууд явдгийг мэднэ. Эмэгтэй хүн рүү ямар хар бэх цацаж болдгийг би биеэрээ үзэж яваа. Хүүхдүүддээ амьд том жишээ болоод өөрийн биеэр ээж минь хэн бэ гэдгийг харуулчихсан. Миний ээж зарим хүмүүсийн хэлж байгаа шиг ийм муухай хүн биш гэдгийг би хүүхдүүддээ харуулчихсан гэсэн үг, тэд ээжийгээ хэн бэ гэдгийг мэддэг юм. Тиймээс би тэр талаар зовдоггүй.

**PLAYBOY:** Амжилттай яваа эмэгтэй хүний ард заавал нэг татаас байдаг, хэн нэгний дэмжлэгээр гарсан мэт ойлголт байдаг. Харин эрэгтэй хүнийг бол ухаантай мундаг учраас гэж хардаг. Гэхдээ мэр сэр тийм явдал улс төрд байдаг уу?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Намайг Энхболдын хүн, хотын фракц гэж хардаг л даа. Гэтэл Энхболд гэдэг хүн бодлогоор дэмжиж, юм хийж чадна гэж итгэл урам өгч явсан байх. Үүнийг үгүйсгэхгүй, хамтарч баг болж ажиллахад байдаг зүйл. Нэгэн зүгт нэг зорилготой явж байгаа. Харин бий болсон итгэл рүү ус цацахгүй байх нь чухал шүү. Цаг хугацаа харуулах биз ээ.

**PLAYBOY:** Улс төрд ёс бус аргаар эмэгтэй хүнийхээ нэр төрийг золиослон байж ордог нэгэн байна биз?

**Ц. ЦОГЗОЛМАА:** Байгаа, манай намд ч бий. Харагдаж л байдаг. Үүнийг юугаар хааж нуух юм бэ тийм үү? Хүн хэдий ухаантай ч хэлэхээс наашгүй гэгчээр хувь хүнд нь хэлж ойлгуулахыг хичээн засаж залруулж явах ёстой гэдэг байр суурин дээр байдаг хүн шдээ. Ёс журам, зарчмаараа явж байгаа эмэгтэйчүүддээ гай тарих учраас таслан зогсоох ёстой. Үүнээс харахад улс төрд ороход тавигдах шаардлага, зарчмаа тодорхой болгох хэрэгтэй байгаа юм. Тоглоомын дүрмээ ил болгоно гэсэн үг. Далимдуулаад нэг зүйл хэлэхэд нийгэмд эмэгтэй хүний зөв дүр төрхийг бий болгоход анхаарах ёстой гэж боддог. Эмэгтэй хүн үнэгүй хүйстэн ч юм шиг, хоёрдогч хүйстэн ч юм шиг. Борлогдохгүй байгаа хүнсний барааны рекламанд хүртэл байж байх юмаа. Гоо сайхантай байна уу гэдгийг хэн ч ялгана. Гэтэл арай ч дээ гэсэн юман дээр хүртэл нүцгэн байж л байдаг. Заагтай байх хэрэгтэй байхаа. Фэйсбүүкийн гүйцэтгэх захирал Сандбергийн улс орнуудын талыг эмэгтэйчүүд удирддаг, гэр орны маань талыг эрчүүд авч явдаг болсон цагт л дэлхийд жинхэнэ эрх тэгш байдал буй болох болно гэж номондоо онцолсон байсан. Энэ яг үнэн шүү дээ.

**PLAYBOY:** Ярилцсан танд баярлалаа  
**Ц. ЦОГЗОЛМАА:** Та бүхэнд амжилт хүсье.



## ХЯНАЛТААС ГАРСАН ДААЛГАВАР

Түрүүч нь 53-р нүүрт

Уг жагсаалтанд 82 настай Роберт В. Фаркухар багтсан бөгөөд, тэрээр анх 1978 онд ISEE-г төрүүлжээ. "NASA-нийг авчрах боломжгүй гэсэн" гэж Винго хэлэв. "Ажиллагаанд 6 сая доллар хэрэгтэй болно. Тэгэхэд нь бид 150,000 доллараар аваад ирье гэсэн. Бид энэ мөнгийг хувь хүний хөрөнгө оруулалтаас гаргахад NASA бидэнд ISEE-3-ыг авах зөвшөөрлийг өгсөн". Урьд өмнө нь ийм зүйл болж байгаагүй. Түүхэнд анх удаа улсын хөрөнгө оруулалттай компани энгийн иргэдэд хиймэл дагуулаа өгсөн явдал болсон юм. Ковин гэх залуу бидэн рүү дөхөн ирэв. "буцаан авчрахад бид урьд нь олоогүй байсан мэдээллийг гартаа барина. 1960 онд NASA-д уг хиймэл дагуулаас бүх мэдээллийг авах технологи байгаагүй, гэхдээ бид өнөөдөр орчин үеийн технологи ашиглан, NASA-ын хуучин хиймэл дагуулаас шинэ мэдээлэл олно" гэж Винго нэмж тайлбарлав. Газар хэвтэж байсан дискнүүд руу заагаад, тэднийг 1976 оны "Lunar Orbiter" гэх хиймэл дагуулаас гарган авсан гэв. Ковин ярьж эхлэв. NASA "энэ диск бидэнд ямар ч хэрэггүй, зүгээр л тоос болон хувирна. Тэр залуус аль хэдийнээ нас барцгаасан. Ямар хамаатай юм. Бид бүх диск болон файлаа хаясан" гэснийг уламжилж хэллээ.

Би энэ баахан зүйлсийг eBay дээрээс, NASA-гийн хогийн савнаас олсон. Бид файлыг нь NASA-гийн гаргаж авсан зурагнаас илүү сайн болтол цэвэрлэсэн. NASA-гийн зураг маш хар гарсан байна лээ. Харин SKY-CORP-ын гаргаж авсан зурагт жижиг чулуу хүртэл маш сайн тод харагдаж байсан" гэж гайхуулав.

Ковин намайг маш хуучны нэгэн диск уншигч машин руу дагуулан явав. Тэгээд тэр iPhone утсаа гаргаж ирээд "Миний энэ утас энэ том төхөөрөмжөөс илүү хүчин чадалтай. Тэр конденсаторыг нь харж байна уу. Бид үүнийг электрон барааны "RadioShack" дэлгүүрээс авсан. Бид хуучин зүйлсийг аваад янзалдаг юм. Бидний хийдэг зүйл гэвэл өнгөрсөн цаг яаж бидний одоогийн байдлыг бий болгосон бэ гэдгийг ойлгож, улмаар ирээдүйд хаачих вэ гэдгээ үүн дээр үндэслэн тодорхойлон гаргадаг. Ихэнх эрдэм шинэжилгээний ажилтнууд одоо байгаагаа хараад ирээдүйдээ яахаа шийддэг. Харин бид өнгөрснөө судалдаг" хэмээн ярилаа. Ковин компьютер луугаа буцаж явахад, Винго намайг Skype-ын залуу ажилтнуудтай танилцуулав. Камерон Вүүдмэн гэх моделээс ч илүү царайлаг залуу 39 настай, Касей Харпер гэх хар үстэй үзэсгэлэнтэй охин 18 настай гэнэ. Тэр Skype-г дунд сургуулиасаа эхлэн тусалж байгаа гэнэ. "Би яг эдний голден ротривэр нохой л гэсэн үг, гарын үзүүрт зарагддаг" гэж Касей хэлэв. Остин Эппс гэх 28 настай, бор үстэй залуу бол сод ухаантан. Марко Коллелуори 29 настай, дугуй царайтай, чихээ жижиг ээмгээр чимсэн залуу.

Винго намайг байрны хамгийн хойд талын өрөө рүү дагуулан оров. Нэг хаалганы урд архирсан нохой сууж байв. "Кений хамгаалагч нохой" гэж Винго хэллээ. "Кен завгүй байгаа бололтой. Садаа болоод яхав". Тэр одоо 69 настай. Винго хэлэхдээ Зин ямар нэгэн зүйл зохион бүтээдэггүй харин тэр " аливаа юмны согогийг нь олоод янзалдаг авьяастай. Тэр өөр ямар нэгэн юмны мэргэжилтэн бишээ" гэв. Оройхон тийшээ би 19-р байр луу унтаж амрахаар явлаа. Үүдний эмэгтэйдээс түлхүүр аваад нарийн хонгилоор дамжин өрөө рүүгээ оров. Өрөөнд сүүлийн 80 жил хүн ороогүй мэт харагдана. Дээр нь 17 инчийн зурагт байрлуулсан том цагаан хөргөгч байх аж. Зурагтных нь өнгө нь ч сайн харагдахгүй байлаа. Хогийн савных нь таг хүртэл эвдэрсэн байв. Жорлон маш дээр үеийнх. Гарын алчуур нь мод шиг хатсан, банн дээрх саван элсээр хийсэн мэт хорчийсан байв. Жижиг шүршүүрт усанд оров. 6 цаг гээд би гадаа гарч Винго намайг дагуулж хоолонд орохыг хүлээлээ. Винго бид хоёр итали ресторан орохоор явлаа. Тэр яг галзуу юм шиг давхилаа. Жолоо барингаа, "сар судалдаг эрдэмтэд Ангарга гаригийг толгойноосоо гаргаж чаддаггүй" гэж хэлээд "саран дээр Нейл Армстронг, Базз Олдрин нар алхсанаас хойш"



хэмээн тайлбарлав.

Би Вингогоос харь гаригийн амьтан болон Area 51-ийн талаар юу гэж боддог талаар нь асуулаа. (Area 51 гэдэг газарт АНУ-ын төр харь гаригийн хүн нуусан хэмээн маш олон хүмүүс таамагладаг. Нэгдсэн улсын агаарын хүчний өндөр зэрэглэлийн нууцлалтай газар. Дээгүүр нь онгоц хүртэл нисч болдоггүй. Маш олон жил АНУ-ын төрөөс уг газар байхгүй хэмээн ард олныг үнэмшүүлэх гэж оролдсоор ирсэн)

Винго "Бид тэр харь гаригийн амьтанд итгэдэг хүмүүс шиг бишээ. Тэд нар огторгуйн талаар үнэнийг мэдэж өөрсдийн фантазыг устгахыг хүсдэггүй хүмүүс байхгүй юу. NASA ямар нэгэн байдлаар харь гаригийн амьтан байгаа гэж мэдсэн бол аль хэдийн ард түмэнд хэлчихсэн байгаа. Ингэснээр тэдний санхүүжилт төдий чинээ ихэснэ шүү дээ" гэв. Гэхдээ тэрээр сансар огторгуйн тухай зөгнөлт кинонуудад дуртай гэдгээ нуусангүй. "Star Trek"-т хамгийн дуртай гэнэ лээ. Над руу харж инээнгээ "намайг хүмүүс Спок гэж дууддаг байсан хэ хэ . . . миний үзүүртэй чихнээс болоод" гэв. Оройн хоолон дээр Винго надад амьдралынхаа талаар яриу. Тэр Алабама мужид төрж өссөн. Багадаа бие муутай байсан болохоор ихэд дураараа өссөн гэнэ. Ямар нэг

спорт тоглодоггүй байсан бөгөөд сургуулиа биеийн байдлаасаа болоод их алгасдаг байжээ. "Би гадаа гарч болохгүй байсан болохоор ном их уншдаг байсан. Хааяа нэг гарахаараа ой модноос янз бүрийн зүйл түүдэг байсан" гэлээ.

Тэрээр анх 4 настай байхдаа огторгуй болон пуужингийн талаар анх мэдэж авчээ. Тэр үед Хятад улс анх удаа цөмийн зэвсгийн туршилт хийж байсан байна. Тэсрэлтийн хаягдал Алабамад цас болон бууна гэж анхааруулж байсан болохоор "цас битгий амандаа хийгээрэй" хэмээн сануулдаг байжээ. "Атомын бөмбөг гэж юу вэ" гэж ихэд гайхсан гэнэ. Түүнийг 6 настай байхад нь авга ах нь түүнийг CAPE CANAVERAL дагуулан явж "Gemini-12" гэдэг хөлөг огторгуйд хөөрөхийг харуулсан. "Надад сансар огторгуй болон ирээдүй ихэд сонирхолтой санагдсан. Саран дээр очиж болох юм байна гэж бодоход Жорж Воллес, Беар Брайнт болон Вернхер Вон Браун зэрэг Saturn-5 хөлгийг бүтээсэн хүмүүс миний баатар болсон" гэж ярилаа.

1970 онд Винго өсвөр насандаа секс, хар тамхи, рок-н-ролл дурласан байлаа. Байкэруудын бааранд цаг нөхцөөж задгай бүсгүйчүүдтэй болздог байсан. "Тэдний нэг нь Жимми Сваггартай баригдаж байсан биеэ үнэлэгч байсан. Тэр 25 настай байхад би 17 -той байлаа" хэмээн

инээмсэглэв. "Тэгээд удалгүй би Алабама мужийн их сургуулийг инженер-физикч мэргэжилтэй төгссөн. Тэр үед би над шиг сансарт сонирхолтой маш олон хүмүүс байдаг гэдгийг мэдэж авсан". Тэр толгой руугаа заагаад "зарим эмэгтэйчүүдэд ухаан бол мөнгө, хүч чадал, рок-н-роллтой адилхан хүчтэй нөлөөлдөг юм байна лээ" гэв.

Их сургуульд байхдаа NASA-гийн хэд хэдэн төсөл дээр ажилласан бөгөөд сарыг цэцэрлэгт хүрээлэн болгох, Ангараг гариг руу онгоцны билет аваад очиж болох мөрөөдөлд ихэд татагдаж байжээ. Энэ үе нь хэдийн өнгөрсөн ч өнөөдөр юунд татагддаг вэ гэж асуухад, "Би сансар судлалын салбарыг зах зээлд гаргаж мөнгө хиймээр байна" гэсэн хариулт өгөв. "Одоо миний хийж байгаа ажил намайг өөрийн карьертаа амжилт олоход тусна. Ирээдүйд би арилжааны төсөл дээр ажилламаар байна. Жишээлбэл дэлхий дээр биш сансарт хиймэл дагуул барих гэх мэт. Дэлхий дээр бүтээе гэвэл хиймэл дагуул маань дэлхийн агаар мандлаас гарахын тулд маш бат бэх, илүү хүчтэй, илүү хүнд байх шаардлагатай. Сансарт бол хамаагүй хөнгөн, хямд, шатахуун маш бага зарж барьж байна" Өөрийн бизнесийг олонд таниулахын тулд Винго компани Макдоналдс дотор байгуулахаар болжээ. "Макдоналдс хэрэггүй болсон байшингаа дандаа нураачихдаг. Харин NASA энэ байшинг эзэмшдэг байсан болохоор бидэнд өгсөн. Энэ байранд байдаг онцлог маань бидэнд олон нийтийн анхаарлыг татахад тусалсан" гэв.

Би орой 19-р байрандаа 21 цагийн үед ирж үүдний хүнээс нэг зүйл хүсэв. "Би одоо завгүй байна" гэж хариулахад нь би "хэдхэн секунд болно оо гээд та интернэтэд холбогдоод "Delta" агаарын компанийн Сан-Хосе хотоос Атланта орох нислэгийн хувиарыг хараад өгөөч" гэж гуйв. "Өө би тэгж болохгүй бид нарыг интернэтэд холбогдохыг хорьсон" гэв. "Хэн хорьсон юм бол?" гэж намайг асуухад "Мэдээжийн хэрэг NASA" гэсэн хариу өгөв.

ХОЁР

ДАХЬ ӨДӨР

Ковин маш сандрангүй оффисдоо орж ирээд шууд компьютерийнхаа урд суув. Би очоод мэндэлтэл тэр намайг анзаарсангүй бололтой өөртэйгөө яриад дэлгэц дээрх



тоонууд руугаа ширтэв. Би дахиж мэндлээд 5, 6 минут өнгөрсний дараа намайг анзаарсан бололтой “Яасан?” гэв.

Ковин хамт оныхоо дунд нэг зүйлээр алдартай. Түүний хувийн вэбсайт болох NASA Watch-ыг хүмүүс “аюултай” хэмээн нэрлэдэг. Яагаад вэ гэвэл, түүний сансрын онолыг ямар нэг байдлаар няцаахыг оролдсон хэн ч байсан хамаагүй, шүдээ зуугаад дайрдаг учраас. Тэр жагсаалтад нь NASA, Конгресс болон дэлхийн сансар судлаач хамт олон багтсан байдаг.

Ковин сар бол ногоон бяслаг гэж хэлэхэд NASA ямар нэгэн байдлаар түүний уг санааг няцаасан тохиолдолд, Ковин NASA руу яг махчин шувуу хэрэм рүү өлсөхөөрөө яаж дайрдаг вэ яг адил дайрна. Арга ч үгүй юм даа, өөрийн вэбсайт дээрээ “вэб хийгч, астробиологи, сэтгүүлч, пуужингийн эрдэм шинжилгээний ажилтан ба дэвшиж буй нийгмийн ажилтан” гэж тайлбарлан бичсэн байдаг. Тэр өөрийгөө “сансрын донтон” гэж нэрлэдэг. Ковин 1960 онд сансар огторгуйн талаар мэдэх маш их сонирхолтой болсон бөгөөд тэр үед мэдээж сансар огторгуй руу нисэх нь фантаз биш харин бодит байдал болж хувирснаас байхаа.

“Би таниас хэдэн зүйл асуух гэсэн юм” гэтэл Ковин над руу эвшээнгүй харснаа дэлгэцэн дээрх тоо руугаа анхаарлаа чиглүүлэв. Тэгэхэд хаалгаар Винго баахан оюутнууд дагуулан орж ирэв. Тэр “Макмүүн” дотор байгаа хуучны багаж хэрэгсэлүүдэд тэд нарт үзүүлэн тайлбарлаж буй бололтой. Залуус Вингог инээмсэглэн сонсож байлаа. Вүүдмэнийг тэр оюутнууд руу харж байх үеэр би түүн рүү очив. “Dennis-ын аялал бол NASA-гын хамгийн алдартай аялал, яг бодит юм шиг болохоор хүүхдүүд өөрсдийгөө сансрын нисгэгч гэж төсөөлдөг” гэж Вүүдмэн надад ярилаа. Вүүдмэн хэдэн сарын өмнө “Skycorp”-т ажиллаж эхэлсэн бөгөөд энэ ажлаа ирээдүйн таалагдашгүй нууцыг нээх боломж гэж үздэг байна. “Skycorp” бол Вүүдмэний аврал гэхэд болно. Түүнд энэ ажил нь том зүйлийн нэгээхэн хэсэг болох боломж нээж өгчээ. “Би багадаа их даруу, ичимхий, хүмүүсийн дунд нээх их ороод байдаггүй байсан. Өөрийн гээд хэлчих тийм сэтгэл санаа нэг хамт олон надад байгаагүй.

Би хүнтэй ч гэрлээгүй. Эмэгтэй хүнтэй ямар нэгэн харьцаанд ороход надад дандаа асуудалтай байдаг байсан” гэж Вүүдмэн өөрийн хувийн амьдралаа ярьж гарлаа.

Аав нь 6 настай байхад нь өнгөрөөд өнчин таван хүүхдийг ээж нь хүн болгосон. Жаахан том болоод тэрээр NASA-ын ойролцоо очиж онгоц хөөрч буухыг хардаг байжээ. Хэдийгээр одоо тэр талбай, онгоцууд байхгүй болсон боловч бяцхан Вүүдмэний сэтгэлд үүрд хоногшжээ. Тэр Тех-асын их сургуулийг сансар судлалын инженер гэсэн мэргэжлээр төгссөн байна.

“Би одоогоор нээгдээгүй, хүний мэдэж чадаагүй зүйлсийг мэдмээр байна. Таалагдашгүй оньсого мэт байдал надад таалагддаг. Энд ажилласнаар надад дуртай зүйлээ хийх боломж олдож байна” гэж Вүүдмэн тун нухацтай өгүүллээ. Вүүдмэнд түүний ажил нь хуучны тоног төхөөрөмжийг ашиглан сансар огторгуйг судалдаг нь ихэд таалагддаг. Дээр үеийн тоног төхөөрөмж нь байнгын л засвар шаардагддаг.

Марко Коллелуори, Остин Еппс хоёр компьютерынхаа ард сууж байв. Манай энд байгаа хамгийн чухал хүн бол Остин гэж Вүүдмэн хэллээ. ISEE-3 төслийн комполшины систем нь Еппсийн ажил бөгөөд тэр өөрийн зохиосон софтвер коддыг ашиглан хиймэл дагуултай холбоо тогтоодог. Эхлээд тэр ажлаа эсрэг талаас нь эхэлж ISEE-3-ын хардвейрыг тайлсан. Тэр хиймэл дагуулыг барьж аван хэрхэн программчилдаг талаар судалгаа хийдэг юм.

Угтаа хиймэл дагуулын мэдээлэл нь компьютерт ороогүй, ISEE -ын түүх болон түүнтэй холбоотой мэдээлэл нь бүгд гараар бичигдсэн байгаа. Бичсэн хүнийх нь бичгийн хэв нь ч хүртэл аймаар. Еппс Даллас хотод төрж өссөн, багадаа их толгойтой мөн шартай хүүхэд байжээ. “Би том юм барьж эхлэх дуртай. Машин, тэгээд пуужин хүртэл өөрийн гараар угсарч байсан. Харин энд бол тэрээр Кен Зинд туслах дуртай. Тэр нисгэгч болохыг хүсдэг байсан боловч, нүдний хараанаас болоод тэнцээгүй гэлээ. Еппс 16 настай байхдаа сансар судлалын инженерийн салбарт орох болсон. Зургаан жилийн дараа тэрээр Skycorp-д ажиллахдаа сэтгэл их өндөр байгаа. “Энд хүмүүс хачин малгай өмсөөд ажилдаа

ирдэг нь таалагддаг. Би NASA-гийн нэг төсөл дээр амьдралынхаа 10 жилийг зарцуулаад эцэст нь төсөл нь хэрэгжээгүй маш олон эрдэм шинжилгээний ажилтныг мэднэ” гээд Еппс сандал руугаа зүглэв. Вингогийн оюутнууд явцгааж, тэр компьютер дээрээ үлдэв. Түүнд би завтай бол Зинтэй ярилцах хүсэлтээ хэллээ. Винго намайг гал тогоо руу дагуулан явлаа. Хөлдөөгч өнгөрөөд том төмөр хаалгатай өрөөнд ортол Кен дургүйцэнгүй бидэн рүү харав. Винго надад “Кен ямар нэгэн зүйл дээр ажиллаж байгаа бололтой” гэж хэлэв.

Винго надад Зинийг “Skycorp”-д авчирсан шалтгаан нь энэ бүсгүйн амьдрал жаахан хэцүү байснаас болсон гэж тайлбарлав. “Ойрд Кен сонин байгаа. Хэд хоногийн өмнө түүний нохой нь зочилж ирж байсан оюутнуудын нэг рүү дайрахад тэр тас тас инээж байсан. ISEE-3 төсөлд оролцоогүй болохоор сонин байгаа байж магадгүй. Тэр магадгүй бүтэн сайн өдрийн парти дээр ирэхгүй байх, хагас сайнд хүн байхгүй, зав гарвал ярилцанаа” хэмээн Винго хэлэв.

“Доктор Фаркухар яасан бэ?” гэж намайг асуухад “Тэр бүтэн сайн өдөр ирнэ ээ” гэж хариулав. “Фаркухар үнэхээр гайхамшигтай эрдэмтэн. Сансрын станцыг бага гариг дээр буулгаж чадсан хүн дээ. Нобелийн шагнал авчхаар, гэхдээ одоо өтөлж, 80 гарч байгаа. Тэр бас бага зэргийн сонин шүү” хэмээн надад сануулав. ГУРАВ ДАХЬ ӨДӨР

Би хагас сайны өглөө эрт Маккүүн руу зүглэв. Гаднаас нь харвал хүн байхгүй мэт хаалга нь онгорхой байсан болохоор би дотогшоо оров. Би над руу ойртох нохойн хатуу шалыг тогшин ирэх дууг сонслоо. Мейор нэртэй нохой над руу хурдлан архиран ирэв. Намайг яг хазахын даваан дээр “No, Мейор! No” гэсэн дууг би сонсов. Гэтэл нохой тайвширч сүүлээ хоёр тийш нь хөдөлгөв. Ар талын өрөөнөөс Зин гарч ирээд, “Чи юундаа айсан юм бэ? Чамайг мэдээж хазахгүйшд” гээд над руу дургүйцэнгүй харав. Тэр гартаа том хогийн уут барьсан байлаа. Тэр өрөөгөөр тойрч, савтай хогийг том уут руугаа хийв. Skycorp маш их цаас хэрэглэдэг. Би түүнээс ярилцаж болох эсэхийг асуув. Тэр дургүйцсэн шинжтэй “Би хогоо цэвэрлэж дуусаагүй байна, надаас өөр энэ хогийг хэн цэвэрлэх вэ дээ” гэлээ. Тэр хогоо нуруундаа үүрэн

гарав. Нохойгоо шээж баалгаад хожуулаа машиндаа суугаад яваад өглөө.

Зинийг явангуут би Маккүүн хавиар "археологийн" ажлаа эхлүүлэв. Төмөр түмбүүшиг дүүрэн бичгийн цаас.

Вүүдмэний компьютерийн ард Зиний ашигладаг шарах шүүгээ. Үүгээр тэр саран дээрээс ирсэн бичлэгүүдийг хатаадаг гэсэн. Хажууд нь тоймгүй олон ном, ундуй сундуй хавтас.

"Математикийн онол" "Франсис Бэкон" "Тэгш системийн онол" "Хэрман Мэлвиллийн сонгомол зохиолууд" гээд ном. 1930 оны гэмээр хуучны төмөр сэйф дүлий дүмбэ оргино.

Би Зинийг хүлээхээр шийдэв. Зин нохойгоо дагуулан буцаад ирлээ.

Нохой нь над руу энэ удаа ч архиран давхив. Миний хэвлий дээр хөлөө тавиад сүүлээ шарвагнууллаа. Би толгойг нь илж, бид дотогшоо оров.

Зинийг даган гараа угааж байсан угаалтуур луу нь дагалаа.

Зин гараа арчихаар цаас авах гэтэл

дуусчээ. Тэр нэлээн унтууцаж, "тэнэгүүд цэвэр цаас солиод тавих толгой байхгүй" гэв. Гараа өмдөндөө арчингаа би яг асрагч шиг л байдаг гээд ажлын өрөө рүүгээ орлоо. Бид хоёрын ярианд нохой нь унтаад өгөв. Тэр надад хаана ажилладаг байснаа тайлагналаа. "Lockheer Martin", NASA, "Memorex" болон "Sony"-д ажилладаг байсан. Түүний албан тушаал нь "димултиплэх интерсэптор багаж засагч" байж. Түүний хийж байсан ихэнх ажил нь маш нууц, өндөр зэрэгтэй байсан бөгөөд ихэнхдээ Орос болон Хятадын харилцааг нууцаар сонсдог багаж тоног төхөөрөмж дээр ажилладаг байжээ. "Та яг юу хийдэг байсан бэ?"

Тэр надад Skycorp ажиллаж эхэлсэн шалтгаан нь NASA-д Ph.D цолгүйгээр ажил олоход хэцүү болсон байна. Би эдлэн газарт өссөн хүн. Би өөрөө өөртөө л юм засахыг заасан. Яг нөгөө орос залуу шиг, хэн ч билээ дээ?" гэж асуухад би "Калашников"

гэж хариулав. Тэр инээмсэглээд "мундаг залуу шүү" хэмээн онцоллоо. Би түүнээс Skycorp-д ажиллах дуртай байна уу гэж асуухад, "Остин, Марко хоёр бол ухаантай залуус. Тэд яаж юм хийхийг дээд зэргээр мэднэ."

Ковин ба Винго хоёрын хувьд? "Деннис NASA-г сайн мэддэг, тэд нараас юм салгаж чаддаг. Винго бол ядаргаатай. Амаа нээмэгц л хүмүүсийн дургүйг хүргэдэг. Деннис мөнгө олдог боловч яаж орж ирснийг бидэнд хэлдэггүй. Тэр мөнгөө нэг тэнэг ажилладаггүй юманд үрээд, тэгээд тэр тэнэг ямбий юмыг нь би янзлах хэрэгтэй болдог. Ойлгож байгаа биз дээ?" гэж над руу нүдээ томруулав.

Би түүнээс бүтэн сайн өдрийн ISEE-3 үйл ажиллагааны талаар асуухад "хэрэгтэй чухал мэдээлэл олох өдөр. Ийм дээр үеийн мэдээлэл хэрэггүй гэж хүмүүс бодох нь бий. Гэхдээ 1960 онд саран дээр газардсан үйл явдал хүн болгонд ашиг тустай байсан. Тийм учраас ISEE-3 тун чухал. Дэлхийтэй ойртох тусам бид илүү их мэдээлэл олж авах болно. Гэхдээ энэ бас асуудалтай. Сүүлийн 30 жилд тэр хиймэл дагуулын мэдрэгчүүд зөв ажиллаж байгаа юу үгүй юу гэдгийг бид мэдэхгүй" хэмээн Зин тун ойлгомжтой ярилаа.

"Тэгвэл бүтэн сайн өдрийн чухал зүйл нь яг юу вэ?" гэж би асуув. "Шал дэмий. Skycorp-ыг л сурталчлах гэж байхгүй юу. Энэ надад чухал асуудал биш" гэсэн хариу өгөв.

#### ДӨРӨВ ДЭХ ӨДӨР

Өглөөний 9 цаг гэхэд Макмүүн миний өмнө харж байгаагүй хүмүүсээр дүүрсэн байв. Нэг л их биеэ тоосон шинжтэй залуус 10.30 болохыг хүлээнэ.

Ковин баяр баясгалантай өрөөгөөр явж, хүн болгоны зургыг утсаараа авч байв. Винго хүмүүстэй мэндэлж бас инээмсэглэж буй харагдлаа. Тэр урд талдаа инээмсэглэж буй том царайтай шар футболка өмссөн харагдана. Зинээс бусад хүмүүс бүгд компьютерынхоо урд суусан харагдав. Тэр хаана ч харагдсангүй.

Би өндөр, цав цагаан царайтай, нүдний шил зүүсэн залуутай ярилцаж буй настай хүнтэй хөөрөлдөхөөр дөхөв. Би өөрийгөө тэр жижиг өвгөнд танилцууллаа. Тэр 82 настай өвгөн бол ISEE-3 ын загалмайлсан эцэг гэнэ. Надтай гар барьснаа "Миний орос найз охины зургийг харах уу?" гэж асуугаад, "Надад хоёр найз охин байгаа, Нэг нь 36-тай, нөгөө нь 26-





тай. Би уул нь гурван найз охинтой байсан юм. Бүгдийг нь Наташа гэдэг л дээ. Надад түрүүвчнээсээ нэг хөөрхөн орос охины зураг үзүүлэв. “Би Наташатай Москвад Оросын Сансар Судлалын төвд очиж тайлан тавьж байгаад танилцсан юм” гэж Фаркухар хэлэв. “Би тайлангаа дуусаад 2 давхраас доошоо хартал, хэдэн охид бүжиглэж байсан. Би буугаад тэдэнтэй танилцах гэсэн боловч хүмүүс битгий яв гэж ятгаж, үгүй ээ Боб тийшээ яваад дэмий” гэсэн гэв. Мэдээж тэр охид оросын тагнуулууд байсан гэж бодсон байх, Америкийн урдаа барьдаг шинжлэх ухаанчийн толгойг эргүүлнэ гэж бодсон байх л даа.

Фаркухар Наташагийн зургийг хараад “Бид бие биедээ их хайрай. Гэхдээ бид гэрлэж болохгүй л дээ, би аль эрт хүнтэй гэрлэсэн. Болох байсан бол би хэдийнээ Наташатай сууж, түүндээ бүх тэтгэврээ өгчихсөн байгаа” гээд тэр над руу сахилгагүйхэн инээмсэглэв. “Тэгвэл ёстой “Uncle Sam” болгож өгөх байхдаа” гэв. “Би чамд их зүйл ярьж болохгүй яагаад гэвэл чи миний авгайд очоод хэлчиж магадгүй. Би авгайдаа “Наташанууд” бол миний зүгээр л найзууд гэж хэлсэн. Би тэдэнтэй юу ч хийж чадахаа больсоон. Виагра уугаад ч хэрэг алга” хэмээн илэн далангүй ярилаа. Тэр дараа нь надад өөрийн залуугийн зургаа үзүүлэв. Өвгөн ширээ дүүрэн америк цэргүүдтэй суусан харагдав. “Би Солонгосын дайны үед Японд десантын цэрэг байлаа. Солонгост хэдхэн долоо хоног болсон ч би ганцаараа дайнд ялсан” гэхэд нь би дотроо хэн ч тэр дайнд ялаагүй шүү дээ гэж бодов.

Тэр халааснаасаа алтан медаль гаргаж ирээд хүзүүндээ зүүв. “Өмнөд Солонгосууд надад энэ медалийг өгсөн. Энд нь намайг ганцаараа Хойд Солонгосын армийг бут цохисон гэж байна” гэв. Удалгүй надаас уучлал гуйнгаа өөр хүмүүстэй ярихаар эргэлээ. Гэхдээ надад бүсгүйчүүдийг дэгээдэх хамгийн шилдэг зөвлөгөөгөө өгсөн юм. “Би өдөр болгон бүсгүйчүүдэд сээтэн хаядаг. Дэлгүүрт ч, банкинд ч болно. Гэхдээ хамгийн шилдэг газар нь бол эмийн сан байхгүй юу. Тэнд чинь бүсгүйчүүд очиж эмээ авдаг” гээд нүдээ ирмэлээ. Тэр хүзүүндээ зүүсэн медалиа гэрэлтүүлэн олны дунд орж алга болов. Хүн болгон түүн рүү инээмсэглэн гарыг нь барьж байв.

Түүнийг халааснаасаа Наташа 1, 2, 3-ын зургийг гаргаж байхыг харав.

Би хүмүүс битүү дүүрсэн өрөөгөөр хэд эргэлдэв. Компьютерын хажууд ижил хар цамц өмссөн хэдэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс сууж байхыг харав. “PIXEL Corp”-т ажилладаг эдгээр залуус Винго, Ковины ISEE-3 талаарх ярилцлагыг олон нийтэд цацах үүрэгтэй. Том ширээн дээр хэдэн сахалтай эрчүүд, солонгос, хятад, энэтхэг зэрэг ази эмэгтэйчүүд сууж байлаа.

Винго нэг өндөр залуутай самбар дээр бичсэн юмны талаар ярьж байв. Нэг япон залуу хажууд нь инээмсэглэн толгой дохин зогсоно. Өвгөн Фаркухар гурван найз охидынхоо зургийг Еппс болон Коллелуорийн найз охидод үзүүлнэ. Тэгснээ тун удалгүй гараа 2 бүсгүйн мөрөн дээр тавин Ковиноор зургаа татуулав.

Эрдэмтэд бололтой хэдэн залуус хүснэгт барин хүмүүст үзүүлэн явна. Хүмүүс нэг их сонирхохгүй байгаа ч сонсоно. Ковин Винго хоёр камер компьютертэй өрөөнд орцгоолоо. Микрофоныг нь тэнд байсан хэдэн туслах залуус зүүж өгөв. Винго над руу харснаа, “Пат манай эхнэрийг олоод ирээч, бялуугаа бас аваад ирээрэй гээд хэлчих” гэв.

Би дүүрэн хүнтэй өрөө рүү ороод Вингогийн авгай байж болохоор хүнийг хайж эхлэв. Нэрийг нь Ники гэдэг гэсэн. Овгийг нь надад хэлээгүй л дээ. Калифорни мужид Вингогийн эхнэр нэрээ Ники болгон хувиргасан юм байна лээ. Нийгмийн хамгааллынхан үүнээс болж Никиг шүүхэд өгсөн. Мэдээж заргалдан шүүхийн хариу Никигийн талд гарсан. Жинс өмссөн нэг даруу эмэгтэй Ники гэдэг нэртэй байж болох юм шиг харагдахаар нь би очоод өөрийгөө танилцууллаа. Тэр над руу харж инээгээд, “Деннисийн яриад байсан өөрийгөө хэт тоосон залуу юу?” гэж хэлэв.

Түүнээс би бялуугаа авч ирсэн эсэхийг асуухад, бялуугаа хоолны тавиур дээр үлдээсэн байв. Бид хэдэн минут ярилаа. Гэнэт Деннис эмэгтэй хүний тухай ярьж байсан нь гэнэт санаанд орж, түүнээс би та ухаантай номын эр хүнийг таалдаг эмэгтэй юу? гэж асуув.

“Надаас бас нэг өөр хүн тэгж асуухад нь би “тийм” гэж хариу өгсөн” гээд “Гэхдээ үнэндээ бол эр хүний хамгийн чухал зан бол сайхан сэтгэл, хөгжилтэй байдал” гэж хариуллаа.

Хэдийн 10.30 өнгөрөхөд ISEE-3 ын талаарх сонирхож буй хүн алга бололтой. Тэд бие биенийхээ зургийг авч, юуны ч тухай юм ярилцан, оройн хоолны төлөвлөгөө гаргаад завгүй харагдана.

Би ар талын жижиг өрөөнд өрөөнд ороход Вингод Ники бялуу авчирсан гэж хэлэх гэтэл Винго Ковин хоёр хиймэл дагуулын талаар нэг англи залуутай утсаар ярьж байв. Тэд түргэн хоолны байр яаж яваад Макмүүн болсон тухай ярьж байв. Англи залуу ISEE-3-ын тухай асуухад Винго өөдөөс нь “Бид мэдээлэл авах гээд хүлээж байна. Бүх юм зүгээрээ” гэв.

Цаг 11.30 гээд цугларсан хүмүүс тайвширч эхэллээ. Хүмүүс кофе, пиво ууж, Касей Харпер ганцаараа компьютерийнхаа хажууд сууж байхыг хараад түүнтэй ярихаар очив. Тэр цэнхэр цамц, бариу жинс сандал өмссөн байлаа. Хэдийгээр 18-тай ч үнэхээр үзэсгэлэнтэй харагдана. Ганцаараа ийм олон залуустай ажиллах ямар байна гэж асуухад тэр “өнөөдөр сансрын салбарт эмэгтэй хүн ажиллах нь нээх сонин зүйл байхаа больсон” гэж яриагаа эхэллээ. “Манай ээж NASA-д, аав ч бас NASA болон “Lockheed Martin”-д ажилладаг байсан. Би хүүхэд байхаасаа механик ажиллагаа шаардсан зүйлд дуртай, юм задалж, буцаан угсрах дуртай. Бас их зурдаг байлаа. Голдуу телевизийн удирдлага их зурдаг байсан” гэв.

Түүнээс би эрчүүд чиний энэ эршүүд зангаас болж эмээдэг байсан уу гэж асуухад, “үгүй ээ” гэв. Тэгэхээр нь болзоход хэрхэн нөлөөлж байна гэхэд “би ахлах сургуульд байхдаа болздоггүй байжээ. Надад хүнтэй болзох сонирхол байгаагүй. Би маш биеэ даасан” гэж тасхийтэл хариуллаа.

Би түүнийг явахаас өмнө сансар судлалын инженер болох гэж байгаа юу гэж асуулаа. Тэр жинхэнэ гар хөл шиг хурдтай, уян хиймэл гар хөл зохион бүтээхийг хүсэж байгаагаа хэллээ. “Тахир дутуу хүмүүс хөгжмийн зэмсэг тоглож, бас зураг зурж чаддаг болохыг би хүсдэг. Миний хамгийн сайн найз нарын нэг нь гитар тоглодог байсан. Одоо хуруугаа таслаад тоглож чадахаа больсондоо маш их гуньдаг” гэв. Би Вингог эхнэртэйгээ ярьж байхыг харлаа. Би тэдэн дээр очоод ISEE-3 талаар асуутал тэр намайг энэ талаар Коллелуоригоос асуу гэв.

Коллелуори гадаа тамхилж байлаа. Би түүнтэй уулзах гээд гарахдаа ширээн дээр овоолсон төгсөлтийн сертификатуудыг анзаарав. Доод талд нь Винго болон Ковинын гарын үсэг байсан бөгөөд дээр нь янз бүрийн хүмүүсийн нэр бичээстэй байв. Тэр хүмүүс нь сертификатаа аваагүй байгаа бололтой.

Би Коллелуоригоос ISEE-3 хиймэл дагуулын талаар асуув. Тэр ажлаа тайлбарлаад “би тойрог замын хяналтын системийн инженер, тийм болохоор хиймэл дагуулын хөдөлгөөнийг хянах нь миний ажлын нэг хэсэг. Бид анх ISEE-3-ын хөдөлгөөнийг удирдаж эхлэхдээ их баярлаж байсан, яагаад вэ гэвэл түүнийг маш олон жил газраас удирдаж чадаагүй шүү дээ. Гэхдээ энэ бүх юм дууслаа гэсэн үг биш шүү. Би их сургуулийн бие даалтан дээр энэ хиймэл дагуулаас алдагдсан нитрогений талаар бичнэ ээ. Дизайн талаас нь харвал өөр шинийг гаргах боломжтой” гэв. Би дотогшоо орох гэтэл гэнэт хаалгаар баяр хөөр болсон бөөн хүмүүс шаагилдсаар гарч ирэв. Тэд байрны гадаа нэгдэн ойртон зогсов. Ковин хүмүүсийг зохион байгуулж “За одоо!” гэсэн комманд өгөхөд бүгд дээшээ тэнгэр лүү хараад хэн нэгэн хүн рүү мэндчилж байгаа мэт гараараа дохилоо.

Ковин хэдэн минут утсаараа бичлэг хийв. Удалгүй тэд тэнгэр лүү харан гараа өргөхөө болих аж. Ковин дахин “За одоо” гэхэд тэд дахин гараа өргөцгөөлөө. Санасандаа хүрээгүй хүмүүсийн хийдэг хөдөлгөөн юм болов уу гэж би бодлоо. ISEE-3-ыг дэлхийгээс удирдах ямар ч аргагүй болсон. Олон хүмүүсийн ажилласан урт хугацааны хөдөлмөр ингээд алга болов. Надад яг сүйт бүсгүй залуу хоёр нь ирээгүй хурим шиг л санагдлаа. Гэсэн ч хүмүүс партидсаар байв яагаад вэ гэвэл тэд хэдхэн хором ч гэсэн хэн хүний хийж чадахааргүй зүйлийг хийж чадсан учраас. Тэд ISEE-3-тай холбоо тогтоож чадсан шүү дээ. Тэд “захиа” бичихэд хиймэл дагуул хариу өгсөн. Миний баруун талд Зин нохойтойгоо гарч ирээд маш хурдан байшингийн араар алга болов.



## T.САНЧИН - 20Q

Түрүүч нь 74-р нүүрт

Хадгалчихсан. /инээв/

### Q5

PLAYBOY: Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Ц.Цэвэрбал таныг анх лигт хөтлөн оруулсан тухай ярилцлагаас чинь уншиж байсан юм байна. Хэрвээ тэр хүнтэй таараагүй бол сагсан бөмбөгийн спортод холбогдох байсан болов уу?  
T.САНЧИР: Яг өдий зэрэгтэй амжилт гаргахад Ц.Цэвэрбал багшийн минь ач гавьяа их байдаг. Сагсны ертөнцийн маш их зүйлийг надад зааж сургасан ачтай багш минь юмаа. Миний анхны багш маань Спортын мастер Мэндсайхан агсан. Цэвэрбал багштай нэг үед тоглож байсан монголын шилдэг сагсчин байсан. Энэ мундаг хүмүүсээр дамжиж сагсан бөмбөгийн гараагаа эхэлсэндээ дотроо маш их баяртай явдаг. Магадгүй анх Ц.Цэвэрбал багшийн Ёлууд багт орж гараагаа эхлээгүй бол өдий зэрэгтэй тамирчин болохгүй ч байсан байж магадгүй юм. Хүний амьдралын хувь тавилан гэж сонин шүү.

### Q6

PLAYBOY: Сагсан бөмбөг чамд юу өгсөн бэ?  
T.САНЧИР: Сагсан бөмбөг надад тэсвэр хатуужил, багаар ажиллах, үг сонсож сурах гээд л ер нь их зүйлийг өгсөн. Спорт хүнийг хүмүүжүүлдэг. Тухайн нөхцөлд хором ч алдах ёсгүй үед маш хурдан, зөв оновчтой шийдвэр гаргах чадвар олж авна. Хамт олон үгүй бол би ёстой хэн ч биш, маш сайхан дотно хамт олонтой болсон.

### Q7

PLAYBOY: Таныг хувийн тоглолттой гэж шүүмжилдэг хүмүүс байдаг? Энэ талаар өөрийн чинь бодлыг сонсмоор

байна?

T.САНЧИР: Хүмүүс тэгж ярьдаг. Багийн маань тоглолт нэг л болж өгөхгүй үе байдаг ш дээ тийм үед, эсвэл баг олон оноогоор хожигдож байгаа үед хувийн тоглолт үзүүлдэг. Хүмүүс янз бүрийн өнцгөөс л хардаг байх. Миний хувьд би хариуцлагаас айдаггүй. Баг хожигдвол би хариуцлага хүлээдэг. Яагаад гэвэл тухайн тоглолтын хувь заяа миний гарт байсан гэж үзэхийн бол багаа ялалтад хүргэж чадаагүй бол хариуцлагаа үүрэх ёстой.

### Q8

PLAYBOY: Манай сагсчдыг Азид нэлээн өөрөөр хүлээн авдаг болсон байхаа, яг талбай дээр тоглож байгаагийн хувьд мэдрэгддэг үү. Хааяа бие биеэ нудраад авах, ширүүн харах тохиолдол гардаг шүү дээ. Мартахааргүй дурсамжаасаа хуваалцаач  
T.САНЧИР: Манай улсын шигшээ багийг Азид анхааралдаа авсан л даа. Бусад орны баг бидний тоглолтыг бүгдийг нь бичлэг хийгээд авсан. Манайхтай тоглох тактикаа боловсруулж тоглодог болсон. Мартагдахааргүй явдал гэвэл Зүүн Азийн тэмцээн дээр намайг оноо тэнцүүлсэн шидэлт хийхэд манай багийн Билгүүн ирээд, хацар луу хорстол чанга алгадаад гүйгээд явчихлаа. Тэр үед тоглолт ид дундаа өрсөлдөөнтэй явж байсан болохоор яаж байнаа ч гэж хэлж амжаагүй. Тэгээд удалгүй завсарлагаар “Чи түрүүн яасан чанга алгадваа” гэж асуулаа. “Уучлаарай баярлаад арай чангадуулчихлаа” гэдэг юм. /инээв/  
Энэ мэтчилэн хөгжилтэй зүйлүүд зөндөө гардаг. Гадныхан манай багт хожигдоод ирэхлээрээ бас янз бүрийн ааш гарганаа. Юу юугүй хазах гэж байгаа юм шиг хор шар нь буцалсан юмнууд эргэн тойрноос дайраад л. /инээв/

### Q9

PLAYBOY: Монголын сагсан бөмбөгчдөөс хэнийг хүндэлж явдаг вэ?  
T.САНЧИР: Монгол Улсын гавьяат тамирчин М.Шаравжамц, ОУХМ Т.Түвшинбаяр, М.Отгонбаяр ах нарыг хүндэлдэг

### Q10

PLAYBOY: Сагсан бөмбөгийн ертөнцийн алдартай тамирчдаас хэний тоглолтыг үзэх дуртай вэ?

Т.САНЧИР: Коби Брайнт. Миний санал зөв гэдэгтэй олон хүн маргахгүй байхаа. Түүний тоглолтыг үзэх дуртай, өөртөө итгэлтэй шийдэмгий байдал нь надад маш их таалагддаг. Дээр нь бага зэрэг ихэмсэг зан гээд л тэр бүх талаараа мундаг тоглогч. Коби бол энэ үеийн домог шүү дээ.

## Q11

PLAYBOY: Азийн оюутны аварга шалгаруулах тэмцээнд оролцсон.

Энэ тэмцээний амжилтаасаа Т.САНЧИР: Энэхүү тэмцээнд 1 удаа ороод Здугаар байранд орж байсан. Эхний тоглолт Хон Конгын багийг хожиж. Дараа нь хятад болон Филиппиний багийг хожин 4-т үлдсэн. Тайванийн багт харамсалтай хожигдсон доо. Хүрлийн төлөө Филиппинтэй дахин учран хожиж байлаа.

## Q12

PLAYBOY: -Биеийн өндөр хэд вэ?

Т.САНЧИР: 190 см. Есдүгээр ангидаа 188 см өндөр байсан. Түүнээс хойш ердөө хоёр см өссөн юм байна.

## Q13

PLAYBOY: Сагсаар хичээллэж байгаа дүү нартаа ямар зүйлийг захих вэ

Т.САНЧИР: Анхлан суралцаж байгаа дүү нартаа хэлэхэд Цагаан толгойн үсэг шиг яг анхнаас нь зөв сайн багш дээр суралцах хэрэгтэй. Аливаа спортын нэгэн адил хөлний тавилт, шидэлт гээд бүгдийг зөв сурахгүй бол дараа нь засахад маш хэцүү, цаг хугацаа их алдана.

## Q14

PLAYBOY: Сагсан бөмбөгийн спортод чиний бодлоор юу дутагдаж байна вэ?

Т.САНЧИР: Одоо монголын сагсан бөмбөгийг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх шаардлагатай гэж бодож байна. Тэгж байж бусад орнуудтай ижил түвшинд өрсөлдөх боломж нээгдэх болов уу. Заал талбай дутмаг тал бий. Сагсны шинэ ордон баригдаж байгаад баяртай байгаа.

## Q15

PLAYBOY: Тамирчин хүн байнга л ялахгүй шүү дээ хожигдох үе байлгүй яхав. Хөгжөөн дэмжигчдийн урам хугараад хатуу хүтүү үг хэлэх үе гардаг шүү дээ ...

Т.САНЧИР: Тэгэлгүй яхав тамирчид

ялагдлаас их зүйл ойлгож дараагийн удаа ялдаг. Ялагдаж байж л тухайн тамирчин хөгжиж сайжирч байдаг. Хөгжөөн дэмжигчдээс зөндөө л дуу хоолой сонсогддог. Зарим нь хатуу ширүүн үг хэлдэг нөгөө хэсэг нь урмын үг хэлдэг тэр болгоноос бас л тамирчин өөртөө дүгнэлт хийдэг байхдаа.

## Q16

PLAYBOY: Сагсан бөмбөгөөс өөр спортоор хичээллэж байв уу?

Т.САНЧИР: Багадаа чөлөөт бөхөөр хэсэг хичээллэж байлаа. Дөрөвдүгээр ангидаа. Миний бөхийн дасгалжуулагч гавьяат тамирчин, алдарт бөх Д.Оюунболд гуай

## Q17

PLAYBOY: Татгалзахгүй бол гэр бүлээ манай уншигчдад танилцуулаач?

Т.САНЧИР: -Би эхнэр хүүхдийн хамт амьдардаг. Манай эхнэрийг Сарнай гэдэг. Бид оны өмнөхөн хүүтэй болсон. Их сургуулийн хоёрдугаар курст байхдаа танилцаж үерхсэн. Эхнэр маань манай доод үеийн охин байсан. Ээж маань телевизийн сэтгүүлч.

## Q18

PLAYBOY: Спорт бол залуу насны үйл. Сагсаа больвол юу хийх вэ, дасгалжуулагч хийх үү?

Т.САНЧИР: За тэр талаар хараахан нухацтай бодож байсангүй. Би Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийг дүүргэсэн. Спортын

хажуугаар мэргэжлээрээ ажилладаг. Дасгалжуулагч болох уу эсвэл өөрийн мэргэжлээрээ ажиллах эсэхийг тэр үед нь хариулж болох уу?

## Q19

PLAYBOY: Урлагт хэр дуртай вэ?

Т.САНЧИР: Би ер нь урлагт дуртай элэгтэй гэх үүдээ. Ялангуяа дуу хөгжимд илүү дуртай. Зав гарвал хөгжим сонсдог. Миний найз нөхдийн хүрээнд урлагийн авьяастай хүн олон шүү. Спорт урлаг хоёр хосолбол их сайхан. Гитар гэдэг хөгжимд сонирхолтой, сурах гэж маш их хичээж байгаа хэ хэ.

## Q20

PLAYBOY: Алдар нэртэй болох ямар байна?

Т.САНЧИР: Алдар нэр хүн болгонд л ирдэг, ээж ааваас заяасан, анд найз нөхдөөс, ард түмнээс гээд л. Мэдээж хүн болж төрснийх дуурсах алдартай, дуудах нэртэй байх сайхан. Гэхдээ олны хайр хүндэтгэлийг дааж хүлээж явна гэдэг бол хариуцлага хэцүү. Нэг ёсондоо буруу хазгай гишгэж явж болохгүй гэсэн үг. Гэхдээ би өөрийгөө жинхэнэ мундаг хүмүүстэй харьцуулахад юун нэр алдар байх вэ. Тодорхой хэмжээнд ялангуяа дүү нар, залуучууд хүндэлж байгаа гэж ойлгодог.

PLAYBOY: Манай сэтгүүлд цаг заваа хумслан ярилцлага өгсөнд баярлалаа. Аян замдаа сайн яваарай, шинэ багтаа амжилттай сайн тоглоорой.



МОНГОЛЫН САЙХАН ЭРЧҮҮДЭД ЗОРИУЛАВ

# PLAYBOY

MONGOLIA

ENTERTAINMENT FOR MEN

MARCH 2014



INTERVIEW: БЕРНИ САНДЕРС 20 АСУУЛТ: ЖЕЙМС ДИН

НҮЦГЭН БҮТЭЭЛ | ЯСАН ЦУГЛУУЛГА | ЯПОН БУРХАН | ЧИНИЙ ГЭР БОЛ ШОРОН | ШУНАЛТ БҮСГҮЙ  
МОСКВА - БЕРЛИН | ИТГЭЛ НАЙДВАРЫН БИЛЭГ ТЭМДЭГ | ТҮҮХЭН ДЭХ 10 АГУУ БАГУУД

ҮНЭ 10 000₮





Нимбэгийн амтат,  
Спиртийн агууламжгүй  
Шар айраг



GOOD, BETTER, PAULANER



# *Dream Doors*



Импортыг орлох  
Шинэ бүтээгдэхүүн  
Шилдэг технологи  
Төгс шийдэл

[WWW.MONHOUSE.MN](http://WWW.MONHOUSE.MN)

УТАС:70135878, 96615737  
E mail: [sales@monhouse.mn](mailto:sales@monhouse.mn)